



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.04.18 № 35-1/58  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
тухай**

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Л.ОЮУН-ЭРДЭНЭ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

20240417 № Х01/765  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт 16 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН

000245000268



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.04.15 № 1/1844  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД  
Х.БОЛОРЧУЛУУН ТАНАА**

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



**Б.ӨНХБАЯР**

1516013/0  
2024



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**


Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.04.16 № 01/2694  
танай 2024.03.29-ны № 01/1064 -т


**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
САЙД Х.БОЛОРЧУЛУУН ТАНАА**

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,



Б.ЖАВХЛАН



**9761000985**

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэлд:

**“6.ХЭЛЭЛЦСЭН нь:** Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:** Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдийн гаргасан саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



## **МАЛ, АМЬТНЫ ЭМ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийг шинээр батлан гаргах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

#### **1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна.” гэж заасан нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа төрийн бодлогын төвд байхыг тодорхойлсон суурь зарчим юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт, дунд хугацааны баримт бичгүүдэд мал эмнэлгийн талаарх бодлогын зорилтуудыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.1.12-т “Эмнэлгийн хэрэгсэл, эм, вакцин, биобэлдмэлийн үйлдвэрлэл, худалдаа, экспорт, импортод тавих стандартын шаардлага, хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлж, биотехнологийн цогцолбор байгуулах замаар чанар, аюулгүй байдлыг хангана.”, 3.4.2.5-д “Хүнсний түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, худалдаа-үйлчилгээ, хадгалалтын бүх үе шатуудад чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоог бий болгоно.”, 3.4.2.6-д “Мал эмнэлгийн тогтолцоог шинэчилж, малын халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг дээшлүүлж, халдвар, хамгаалал, биоаюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгоно.” гэж;

2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 8.3.18-д “Мал, амьтны өвчний гаралт, тархалтыг бууруулж, бүс, нутгийн түвшинд халдварт өвчнөөр тайван байдлыг баталгаажуулна.”, 8.3.19-д “Мал эмнэлгийн лабораторийн орчин үеийн оношилгоо, шинжилгээний дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлж, оношилгооны чадавхыг сайжруулна.”, 8.3.20-д “Эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай малын эм,

биобэлдмэлийг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.”, 8.3.21-д “Мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, бие даасан, нэгдмэл байдлыг хангах, мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжинэ.” гэж;

3. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 8.3.5-д “мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжинэ.” гэж;

4. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.8-д “Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ.” гэж;

5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.3.8.1-д “Биокомбинат үйлдвэрийн дэд бүтэц, үйлдвэрийн технологийг шинэчлэнэ”, 3.3.8.2-т “Малын эмч нарыг чадавхижуулж, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулна”, 3.3.8.6-д “Мал эмнэлэг, хүнсний аюулгүй байдлын лаборатори, чанарын дэд бүтцийг сайжруулах, чадавхижуулна” зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тус тус заасан.

## **1.2. Практик шаардлага**

Монгол Улсад хүний болон мал, амьтны зориулалттай эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 5 дугаар сарын 03-ны өдөр Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Уг хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх явцад өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнээс хальсан зарчмын зөрүүтэй саналууд гарсан тул Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлийн дагуу уг хуулийн төслийг Засгийн газар дахин боловсруулахаар 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдөр татан авсан.

Түүнчлэн хүний эмийн зохицуулалтын асуудлыг мал, амьтны эмийн хяналт, зохицуулалтаас тусад нь хуульчлах саналыг Эрүүл мэндийн сайдаас ирүүлсэн.

Аливаа улс орны мал эмнэлгийн алба нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, өвчин эмгэгтэй тэмцэх, эрт илрүүлэх, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах замаар нийтийн эрүүл мэндийг хамгаалах, гадаад, дотоод худалдааны чөлөөт байдлыг хангах үндсэн үүрэгтэй байдаг.

Нөгөө талаас Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны хувьд Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага /OIE/-аас батлан гаргасан стандарт, удирдамж, заавар, зөвлөмжид нийцүүлэн үндэсний бодлого, эрх зүйн орчныг өөрчлөх, шинээр боловсруулах үүрэг хүлээж байна.

Мал, амьтны эм, биобэлдмэл, оношлуур, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэлийн чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах, нянгийн тэсвэржилт үүсэх, мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүнд зөвшөөрөл олгох, импортлох, үйлдвэрлэх, бөөний болон жижиглэнгийн үнээр ханган нийлүүлэх, хэрэглэх, худалдаалах, устгах зохицуулалт зэрэг хүн, мал, амьтан, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах эрх зүйн үндсийг мал эмнэлгийн хууль тогтоомжоор тогтоохыг удирдамж болгодог.

Одоо мөрдөж байгаа Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд хүний эмнэлгийн зориулалттай эм, түүний дотор уламжлалт эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулсан бөгөөд мал эмнэлгийн зохицуулалт хавсарга байдлаар тусгагдсан нь учир дутагдалтай байна.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулан батлах дараах практик шаардлагууд байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын мал эмнэлгийн улсын байцаагч нарыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлсэн ч өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд мал, амьтны эм, биобэлдмэл, оношлуур, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон мал эмнэлгийн улсын байцаагчийн эрх, үүрэг зохицуулагдаагүй орхигдсон байна.

2. Мал, амьтны эм, биобэлдмэл, оношлуур, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэлийн үйлдвэрлэл, төрөл, тоо хэмжээ нэмэгдэж, орчин үеийн дэвшилтэт технологи нэвтэрч, эм, эмнэлгийн хэрэгслийн хүртээмж сайжирч байгаа хэдий ч мал эмнэлгийн практикт бичил биетний эсрэг эмийн тэсвэржилт, малын эмийн үлдэц, малын эмийн зохисгүй хэрэглээ үүсэх эрсдэл нэмэгдэж байгаа тул энэхүү асуудлыг тусгайлан зохицуулах шаардлагатай байна.

3. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад эмийн зохистой хэрэглээ ихээхэн чухал. Нэг талаас малчид, мал бүхий иргэн, аж ахуй нэгж өөрсдөө дур мэдэн эм хэрэглэх, хэт дөвийлгөн сурталчилж буруу мэдээлэл түгээх, мал эмнэлгийн эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм, бэлдмэлийг хэрэглэх зэрэг зөрчил гарсаар байна. Иймд эдгээр асуудлыг хуульчлан зохицуулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

4. Дэлхий дахинд эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хурдацтай хөгжиж байгаа нь мал эмнэлгийн эмчилгээ, оношилгооны шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, эмийн худалдаа, хангамж, эмийн бүртгэл, баталгаажуулалт, эмийн нэгдсэн цахим бүртгэлийг нэвтрүүлэх, эмийн зохистой хэрэглээ, төрөөс баримтлах зарчим, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хяналт, мал, амьтны эм,

эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эм, эмийн сангийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгох, төрийн хяналт шалгалт зэрэг тулгамдаж буй асуудлуудыг шинээр хуульчлан зохицуулах хэрэгцээ шаардлага байна.

Иймд дээр дурдсан бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилтуудыг хангах үүднээс Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийг шинээр боловсруулж, суурь зарчмын хүрээнд өөрчлөн шинэчлэх, ойлгомжтой бус, тодорхойгүй зохицуулалтуудыг бусад хууль тогтоомжтой уялдуулах, нэр томъёоны зөрүүг жигдлэх, олон улсын жишигт нийцсэн, практик шаардлагад тулгуурласан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулиар мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эм, мал, амьтны эмийн сангийн үйл ажиллагааг эрхлэх зэрэг зөвшөөрөл, бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдаа, хангамж, хэрэглээ, хяналт шалгалттай холбогдсон харилцааг зохицуулна.

Хуулийн төсөлд дараах асуудлыг зохицуулахаар тусгана. Үүнд:

1.Хуулийн зорилт, мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль тогтоомж, мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн талаар төрөөс баримтлах зарчим, нэр томъёоны тодорхойлолт зэргийг тусгана.

2.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн бүртгэл, мал, амьтны эмийн зөвлөл болон фармакопейн хорооны бүрэн эрх, мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн чанарын баталгаажуулалт, хаяглалт, түүнд тавигдах шаардлага, судалгаа, шинжилгээний зохицуулалтыг тусгана.

3.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хангамжийн байгууллага болон эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн үйлдвэр, импортлогч ханган нийлүүлэх байгууллага, мал, амьтны эмийн сан болон эдгээрт тавих нийтлэг шаардлага болон үйл ажиллагаанд нь хориглох зүйл, малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч иргэн, хуулийн этгээдэд мал, амьтны эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зохицуулалттай холбоотой харилцаанд хориглох зүйл, мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг улсын хилээр нэвтрүүлэх, мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг худалдах зөвшөөрөл олгохтой холбоотой зохицуулалтыг тусгана.

4.Мал, амьтны эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зохистой хэрэглээний зохицуулалтыг тодорхойлох бөгөөд бичил биетний

тэсвэржилтээс сэргийлэх, малын эмийн үлдцээс сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зэрэг зохицуулалтыг тусгана.

5. Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтэд төрөөс тавих хяналт шалгалтын зохицуулалтыг тусгана.

6. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн мэдээлэл болон зар сурталчилгаатай холбогдсон зохицуулалтыг тусгана.

7. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг заана.

**Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл батлагдсанаар эмийн зохицуулалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын үйл ажиллагааны болон хяналтын чиг үүрэг илүү тодорхой болж, эмийн чанар, аюулгүй байдал, хангамж сайжирч, хүнсний аюулгүй байдлыг хангахад төр болон хувийн хэвшлийн үүрэг хариуцлага нэмэгдэнэ.

Монгол Улс нь Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны хувьд олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, нийтийн эрүүл мэнд болон мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах бодлого, чиглэл, стратеги, үйл ажиллагааг тодорхойлсон эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Мал, амьтны гоц халдварт, халдварт, халдваргүй, шимэгчтэх, өвчнөөс урьдчилан болон эмчлэн сэргийлэх арга хэмжээний үр дүн сайржирч, мал, амьтны өвчний гаралт, тархалт, өвчлөл буурч хүн ам, мал, амьтны эрүүл мэндэд учруулах эрсдэл буурна.

Олон улсын өндөр шалгууртай зах зээл болон дотоодын зах зээлд мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг чөлөөтэй нийлүүлэх нөхцөл бүрдүүлснээр түүхий эд, бүтээгдэхүүнээс олох орлого нэмэгдэж малчдын амьжиргааны түвшин дээшилж, экспортын хэмжээ нэмэгдэнэ.

Хуулийн төсөлд шинээр бүтэц үүсгэх, байгууллага бий болгох зохицуулалт тусгагдаагүй бөгөөд хуулийн төсөл батлагдсанаар төсөв, санхүүгийн ямар нэгэн зардал гарахгүй.

**Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай,

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулна.

-----oOo-----

## МАЛ, АМЬТНЫ ЭМ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2024.04.01.

Манай улсын хөдөө аж ахуйн үйлдвэрлэл нь мянга мянган өрхийн амьжиргааны эх үүсвэр болж, орон нутгийн, улс орны эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг нь 2022 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д 13.1 хувийг, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт нь нийт экспортын орлогын 5.4 хувийг тус тус бүрдүүлж, нийт ажиллах хүчний 24.9 хувь нь тус салбарт ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд даяаршил, уур амьсгалын өөрчлөлт, гадаад, дотоод аялал жуулчлал, Мал, амьтан болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний экспорт, импорт, дотоод худалдааны өсөлт, хүн, мал, амьтны гадаад, дотоод шилжилт хөдөлгөөн зэрэг олон хүчин зүйлээс хамаарч халдварт өвчнүүд ихээр гарах болсон төдийгүй өмнө нь гарч байгаагүй өвчнүүд шинээр бүртгэгдэн хүн, мал, амьтны эрүүл мэнд, нийгэм эдийн засагт сөргөөр нөлөөлж байна.

Мөн бичил биетний тэсвэржилт (ББТ) нь хүн, мал амьтан, ургамлын эрүүл мэнд болон хүнс, хүрээлэн буй орчинд нөлөөлдөг, дэлхий нийтийн анхаарал татах болсон. Хүн, мал амьтны эмийн бүтцэд нийтлэг ордог бичил биетний эсрэг нэгдлүүдэд тэсвэртэй болох явдал дэлхийн анагаах ухаан, мал эмнэлгийн салбарт аль алинд нь өсөн нэмэгдэж байна. Ялангуяа нянгийн тэсвэржилт дэлхийн нийтийн эрүүл мэндэд үнэхээр томоохон аюул занал учруулах эрсдэл болоод байна.

Мал, амьтнаас хүнд халдварладаг өвчнийг зооноз гэх бөгөөд дэлхий дээр 1500 орчим хүний халдварт өвчин бүртгэгдсэний 60% нь зооноз өвчин байна. Жил бүр хүний 4-5 халдварт өвчин шинээр бүртгэгдэж байгаагаас 3-4 нь буюу 75-80 % нь амьтнаас хүнд халдварлаж (зооноз өвчин) байгааг судалгаагаар тогтоосон. Нийт зооноз өвчний 60%, сүүлийн 20 жилд шинээр бүртгэгдсэн зооноз өвчний 80% нь вирусээр үүсгэгддэг байна.

Монгол Улсад хүний болон мал, амьтны зориулалттай эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулж байна.

Эмийн тухай хууль нь 1998 онд батлагдаж, 2006 онд нэмэлт, өөрчлөлт оруулж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болгосон бөгөөд 2010 онд тус хуулийг шинэчлэн найруулснаас хойш нийтдээ 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан хэдий ч зарчмын хувьд мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн талаарх зарчмын суурь зохицуулалт, хяналт шалгалтын талаар бүрэн тусгагдаагүй билээ.

Түүнчлэн Монгол Улс 1989 онд Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-д, 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элссэн бөгөөд гишүүн орны хувьд дээрх байгууллагуудын батлан гаргасан стандарт, удирдамж, заавар, зөвлөмжид нийцүүлэн үндэсний бодлого, хууль тогтоомжийг өөрчлөх, шинээр боловсруулах үүрэг хүлээсэн байдаг.

Дээрх олон улсын байгууллагууд нь мал, амьтны эмийн бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах, нянгийн тэсвэржилт үүсэх, мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүнд зөвшөөрөл олгох, импортлох, үйлдвэрлэх, бөөний болон жижиглэнгийн үнээр ханган нийлүүлэх, хэрэглэх, худалдаалах, аюулгүй байдлаар үр дүнтэй устгах зохицуулалт зэрэг хүн, мал, амьтан, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах эрх зүйн үндсийг мал эмнэлгийн хууль тогтоомжоор тогтоохыг удирдамж болгодог билээ.

Одоо мөрдөж байгаа Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд хүний эмнэлгийн зориулалттай эм, түүний дотор уламжлалт эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулалтыг нарийн тусгагдсан бөгөөд мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зохицуулалт дүйцүүлэх байдлаар тусгагдсан нь учир дутагдалтай зохицуулалттайгаар хэрэгжүүлж ирсэн.

Иймд Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 5 дугаар сарын 03-ны өдөр Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Уг хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх явцад өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнээс хальсан зарчмын зөрүүтэй саналууд гарсан тул Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 28 дугаар хуралдааны тэмдэглэлийн дагуу уг хуулийн төслийг Засгийн газар дахин боловсруулахаар 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдөр татан авсан.

Түүнчлэн хүний эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын асуудлыг мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн бүртгэл, баталгаажуулалт, хяналт, зохицуулалтаас тусад нь хуульчлах саналтай байгааг Эрүүл мэндийн сайдын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 1а/957 албан бичгээр ирүүлсэн.

Дэлхий дахинаа мал, амьтны эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хурдацтай хөгжиж байгаа нь мал, амьтны өвчний оношлогоо, эмчилгээний шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, эмийн худалдаа, хангамж, эмийн бүртгэл, баталгаажуулалт, эмийн нэгдсэн цахим бүртгэлийг нэвтрүүлэх, эмийн зохистой хэрэглээ, төрөөс баримтлах зарчим, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн хяналт, зохицуулалт мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл олгох, хяналт шалгалт зэрэг хууль, эрх зүйн зохицуулалтыг цогцоор нь тусгах хэрэгцээ шаардлага бий болоод байна.

Иймд мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, ариутгалын бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл, бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдаа, хангамж, хэрэглээ, хяналт шалгалттай холбогдсон харилцааг зохицуулахаар Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийг 7 бүлэг, 24 зүйлтэйгээр Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомж, батлагдсан үзэл баримтлалд нийцүүлж, Засгийн газрын

хуралдаанд хэлэлцүүлж, Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган боловсрууллаа.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулсан болно.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

## МАЛ, АМЬТНЫ ЭМ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

2024.04.01.

Аливаа улс орны мал эмнэлэг нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, өвчин эмгэгтэй тэмцэх, эрүүлжүүлэх, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах замаар нийтийн эрүүл мэндийг хамгаалах, гадаад, дотоод худалдаанд үүссэн хориг саадыг арилгахад чухал үүрэг гүйцэтгэдэг билээ.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, бичил биетний хувьсал, олон улсын худалдаанд тавигдаж буй хориг, шинээр болон дахин сэргэж буй хил дамнан тархах эрсдэлтэй өвчнүүдийн дэгдэлт зэрэг дэлхийн хэмжээний томоохон асуудлуудтай холбоотойгоор мал эмнэлгийн байгууллага урд өмнөхөөс илүү хүнд сорилтуудтай тулгарсаар байна.

Монгол Улсад хүний болон мал, амьтны зориулалттай эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулж ирсэн.

Эмийн тухай хууль нь 1998 онд батлагдаж, 2006 онд нэмэлт, өөрчлөлт оруулж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болгосон бөгөөд 2010 онд тус хуулийг шинэчлэн найруулснаас хойш нийтдээ 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үүнд:

- 2011 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр;
- 2012 оны 08 дугаар сарын 17-ний өдөр;
- 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр;
- 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр;
- 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр;
- 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр;
- 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр;

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна” гэж заасан нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа төрийн бодлогын төвд байхыг тодорхойлсон суурь зарчим юм.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон 2020 онд шинэчлэн батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдэд мал эмнэлгийн талаарх бодлогын зорилтуудыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.1.12-т “Эмнэлгийн хэрэгсэл, эм, вакцин, биобэлдмэлийн үйлдвэрлэл, худалдаа, экспорт, импортод тавих стандартын шаардлага, хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлж, биотехнологийн цогцолбор байгуулах замаар чанар, аюулгүй байдлыг хангана.”, 3.4.2.5-д “Хүнсний түүхий эд бэлтгэл, үйлдвэрлэл, худалдаа-үйлчилгээ, хадгалалтын бүх үе шатуудад чанарын удирдлага,

хяналт, баталгаажуулалтын нэгдмэл тогтолцоог бий болгоно.", 3.4.2.6-д "Мал эмнэлгийн тогтолцоог шинэчилж, малын халдварт өвчинтэй тэмцэх чадавхийг дээшлүүлж, халдвар, хамгаалал, биоаюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгоно." гэж;

2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 8.3.18-д "Мал, амьтны өвчний гаралт, тархалтыг бууруулж, бүс, нутгийн түвшинд халдварт өвчнөөр тайван байдлыг баталгаажуулна.", 8.3.19-д "Мал эмнэлгийн лабораторийн орчин үеийн оношилгоо, шинжилгээний дэвшилтэт арга, технологийг нэвтрүүлж, оношилгооны чадавхыг сайжруулна.", 8.3.20-д "Эмчилгээний өндөр идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай малын эм, биобэлдмэлийг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.", 8.3.21-д "Мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, бие даасан, нэгдмэл байдлыг хангах, мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжинэ." гэж;

3. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 8.3.5-т "мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжинэ." гэж;

4. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 3.3.8-д "Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ." гэж;

5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 3.3.8.1-д "Биокомбинат үйлдвэрийн дэд бүтэц, үйлдвэрийн технологийг шинэчлэнэ", 3.3.8.2-д "Малын эмч нарыг чадавхижуулж, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулна", 3.3.8.6-д "Мал эмнэлэг, хүнсний аюулгүй байдлын лаборатори, чанарын дэд бүтцийг сайжруулах, чадавхижуулна" гэж тус тус заасан байна.

Монгол Улс 1989 онд Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (ДМАЭМБ)-д, 1997 онд Дэлхийн худалдааны байгууллагад гишүүнээр элссэн бөгөөд гишүүн орны хувьд дээрх байгууллагуудын батлан гаргасан стандарт, удирдамж, заавар, зөвлөмжид нийцүүлэн үндэсний бодлого, хууль тогтоомжийг өөрчлөх, шинээр боловсруулах үүрэг хүлээсэн байдаг.

Малын эмнэлгийн эмийн бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах, нянгийн тэсвэржилт үүсэх, мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүнд зөвшөөрөл олгох, импортлох, үйлдвэрлэх, бөөний болон жижиглэнгийн үнээр ханган нийлүүлэх, хэрэглэх, худалдаалах, аюулгүй байдлаар үр дүнтэй устгах зохицуулалт зэрэг хүн, мал, амьтан, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах эрх зүйн үндсийг мал эмнэлгийн хууль тогтоомжоор тогтоохыг удирдамж болгодог билээ.

Одоо мөрдөж байгаа Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд хүний эмнэлгийн зориулалттай эм, түүний дотор уламжлалт эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох,

хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулалтыг нарийн тусгагдсан бөгөөд мал эмнэлгийн зохицуулалт дүйцүүлэх байдлаар тусгагдсан нь учир дутагдалтай зохицуулсан.

Мөн дараах зохицуулалт огт тусгагдаагүй байна. Үүнд:

1.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын мал эмнэлгийн улсын байцаагч нарыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлсэн ч өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн эрх үүрэг зохицуулагдаагүй байгаа нь үйл ажиллагааны хийдлийг үүсгэх эрсдэл бий болгож байна.

2.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн үйлдвэрлэл, төрөл, тоо хэмжээ нэмэгдэж, орчин үеийн дэвшилтэт технологи нэвтэрч, эм, эмнэлгийн хэрэгслийн хүртээмж сайжирч байгаа хэдий ч мал эмнэлгийн практикт бичил биетний эсрэг эмийн тэсвэржилт, малын эмийн үлдэц, малын эмийн зохисгүй хэрэглээ үүсэх эрсдэл нэмэгдэж байгаа тул зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байна.

3.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад эмийн зохистой хэрэглээ ихээхэн чухал. Нэг талаас малчид, мал бүхий иргэн, аж ахуй нэгж өөрсдөө дур мэдэн эм хэрэглэх, хэт дөвийлгөн сурталчилж буруу мэдээлэл түгээх, мал эмнэлгийн эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг хэрэглэх зэрэг зөрчил гарсаар байна. Иймд эдгээр асуулдыг хуульчлах эрх зохицуулалт зайлшгүй шаардлага тулгарч байна.

Дэлхий дахинаа эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хурдацтай хөгжиж байгаа нь мал эмнэлгийн эмчилгээ, оношилгооны шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, эмийн худалдаа, хангамж, эмийн бүртгэл, баталгаажуулалт, эмийн нэгдсэн цахим бүртгэлийг нэвтрүүлэх, эмийн зохистой хэрэглээ, төрөөс баримтлах зарчим, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн хяналт, зохицуулалт, мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, оношлуур, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл олгох, төрийн хяналт шалгалт зэрэг хууль, эрх зүйн зохицуулалтыг цогцоор нь тусгах хэрэгцээ бий болоод байна.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөлд мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл, бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдаа, хангамж, хэрэглээ, хяналттай холбогдсон харилцааг зохицуулахаар тусгалаа.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай тухай хуулийн төсөл 7 бүлэг, 24 зүйлтэй байна. Үүнд:

### Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэлийг тодорхойлох:

Энэхүү бүлэгт хуулийн зорилт, мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль тогтоомж, төрөөс баримтлах зарчим, нэр томьёоны тодорхойлолт зэргийг тусгав.



Хуулийн зорилтыг мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл, бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдаа, хангамж, хэрэглээ, хяналттай холбогдсон харилцааг зохицуулахаар тодорхойлов.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэхээр заалаа.

Түүнчлэн Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөхөөр заасан.

Төрөөс мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн талаар баримтлах зарчмыг дараах байдлаар хуулийн төсөлд тодорхойлсон. Үүнд:

- Мал эмнэлгийн эм зүйн салбарын ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, эмийн зохицуулалтын цогц тогтолцоог бэхжүүлэх;
- Эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтээр жигд, хүртээмжтэй, тогтмол хангах;
- Мал эмнэлгийн эм зүйн салбарын үйл ажиллагааг судалгаа, нотолгоонд тулгуурлан явуулж, хөгжлийн чиг хандлагыг оновчтой тодорхойлох;
- Мал эмнэлгийн эм зүйн салбарыг мэргэшсэн, ур чадвартай хүний нөөцөөр тогтвортой хангах;
- Мал эмнэлгийн эм хангамжийн байгууллагад үйлдвэрлэлийн болон лабораторийн зохистой дадлыг үе шаттайгаар нэвтрүүлэх;
- Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжих.

Мөн энэ хуульд хэрэглэгдэг нэр томьёог илүү ойлгомжтой болгохоор тайлбарт 19 нэр томьёоны тодорхойлолтыг гарган, үүнээс шинээр "ерөнхий нэршлийн эм", "эмийн олон улсын нэршил", "эмийн худалдааны нэршил", "бичил биетний тэсвэржилт", "бичил биетний эсрэг эм", "тэжээлийн нэмэлт" зэрэг нэр томьёог тодорхойлж тусгав.

Хоёрдугаар бүлэг. Мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн бүртгэл, баталгаажуулалт:

Энэхүү бүлэгт мал, амьтны эмийн зөвлөл болон фармакопейн хорооны бүрэн эрх, мал, амьтны эм, биобэлдмэл, оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн бүртгэл, мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн чанарын баталгаажуулалт, мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн хаяглалт, түүнд тавигдах шаардлага, мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн судалгаа, шинжилгээний зохицуулалтыг тусгалаа.

Төрөөс мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн талаар баримталж буй бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий орон тооны бус мал, амьтны эмийн зөвлөл болон фармакопейн хороог Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллахаар тусгалаа.

Энэ хүрээнд мал, амьтны эм, тэжээлийн нэмэлт, эмийн түүхий эдийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах, шинээр зохион бүтээсэн мал, амьтны эм, тэжээлийн нэмэлт, эмийн түүхий эдийн сорилын ба эмнэлзүйн эм судлалын судалгаа, туршилтын дүнг хэлэлцэн шийдвэр гаргах, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зориулалттай эм, тэжээлийн нэмэлтийг сонгох асуудлаар санал, зөвлөмж боловсруулах, анх удаа импортлон бүртгүүлж байгаа мал, амьтны эм, биобэлдмэлд эмнэл зүйн туршилт хийх шаардлагатай эсэхийг хэлэлцэх эрх үүргийг тусгалаа.

Түүнчлэн мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн талаар төрөөс баримталж буй бодлогын асуудлаар санал, зөвлөмж боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий хангамжийн байгууллагын жилийн тайланг хэлэлцэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, мал, амьтны эмийн сэрэмжлүүлэг, аюулгүй байдал, болзошгүй эрсдэлийн асуудлаар мэргэжлийн зөвлөмж гаргах, мал, амьтны эмийн фармакопейн хорооны жилийн тайланг хэлэлцэж, зөвлөмж өгөхөөр тодорхойлов.

Мөн мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг мал, амьтны эмийн бүртгэлд бүх төрлийн урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зориулалттай эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, тун, хэлбэр, савлагаа, найрлага, хэрэглэх заавар болон үйлдвэрлэлийн технологид өөрчлөлт орсон эм, тэжээлийн нэмэлт, олон улсын зээл, тусламжаар импортлох эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн эмчилгээний тун бүхий амин дэм, эмийн эмчилгээг дэмжих, сэргийлэх зориулалттай бэлдмэлүүдийг бүртгэхээр тусгасан.

Харин эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн бүртгэлийн дээж, судалгаа, шинжилгээний ажил, эмнэлзүйн туршилтад хэрэглэх эм, үзэсгэлэн худалдаанд оролцуулах эм, эмийн туслах бодис, цацраг идэвхт бодис, тэдгээрийн бэлдмэл, химийн урвалж болон бүх төрлийн тэжээлт орчин, лабораторийн зориулалтаар хэрэглэгдэх будаг зэргийг мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт бүртгэлд хамааруулахгүйгээр тусгасан.

Мал, амьтны эмийн бүртгэлд Мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч, импортлогч, хэлбэр, тун, зориулалтыг зааж 5 жилийн хугацаатайгаар бүртгэхээр заасан.

Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн бүртгэл, мэдээллийн цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөхөөр тусгасан.

Мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн чанарын баталгаажуулалтыг Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын лаборатори хийх чиг үүргийг нарийвчлан тусгаж өгсөн.

Мал, амьтны эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн сав, баглаа боодол, шошго, хаяглалт, тэмдэглэгээ, хэрэглэх зааварт агуулагдах мэдээллийг нарийвчлан тусгасан.

Мал, амьтны эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь эрдэм шинжилгээний ажлыг гэрээ, захиалгаар гүйцэтгүүлэх, үр дүнг нэвтрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах эрх зүйн зохицуулалтыг тусгасан.

Гуравдугаар бүлэг. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн худалдаа, хангамж, зөвшөөрөл:

Энэхүү бүлгээр мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хангамжийн байгууллага, мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн үйлдвэр, мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг ханган нийлүүлэх байгууллага, мал, амьтны эмийн сан, малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч иргэн, хуулийн этгээдэд хориглох зүйл, мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг улсын хилээр нэвтрүүлэх, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн хяналт, зохицуулалт, мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл олголтын зохицуулахаар тусгав.

Энэ бүлэгт малын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтээр мал эмнэлгийн байгууллагыг хүртээмжтэй хангах хангамийн байгууллагуудыг дараах байдлаар тусгасан.

1. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн үйлдвэр;
2. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг ханган нийлүүлэх байгууллага;
3. Мал, амьтны эмийн сан;

Эдгээр хангамжийн байгууллагад тавих нийтлэг шаардлага, хориглох үйл ажиллагааг нарийвчлан тусгасан.

Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч иргэн, хуулийн этгээдэд дараах зүйлийг хориглоно:

1. Хуурамч, бүртгэлд ороогүй, чанарын баталгаагүй, хүчинтэй хугацаа дууссан эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг дур мэдэн худалдан авах, хэрэглэх;
2. Зориулалтын бус газарт эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, эмийн түүхий эдийг хадгалах;
3. Мал, амьтныг дархлаажуулах биобэлдмэл, жороор олгох эмийг малын эмчийн зөвшөөрөлгүй мал, амьтанд хэрэглэх.

Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг Засгийн газар тогтоохоор тусгасан.

Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг импортлох, экспортлоход мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас энгийн зөвшөөрөл авахаар заасан.

Мөн мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг импортлох, экспортлоход хориглох зүйлийг тусгасан.

Түүнчлэн тусламж, хандиваар мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн шаардлага, импортлох, экспортлоход хориглох зраицуулалтыг нарийвчлан тусгав.

Дөрөвдүгээр бүлэг. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн зохистой хэрэглээ:

Энэхүү бүлэгт Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх, малын эмийн үлдцээс сэргийлэх, мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн зохистой хэрэглээний зохицуулалтыг тусгасан.

Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх, малын эмийн үлдцээс сэргийлэх тэсвэржсэн бичил биетэн болон малын эмийн үлдцийг илрүүлэх, хянах үйл ажиллагаа нь эрсдэлийн үнэлгээнд суурилан олон улсын жишгийн дагуу тандалт шинжилгээг итгэмжлэгдсэн лаборатори хэрэгжүүлэх зохицуулалтыг тусгасан.

Түүнчлэн жороор олгох мал, амьтны эмийн жагсаалт болон мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн жагсаалтыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга жил бүр шинэчлэн батлан, мөрдөх зохицуулалтыг тусгалаа.

Мал, амьтанд хэрэглэсэн эмийн гаж нөлөө болон бичил биетний тэсвэржилт, мал, амьтны биед үлдэц үүсгэдэг эм, бэлдмэлийн мэдээллийг сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг бүртгэх, мал, амьтны эмийн зохистой хэрэглээг хэвшүүлэх сургалт, сурталчилгааг мал эмнэлгийн байгууллагууд харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах чиг үүргийг заасан.

Тавдугаар бүлэг. төрийн хяналт шалгалт:

Энэхүү бүлэгт Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтэд тавих хяналт шалгалтын зохицуулалтыг тусгасан.

Энэ бүлэгт мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хяналт шалгалтыг аймаг, нийслэл, сум, дүүрэгт мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, хил дээр ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид хэрэгжүүлэхээр тусгасан.

Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчын мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн талаар гарсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын биелэлтэд хяналт тавих эрх, үүргийг тусгасан.

Зургаадугаар бүлэг: Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зар сурталчилгааны зохицуулалтыг тусгав.

Долоодугаар бүлэг. Бусад зүйл: Төгсгөлийн бүлэгт хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тус тус заасан.

Уг хуулийн төсөлтэй уялдуулан Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулав. Үүнд:

1. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: “11.1.4.Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалтад багтсан өвчтнтэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг оролцогч талууд хамтран санхүүжүүлж болно.” гэсэн эрх зүйн зохицуулалтыг нэмсэн. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 24, 25, 26 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 28.11, 28.12, 28.13 дахь хэсгийн Мал, амьтны эмийн зохистой хэрэглээг нэвтрүүлэх, хянах, Мал, амьтны тэжээлийн нэмэлтийн хяналт, Мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх эм, пестицидийн үлдэгдлийн хяналт, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд мал, амьтны эмийн бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хянах үүрэг бүхий орон тооны бус малын эмийн салбар зөвлөл, фармакопейн хорооны зохицуулалтыг мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөлд тусгахаар тусгалаа. Мөн “4.1.16.“тэжээлийн нэмэлт” гэж Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 4.1.5-д заасныг;” гэж өөрчлөн найруулж, хуулийн дагаж мөрдөх хугацааг заасан.

2. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлд: Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай” гэж нэмсүгэй.” гэж нэмэх, хуулийн дагаж мөрдөх хугацааг заасан.

3. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлд: Зөрчлийн тухай хуульд “13.10 дугаар зүйл. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль зөрчих” нэмж зөрчлийн зүйл заалтыг томъёолж, хуулийн дагаж мөрдөх хугацааг заасан.

4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлд: Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.11 дэх заалтын “10.3 дугаар зүйлийн 1.1 дэх заалт,” гэсний дараа “10.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг” гэж нэмэхээр, мөн хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.44 дэх заалтын “13.9 дүгээр зүйл”

гэснийг “13.9, 13.10 дугаар зүйл,” гэж өөрчлөлт оруулан, хуулийн дагаж мөрдөх хугацааг заасан.

5. Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд: Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн гарчгийн “Эрүүл мэндийн” гэсний дараа “мал эмнэлгийн” гэж нэмж, хуулийн дагаж мөрдөх хугацааг заасан.

6. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: “4.1.11.“мал, амьтны эмийн үлдэц” гэж мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, тэдгээрийн малын биед орж хувирсан нэгдлийн үлдэгдлийг;” гэж өөрчлөн найруулах, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын “малын эм, биобэлдмэлийн” гэснийг “мал, амьтны эмийн үлдэц” гэж өөрчилж, хуулийн дагаж мөрдөх хугацааг заасан.

7. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд: Хуулийн төслийг 3 зүйлтэйгээр боловсруулсан багаад 1 дүгээр зүйлд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “хүн, мал, амьтанд” гэснийг “хүнд” гэж, мөн зүйлийн 3.1.14 дэх заалтын “хүн болон мал, амьтанд” гэснийг “хүнд” гэж, мөн зүйлийн 3.1.23 дахь заалтын “байгууллага болон мал эмнэлгийг” гэснийг “байгууллагыг” гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн “болон малын эмийн зөвлөл хамтран хуралдаж” гэснийг “эмийн зөвлөл” гэж, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “бүртгэх бөгөөд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 11.4-т заасан зөвшөөрлийг олгоно.” гэснийг “бүртгэнэ.” гэж, мөн зүйлийн 15.5 дахь хэсгийн “гишүүн болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын” гэснийг “гишүүний” гэж тус тус өөрчлөхөөр, 2 дугаар зүйлд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “болон мал эмнэлгийн зориулалттай” гэснийг, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай” гэснийг, 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.5, 3.1.18 дахь заалтын “болон мал, амьтны” гэснийг, мөн зүйлийн 3.1.14 дэх заалт, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “болон хөдөө аж ахуйн” гэснийг, мөн зүйлийн 3.1.24 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.2, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “мал эмнэлэг” гэснийг, 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтын “холбогдох” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд малын эмийн асуудал хариуцсан зөвлөл” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “Мал, амьтны тэжээлийн нэмэлт, эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлоход мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.” гэснийг, мөн зүйлийн 15.7, 15.8, 22 дугаар зүйлийн 22.6, 23 дугаар зүйлийн 23.3, 23.4 дэх хэсгийн “болон хөдөө аж ахуйн” гэснийг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “болон мал эмнэлгийн зориулалтаар хэрэглэх” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1.3 заалтын “холбогдох” гэснийг тус тус хасахаар, Хуулийн төслийн 3 дугаар зүйлд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.5, 7.6, 7.7, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 15<sup>1</sup> дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг, мөн зүйлийн 16.5.2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцохоор, хуулийн төслийн 4 дүгээр зүйлд Энэ хуулийг дагаж мөрдөх хугацааг заасан болно.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд нийцүүлсэн болно. Хуулийн төсөлд шинээр байгууллага байгуулах, шинэ албан тушаал бий болгох заалт оруулаагүй бөгөөд хуулийг баталсны дараа нийгэм эдийн засаг, хууль зүйн сөрөг үр дагавар үүсэхгүй гэж үзэж байна.

Хууль батлагдснаар мал, амьтны эмийн зохицуулалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын чиг үүрэг, хяналтын үүрэг илүү тодорхой болж, эмийн чанар, аюулгүй байдал, хангамж сайжирч, хүнсний аюулгүй байдлыг хангахад төр болон хувийн хэвшлийн үүрэг хариуцлага нэмэгдэнэ.

Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн худалдааны байгууллага болон бусад олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, мал, амьтны болон нийтийн эрүүл мэндийг хамгаалах бодлого, чиглэл, стратеги, үйл ажиллагааг тодорхойлсон эрх зүйн орчинг бүрдэнэ.

Мал, амьтны гоц халдварт, халдварт, халдваргүй, шимэгчтэх, өвчнөөс урьдчилан болон эмчлэн сэргийлэх арга хэмжээний үр дүн сайржирч, мал, амьтны өвчний гаралт, тархалт, өвчлөл буурч хүн ам, мал, амьтны эрүүл мэндэд учруулах эрсдэл буурна.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

**МАЛ, АМЬТНЫ ЭМ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

2024 оны ....дугаар  
сарын .... -ны өдөр

Улаанбаатар  
хот

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл, бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдаа, хангамж, хэрэглээ, хяналттай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль тогтоомж**

2.1.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Хэмжил зүйн тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн талаар төрөөс баримтлах зарчим**

3.1.Төрөөс мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн талаар дараах үндсэн зарчмыг баримтална:

3.1.1.мал эмнэлгийн эмийн салбарын ил тод, нээлттэй, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, эмийн зохицуулалтын цогц тогтолцоог бэхжүүлэх;

3.1.2.эм, эмнэлгийн хэрэгслээр хүртээмжтэй тогтвортой хангах;

3.1.3.мал эмнэлгийн эмийн салбарын үйл ажиллагааг судалгаа, нотолгоонд тулгуурлан явуулж, хөгжлийн чиг хандлагыг оновчтой тодорхойлох;

3.1.4.мал эмнэлгийн эмийн салбарыг мэргэшсэн, ур чадвартай хүний нөөцөөр тогтвортой хангах;

3.1.5.мал эмнэлгийн эм хангамжийн байгууллагад зохистой дадлыг нэвтрүүлэх;

3.1.6.мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн үндэсний үйлдвэрлэлийг дэмжих.

#### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."эм" гэж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3.1.1-д заасныг;

4.1.2."биобэлдмэл" гэж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3.1.2-т заасныг;

4.1.3."ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл" гэж бичил биетнийг идэвхгүйжүүлэх, устгах нийтлэг болон сонгомол үйлчилгээтэй дан болон нийлмэл бүтээгдэхүүнийг.

4.1.4."тэжээлийн нэмэлт" гэж мал, амьтны бие махбодын үйл ажиллагааг дэмжих, зохицуулах үйлчилгээ бүхий дан болон олон найрлагат бэлдмэлийг;

4.1.5."оношлуур" гэж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3.1.4-т заасныг;

4.1.6."эмийн түүхий эд" гэж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3.1.9-д заасныг;

4.1.7."эмийн гол үйлчлэгч бодис" гэж тухайн эмийн үйлдлийг нөхцөлдүүлэгч дан ба нийлмэл бүрэлдэхүүнтэй биологийн идэвхт нэгдлийг;

4.1.8."эмийн туслах бодис" гэж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3.1.10-т заасныг;

4.1.9."эм барих" гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.12-т заасныг;

4.1.10."цуврал" гэж үйлдвэрлэлийн технологийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэгдсэн багцын тоо хэмжээг;

4.1.11."мал, амьтны эмийн бүртгэл" гэж эм зүй, эм судлалын ба бусад судалгааны үндсэн дээр урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээнд хэрэглэж болох нь нотлогдсон эмийн чанар аюулгүй байдал, үр нөлөөг хянах, Монгол Улсын хэмжээнд хэрэглэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг;

#### **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

#### **МАЛ, АМЬТНЫ ЭМ, ЭМИЙН ТҮҮХИЙ ЭД, АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БЭЛДМЭЛ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН БҮРТГЭЛ, БАТАЛГААЖУУЛАЛТ**

#### **5 дугаар зүйл.Мал, амьтны эмийн зөвлөл болон фармакопейн хороо**

5.1.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд төрөөс мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн талаар баримталж буй бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий орон тооны бус мал, амьтны эмийн зөвлөл болон фармакопейн хороо ажиллана.

5.2.Мал, амьтны эмийн зөвлөл болон фармакопейн хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий албан тушаалтан Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ажиллана.

5.3.Мал, амьтны эмийн зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.3.1.мал, амьтны эм, тэжээлийн нэмэлт, эмийн түүхий эдийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах;

5.3.2.шинээр зохион бүтээсэн мал, амьтны эм, тэжээлийн нэмэлт, эмийн түүхий эдийн сорилын ба эмнэлзүйн эм судлалын судалгаа, туршилтын дүнг хэлэлцэн шийдвэр гаргах;

5.3.3.урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зориулалттай эм, тэжээлийн нэмэлтийг сонгох асуудлаар санал, зөвлөмж боловсруулах;

5.3.4.Монгол Улсад анх удаа импортлон бүртгүүлж байгаа мал, амьтны эм, биобэлдмэлд эмнэл зүйн туршилт хийх шаардлагатай эсэхийг хэлэлцэх;

5.3.5.мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн талаар төрөөс баримталж буй бодлогын асуудлаар санал, зөвлөмж боловсруулж, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

5.3.6.~~тусгай зөвшөөрөл бүхий~~ хангамжийн байгууллагын жилийн тайланг хэлэлцэх, дүгнэлт, зөвлөмж гаргах;

5.3.7.мал, амьтны эмийн сэрэмжлүүлэг, аюулгүй байдал, болзошгүй эрсдэлийн асуудлаар мэргэжлийн зөвлөмж гаргах;

5.3.8.мал, амьтны эмийн фармакопейн хорооны жилийн тайланг хэлэлцэж, зөвлөмж өгөх.

5.4.Мал, амьтны эмийн зөвлөлийн ажиллах журам, зөвлөлийн бүрэлдэхүүнийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.5.Мал, амьтны эмийн фармакопейн хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.5.1.мал эмнэлгийн үндэсний ба үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүллийг хэлэлцэн батлах;

5.5.2.фармакопейн өгүүлэлд дугаар олгох;

5.5.3.фармакопейн өгүүллийн нэгдсэн бүртгэл хөтлөх;

5.5.3.фармакопейд нэмэлт, өөрчлөлт оруулах, эмхэтгэн хэвлэх;

5.5.4.фармакопейн өгүүллийг хүчингүй болгох;

5.5.5.фармакопейн өгүүллийг боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө өгч, хянан магадлах.

5.6.Мал, амьтны эмийн зөвлөл болон фармакопейн хорооны үйл ажиллагаатай холбогдох зардлыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

5.7.Мал, амьтны эмийн фармакопейн хорооны ажиллах журам, хорооны бүрэлдэхүүнийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

Тайлбар: "фармакопейн өгүүлэл" гэж эмэнд тавих шаардлага, чанарын үзүүлэлт болон тэдгээрийг шинжлэх аргыг заасан зайлшгүй мөрдөх баримт бичгийг, "фармакопей" гэж фармакопейн өгүүллийн эмхэтгэлийг тус тус ойлгоно.

## **6 дугаар зүйл. Мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг бүртгэх**

6.1. Мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг улсын бүртгэлд бүртгэх, өөрчлөлт оруулах асуудлыг мал, амьтны эмийн зөвлөл хэрэгжүүлнэ.

6.2. Дор дурдсан мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг мал, амьтны эмийн бүртгэлд бүртгэнэ:

6.2.1. энэ зүйлийн 6.3-д зааснаас бусад бүх төрлийн урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зориулалттай эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт;

6.2.2. тун, хэлбэр, савлагаа, найрлага, хэрэглэх заавар болон үйлдвэрлэлийн технологид өөрчлөлт орсон эм, тэжээлийн нэмэлт;

6.2.3. олон улсын зээл, тусламжаар импортлох эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт;

6.2.4. үйлдвэрийн аргаар бэлтгэсэн эмчилгээний тун бүхий амин дэм, эмийн эмчилгээг дэмжих, сэргийлэх зориулалттай бэлдмэл;

6.3. Дор дурдсан мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт бүртгэлд хамаарахгүй:

6.3.1. эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн бүртгэлийн дээж;

6.3.2. судалгаа, шинжилгээний ажил, эмнэлзүйн туршилтад хэрэглэх эм;

6.3.3. үзэсгэлэн худалдаанд оролцуулах эм;

6.3.4. эмийн туслах бодис;

6.3.5. цацраг идэвхт бодис, тэдгээрийн бэлдмэл;

6.3.6. химийн урвалж болон бүх төрлийн тэжээлт орчин;

6.3.7. лабораторийн зориулалтаар хэрэглэгдэх будаг.

6.4. Мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч, импортлогч, хэлбэр, тун, зориулалтыг зааж мал, амьтны эмийн бүртгэлд 5 жилийн хугацаатайгаар бүртгэнэ.

6.5. Гамшгийн болон онцгой байдлын нөхцөл үүссэн үед хэрэглэх эмийг 1 жилийн хугацаатайгаар түргэвчилсэн журмаар бүртгэнэ.

6.6. Шинээр зохион бүтээсэн үндэсний үйлдвэрийн эмийг бүртгэх эсэхийг туршилт, судалгааны тайлан, эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэн хэлэлцэн, шийдвэрлэнэ.

6.7. Үндэсний үйлдвэрийн эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг бүртгүүлэхэд дор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ:

6.7.1. эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл, эмийн түүхий эдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар, үйлдвэрийн танилцуулга, эмийн технологийн зураглал;

6.7.2.мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн фармакопейн өгүүлэл;

6.7.3.мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн судалгааны тайланг хэлэлцсэн талаарх эрдэм шинжилгээний байгууллагын дэргэдэх зөвлөлийн хуралдааны тэмдэглэл;

6.7.4.мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтэд сорилт, туршилт хийсэн эрх бүхий хөндлөнгийн лабораторийн сорилт, баталгаажуулалтын дүн;

6.7.5.эмийн тогтвортой байдал, гаж нөлөө, харилцан нөлөөлөл, хорон чанар, идэвхи, аюулгүй байдлыг судалсан дүн, сорилт, туршилт хийсэн судалгааны дэлгэрэнгүй материал, дүн;

6.7.6.Эмийн хэрэглэх зааврын төсөл;

6.8.Импортын эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг бүртгүүлэхэд дор дурдсан баримт бичгийг баталгаажуулсан монгол орчуулгын хамт ирүүлэх ба ирүүлсэн материалыг буцаан олгохгүй:

6.8.1.үйлдвэрлэгчтэй байгуулсан худалдааны гэрээ, итгэмжлэл;

6.8.2.фармакопейн өгүүлэл;

6.8.3.үйлдвэрлэгчийн танилцуулга, үйлдвэр нь олон улсын стандарт, чанарын шаардлага (GMP) хангасныг нотлох баримт бичиг;

6.8.4.үйлдвэрлэгч орны болон өөрийн орны эрх бүхий хөндлөнгийн лабораторийн сорилт баталгаажуулалтын дүн;

6.8.5.эмзүй, эмнэлзүйн туршилтын нийтлэгдсэн материал, гол үйлчлэгч, туслах бодис, тогтвортой чанарын шинжилгээ судалгааны дүн, эмийн хорон чанар, идэвхи, найрлага, аюулгүй байдал, харилцан нөлөөллийг судалсан дүн, эмийн шошго /монгол, англи хэл дээр баталгаажуулсан байх/;

6.8.6.тухайн эмийн найрлага, химийн шинж чанар, хэрэглэх, хориглох заалт, гаж нөлөө, эмийн харилцан үйлчлэл, тун хадгалах нөхцөл, сэрэмжлүүлэг зэргийг тусгасан баталгаажсан загварын дагуу бичигдсэн хэрэглэх заавар;

Тайлбар: "эмийн гаж нөлөө" гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зорилгоор зааврын дагуу хэрэглэх явцад илэрч байгаа сөрөг хариу урвалыг ойлгоно.

6.8.7.эмийн дээж;

6.8.8.тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон эмийн бүртгэлийн гэрчилгээ;

6.8.9.эмийн гарал үүслийн гэрчилгээ;

6.8.10.эмийн түүхий эдийг улсын бүртгэлд бүртгэхэд үйлдвэрлэгчийн GMP гэрчилгээ, бүтээгдэхүүний сертификат, шинжилгээний дүн, аргачлал, лабораторийн сорилтын дүн, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын орчны үнэлгээний дүгнэлт, холбогдох бусад материалууд орчуулгын хамт;

6.8.11.биобэлдмэл бүртгүүлэхэд дээр дурдагдсан бичиг баримтаас гадна олон улсын лавлагаа лабораторийн шинжилгээний дүгнэлт.

6.9.Мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэсэн улс, үйлдвэрлэгч, хэлбэр, тун тус бүрээр нь Малын эмийн улсын бүртгэлд нэг удаа бүртгэнэ.

6.10.Мал, амьтны эмийн зөвлөл нь энэ хуульд заасан шаардлага хангасан баримт бичгийг хүлээж авснаас хойш 1 сарын дотор, түргэвчилсэн журмаар мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

6.11.Дараах тохиолдолд эмийн улсын бүртгэлийг шинэчилнэ:

6.11.1.Мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн үйлдвэрийн өмчлөлийн хэлбэр, харьяалал, нэр, хаяг, гарал үүсэл өөрчлөгдсөн;

6.11.2.Үйлдвэрийн технологи, эмийн фармакопей, хэрэглэх заавар, тун өөрчлөгдсөн.

6.12.Мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн бүртгэлийн дугаар нь тухайн эмийн гарал үүсэл, бүртгэгдсэн он, бүртгэлийн хүчинтэй хугацаа, олон улсын эмийн ангиллын томъёолол, эм олгох нөхцөл, хувийн дугаарын талаарх мэдээлэл агуулсан байна.

6.13.Бүртгэлийн хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчөөгүй тухай хяналтын байгууллагын болон эрх бүхий хөндлөнгийн лабораторийн дүгнэлтийг үндэслэн бүртгэлийг анх олгосон хугацаанаас доошгүй хугацаагаар сунгана.

6.14.Мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн бүртгэлийн хугацааг сунгасан тохиолдолд бүртгэлийн дугаарыг давтан хэрэглэнэ.

6.15.Дараах тохиолдолд мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг улсын бүртгэлээс хасна:

6.15.1.бүртгэлийн хугацаа дуусахаас 2 сараас доошгүй хугацааны өмнө эм ханган нийлүүлэх байгууллага сунгуулах хүсэлтээ Мал, амьтны эмийн зөвлөлд ирүүлээгүй;

6.15.2.мал эмнэлгийн эмчилгээ үйлчилгээнд нийцээгүй буюу гаж нөлөө илэрсэн, хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөргөөр нөлөөлсөн, өвчний үүсгэгч тухайн эмэнд дасал болсон нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;

6.15.3.тухайн үйлдвэрлэгч мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг хуурамчаар үйлдвэрлэсэн болох нь нотлогдсон;

6.16.Мал, амьтны эмийн бүртгэлд бүртгүүлэхдээ бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн болох нь нотлогдсон тохиолдолд мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн бүртгэлийг хүчингүй болгоно.

6.17.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн бүртгэл, мэдээллийн цахим сантай байна.

6.18.Энэ хуулийн 6.17-д заасан цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.19.Мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн бүртгэлтэй холбоотой зардлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага жил бүрийн төсөвтөө тусган хэрэгжүүлнэ.

## **7 дугаар зүйл.Мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн чанарын баталгаажуулалт**

7.1.Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын лаборатори нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 29.2-т зааснаас гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.1.1.мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэлийг үйлдвэрлэх, шалгах, хэрэглэхтэй холбоотой зөвлөмж гаргах;

7.1.2.мал эмнэлгийн хэрэгцээнд шинээр нэвтрүүлж байгаа эм, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг лабораторийн болон хээрийн нөхцөлд сорьж турших;

7.1.3.лабораторийн хяналт, шалгалт, туршилт шинжилгээний ажилд ашигладаг стандарт бодисууд болон мал, амьтны өвчний үүсгэгчийн шалгалтын омгуудыг зохих стандартын дагуу хадгалах, сэргээх, баталгаажуулах, шинэчлэх, шилжүүлэн авах, худалдан авах, нөөц бүрдүүлэх;

7.1.4.сорилт, баталгаажуулалтад хамрагдсан эм, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн мэдээ, тайланг улирал тутам гаргаж дээд шатны байгууллагад мэдээлэх.

7.2.Мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг шаардлагатай тохиолдолд олон улсын эрх бүхий лавлагаа лабораторид хүргүүлэн баталгаажуулна.

## **8 дугаар зүйл.Мал, амьтны эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хаяглалт, түүнд тавигдах шаардлага**

8.1.Мал, амьтны эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн сав, баглаа боодол, шошго, хаяглалт, тэмдэглэгээ нь дараах мэдээллийг агуулсан байна:

- 8.1.1.эмийн худалдааны болон олон улсын нэршил;
- 8.1.2.эмийн хэлбэр;
- 8.1.3.тун, хэмжээ, тоо ширхэг;
- 8.1.4.үйлдвэрлэгчийн нэр;
- 8.1.5.цувралын дугаар;
- 8.1.6.хэрэглэх арга;
- 8.1.7.үйлдвэрлэсэн он, сар, өдөр, хүчинтэй хугацаа;
- 8.1.8.хадгалах, тээвэрлэх нөхцөл;
- 8.1.9.Монгол Улсын мал эмнэлгийн эмийн бүртгэлийн дугаар;
- 8.1.10.үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүллийн дугаар.

8.2.Энэ хуулийн 8.1.9, 8.1.10 дахь заалт нь зөвхөн үндэсний үйлдвэрлэгчид хамаарна.

8.3.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн шошго ба хэрэглэх зааварт “Зөвхөн мал эмнэлгийн хэрэглээнд зориулав” гэсэн тэмдэглэгээг бичнэ.

8.4.Мал, амьтны эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хэрэглэх заавар нь монгол хэлээр бичигдсэн байх бөгөөд дараах мэдээллийг агуулна:

- 8.4.1.үйлдвэрлэгчийн нэр, албан ёсны хаяг;
- 8.4.2.эмийн худалдааны болон олон улсын нэршил;
- 8.4.3.эмийн найрлага, тун, хэмжээ;
- 8.4.4.эмийн ангилал, үйлдлийн механизм;
- 8.4.5.хэрэглэх заалт;
- 8.4.6.хэрэглэх арга;
- 8.4.7.гаж нөлөө;
- 8.4.8.хориглох заалт;
- 8.4.9.хүчинтэй хугацаа;
- 8.4.10.хадгалах нөхцөл;
- 8.4.11.биеэс гадагшлах хугацаа;
- 8.4.12.анхааруулга;
- 8.4.13.эмийн ангилал.

8.5. Мал, амьтны эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн сав, баглаа боодол, шошго, хаяглалт, тэмдэглэгээ, баталгаажсан хэрэглэх зааврыг дур мэдэн өөрчлөхийг хориглоно.

**9 дүгээр зүйл.Мал, амьтны эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн судалгаа, шинжилгээ**

9.1.Шинээр бүтээсэн мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт нь эмзүй, эм судлал, хор судлал болон бусад судалгааны дүнгээр баталгаажсан байна.

9.2.Шинэ эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн талаар хийгдсэн судалгааны тайланг мал эмнэлгийн эрдэм шинжилгээний, эсхүл дээд боловсролын байгууллагын Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсан байна.

9.3.Хангамжийн байгууллага нь энэ хуулийн 4.1.5-д заасан бүтээгдэхүүнийг шинээр хэрэглээнд нэвтрүүлэхээс өмнө Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 29.1-д заасан лабораториор харьцуулсан үр дүнгийн судалгааг хийлгэнэ.

9.4.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь эрдэм шинжилгээний ажлыг гэрээ, захиалгаар гүйцэтгүүлэх, үр дүнг нэвтрүүлэх ажлыг удирдан зохион байгуулна.

#### **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **МАЛ, АМЬТНЫ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, ЭМИЙН ТҮҮХИЙ ЭД, АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БЭЛДМЭЛ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ХУДАЛДАА, ХАНГАМЖ, ЗӨВШӨӨРӨЛ**

**10 дугаар зүйл.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хангамжийн байгууллага**

10.1.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хангамжийн байгууллага /цаашид "хангамжийн байгууллага" гэх/ нь малын эмийн бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтээр мал эмнэлгийн байгууллагыг хүртээмжтэй хангах зарчмыг үйл ажиллагаандаа баримтална.

10.2.Хангамжийн байгууллагад дараах байгууллага хамаарна:

10.2.1.мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн үйлдвэр;

10.2.2.мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг ханган нийлүүлэх байгууллага;

10.2.3.мал, амьтны эмийн сан;

10.3.Энэ хуулийн 10.2.1, 10.2.2-т заасан байгууллага нь эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг бөөний үнээр худалдан борлуулах салбар нэгж байгуулан ажиллаж болно.

10.4.Хангамжийн байгууллага нь үйл ажиллагаандаа зохистой дадлыг нэвтрүүлж, үндэсний стандартыг мөрдөж ажиллана.

10.5.Мал, амьтны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хангамжийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавина.

10.6.Хангамжийн байгууллага нь үйлдвэрлэсэн, импортолсон эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн холбогдох баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд зах зээлд нэвтрүүлэхээс нэг сарын өмнө мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэн, бүртгэлийг шинэчлүүлсэн байна.

10.7.Хангамжийн байгууллагын байршил, барилга байгууламж, мэргэжлийн удирдлага, чанарын менежер өөрчлөгдсөн талаарх мэдээллийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр мэдэгдэнэ.

10.8.Хангамжийн байгууллага нь үйлдвэрлэсэн, импортолсон, нийлүүлсэн мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн бэлдмэлийн жилийн тайланг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн оны 12 дугаар сарын 20-ны дотор хүргүүлнэ.

10.9.Дархлаажуулах биобэлдмэлийн улсын нөөц бүрдүүлэх, хадгалах, тээвэрлэх, хэвийн хорогдол тооцох, биоаюултай хог хаягдлыг эгүүлэн татах, устгах журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

10.10.Гамшгийн болон онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллага олон улсын чанарын шаардлага хангасан мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авч болно.

10.11.Энэ хуулийн 10.2-т заасан хангамжийн байгууллагаас бусад байгууллага, иргэн мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

## **11 дүгээр зүйл.Мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн үйлдвэр**

11.1.Мал, амьтны эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн үйлдвэр /цаашид “эмийн үйлдвэр” гэх/ гэж зориулалтын түүхий эд ашиглан стандарт, технологийн дагуу мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг хэлнэ.

11.2.Эмийн үйлдвэр нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

11.2.1.үндэсний болон олон улсын стандартын шаардлага хангасан эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэх технологитой байх;

11.2.2.эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан зориулалтын байр, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

11.2.3.үйлдвэрлэлийн зохистой дадлын шаардлага хангасан байх;

11.2.4.эмийн түүхий эдийг эмийн бүртгэлд бүртгүүлсэн байх;

11.2.5.өөрийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцах чанарын хяналтын тогтолцоотой байх;

11.2.6.үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний цуврал бүрд хөндлөнгийн чанарын баталгаа гаргуулдаг байх;

11.2.7.үйлдвэрлэсэн эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн сав, баглаа боодол, шошго нь стандартын шаардлага хангасан байх.

11.3.Эмийн үйлдвэр өөрийн бүтээгдэхүүний чанарыг хариуцна.

11.4.Эмийн үйлдвэрт дараах үйл ажиллагааг хориглоно:

11.4.1.мал, амьтны эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эмийн түүхий эд хэрэглэх;

11.4.2.чанарын шаардлага хангаагүй түүхий эдээр үйлдвэрлэл явуулах;

11.4.3.эмийг эмийн бус бүтээгдэхүүнтэй нэг байр, шугам дамжлагаар үйлдвэрлэх;

11.4.4.хуурамч, стандартын бус бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

11.4.5.мал эмнэлгийн байгууллагыг өөрийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг худалдаалсан үр дүнгээр нь урамшуулах буюу түүнтэй адилтгах үйл ажиллагаанд оролцуулах.

11.5.Энэ хуулийн 10.2.1, 10.2.2-т заасан хуулийн этгээд нь хэрэглэгчийн захиалгын дагуу чанарын баталгаатай биобэлдмэлийг мал эмнэлгийн байгууллагын хяналт дор нийлүүлж болно.

**12 дугаар зүйл.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг ханган нийлүүлэх байгууллага**

12.1.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг ханган нийлүүлэх байгууллага /цаашид "ханган нийлүүлэх байгууллага" гэх/ гэж мал эмнэлгийн байгууллага, мал, амьтны эмийн санд эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг гэрээний үндсэн дээр бөөнөөр ханган нийлүүлэх хуулийн этгээдийг хэлнэ.

12.2.Ханган нийлүүлэх байгууллага нь үйл ажиллагаандаа холбогдох стандартыг мөрдөнө.

12.3.Ханган нийлүүлэх байгууллага нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

12.3.1.мэргэжлийн боловсон хүчний чадавхитай байх;

12.3.2.өөрийн импортолсон, түгээсэн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцах дотоод хяналтын тогтолцоотой байх;

12.3.3.мал эмнэлгийн хэрэгсэлд шалгалт тохируулга, баталгаажуулалт хийлгэсэн байх;

12.3.4.эмийн санд эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг ханган нийлүүлэхдээ цуврал бүрийн чанарын баталгааны нотлох баримтыг дагалдуулах;

12.4.Мал эмнэлгийн байгууллага нь улсын бүртгэлд бүртгэсэн, чанарын баталгаатай эм, тэжээлийн нэмэлтийг тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэрлэгч, импортлогчоос гэрээний үндсэн дээр худалдан авна.

12.5.Мал, амьтны эмнэлгийн хэрэгслийг импортлох, ханган нийлүүлэхэд тухайн бүтээгдэхүүний техникийн болон чанарын баталгаажуулалтын баримт бичгийг хавсаргасан байна.

12.6.Ханган нийлүүлэх байгууллага өөрийн нийлүүлсэн мал эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ, тохируулгыг баталгаат хугацаанд бүрэн хариуцна.

12.7.Ханган нийлүүлэх байгууллагад дараах зүйлийг хориглоно:

12.7.1.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг тусгай зөвшөөрөлгүйгээр импортлох;

12.7.2.бүртгэлд ороогүй, чанарын баталгаагүй, шошгогүй, хүчинтэй хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг нийлүүлэх;

12.7.3.мал эмнэлгийн байгууллагыг эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт худалдаалсан үр дүнгээр нь урамшуулах буюу түүнтэй адилтгах үйл ажиллагаанд оролцуулах;

12.7.4.хуурамч, эсхүл бүртгэлд ороогүй эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг импортлох, худалдах;

12.7.5.мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хадгалалт, түгээлт, ашиглалтын заавар, журам, стандарт зөрчих;

12.7.6.малчин, иргэнд эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг худалдах, түгээх.

12.8.Мал эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга, баталгаажуулалттай холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Хэмжил зүйн тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.

Тайлбар: "эмнэлгийн хэрэгсэл" гэж мал, амьтны өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх, сувилах, сэргийлэх ба бие махбодын бүтэц, үйл ажиллагааг хянах, орлох, сэргээн засах зорилгоор хэрэглэдэг мал эмнэлгийн болон эмийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, түүний дагалт эд зүйл, программ хангамжийг ойлгоно.

### **13 дугаар зүйл.Мал, амьтны эмийн сан**

13.1.Мал, амьтны эмийн сан /цаашид "эмийн сан" гэх/ гэж мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг жижиглэнгийн үнээр худалдах үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг хэлнэ.

13.2.Эмийн сан нь үйл ажиллагаандаа холбогдох стандартыг мөрдөнө.

13.3.Эмийн санд эм барих эрх бүхий малын эмч, эсхүл мал эмнэлгийн эм зүйч ажиллана.

13.4.Эмийн сан нь эмийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллагаас гэрээний үндсэн дээр мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг худалдан авна.

13.5.Мал, амьтны эмчилгээ, үйлчилгээнд хэрэглэгддэг хүн эмнэлгийн зориулалт бүхий эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтыг эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.

13.6.Мал эмнэлгийн байгууллага, эмийн сан нь энэ хуулийн 13.5-д заасан жагсаалтад орсон эм, эмнэлгийн хэрэгслийг тусгай зөвшөөрөл бүхий хүн эмнэлгийн эм хангамжийн байгууллагаас гэрээний үндсэн дээр худалдан авна.

13.7.Эмийн сангийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

13.7.1.энэ хуулийн 13.3-т зааснаас бусад этгээдийг ажиллуулах;

13.7.2.эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хадгалалт, шошго, тээвэрлэлт, түгээлтийн журам зөрчих;

13.7.3.жороор олгох эмийг жоргүйгээр эсхүл стандартын бус жороор олгох;

Тайлбар: мал, амьтны эмийн жор гэдэгт малын эмчээс эм зүйч, эм найруулагчид хандан эмийг өвчтэй мал, амьтанд зориулан бэлтгэх, олгох, хэрэглэх аргыг заасан баримт бичгийг ойлгоно.

13.7.4.хуурамч, эсхүл бүртгэлд ороогүй эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтээр үйлчлэх;

13.7.5.мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг хүнд хэрэглэхээр олгох;

13.7.6.буцалтгүй тусламжийн болон төсвийн хөрөнгөөр нийлүүлсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг үнэлэн худалдах.

#### **14 дүгээр зүйл.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч иргэн, хуулийн этгээдэд хориглох зүйл**

14.1.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч иргэн, хуулийн этгээдэд дараах зүйлийг хориглоно:

14.1.1.хуурамч, бүртгэлд ороогүй, чанарын баталгаагүй, хүчинтэй хугацаа дууссан эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг дур мэдэн худалдан авах, хэрэглэх;

14.1.2.зориулалтын бус газарт эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт, эмийн түүхий эдийг хадгалах;

14.1.3.мал, амьтныг дархлаажуулах биобэлдмэл, жороор олгох эмийг малын эмчийн зөвшөөрөлгүй мал, амьтанд хэрэглэх.

#### **15 дугаар зүйл.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг улсын хилээр нэвтрүүлэх**

15.1.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг Засгийн газар тогтооно.

15.2.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг импортлох, экспортлоход мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас энгийн зөвшөөрөл авна.

15.3.Энгийн зөвшөөрөлд эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн нэр, хэлбэр, тун, тоо хэмжээ, үйлдвэрлэгчийн нэр, улсын хилээр нэвтрүүлэх хугацаа, хилийн боомтыг заасан байна.

15.4.Гамшгийн болон онцгой байдлын нөхцөл үүссэн үед эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм болон яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг зайлшгүй шаардлагаар импортоор авах тохиолдолд мал, амьтны эмийн зөвлөлийн дүгнэлтийг

үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр энгийн зөвшөөрөл олгоно.

15.5.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг импортлогч нь гадаад улсын эмийн үйлдвэр, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай, экспортлогч нь худалдан авагч байгууллагатай худалдааны гэрээ байгуулсан байна.

15.6.Тусламж, хандиваар мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт нь дараах шаардлагыг хангасан байна:

15.6.1.олон улсын стандартын шаардлага хангасныг нотолсон эрх бүхий байгууллагын тодорхойлолттой байх;

15.6.2.шинээр үйлдвэрлэгдсэн байх, нийлүүлэгдэх үед 2 жилээс дээш хугацаатай барааны хувьд  $2/3$  нь өнгөрөөгүй, 2 жил хүртэлх хадгалалтын хугацаатай барааны хувьд  $3/4$  нь өнгөрөөгүй байх;

15.6.3.шошго нь ерөнхий нэршил, хэлбэр, тун, тоо хэмжээ, цувралын дугаар, гарал үүслийн улсын нэр, үйлдвэрлэгчийн нэр, хадгалах нөхцөл болон хугацааны талаарх мэдээллийг агуулсан байх.

15.7.Тусламж, хандиваар мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт хүлээн авахад тусламж, хандив үзүүлэгч болон хүлээн авагч хоёр тал гэрээ байгуулах бөгөөд гэрээнд дараах зүйлийг тусгана:

15.7.1.тээвэрлэлт, түгээлт, түүнд холбогдон гарах зардлыг хариуцах этгээд;

15.7.2.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасны дагуу албан татвараас чөлөөлөгдөхөөр зааснаас бусад тусламж, хандивын бараанд ногдох татварыг хариуцах этгээд;

15.7.3.чанарын сорилт, баталгаажилттай холбогдон гарах зардлыг хариуцах этгээд, түүний үүрэг;

15.7.4.хүчинтэй хугацаа хэтэрсэн, чанарын шаардлага хангахгүй, ашиглах боломжгүй, иж бүрдэл дутуу ирсэн тохиолдолд хилээр буцаан гаргах болон устгахтай холбогдон гарах зардлыг хариуцах этгээд, хоёр талын харилцан хүлээх үүрэг, хариуцлага.

15.8.Тусламж, хандиваар нийлүүлж буй мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт нь шаардлага хангасан тохиолдолд малын эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага импортын лиценз олгоно.

15.9.Тусламж, хандиваар нийлүүлж буй мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг хилээр нэвтэрсний дараа тусламж, хандивыг хүлээн авагч нь итгэмжлэгдсэн эрх бүхий лабораторид шинжилгээнд хамруулж чанарыг баталгаажуулна.

15.10.Тусламж, хандиваар нийлүүлж буй мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг гаалийн болон нэмэгдсэн

өртгийн албан татвараас чөлөөлөхөд захиалгат бараа ачигдсан мэдээ, баримтыг тусламж, хандив үзүүлэгч талаас хүлээн авсан даруй хүлээн авагч дараах бичиг баримтыг бүрдүүлэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

15.10.1. татвараас чөлөөлүүлэх тухай албан бичиг;

15.10.2. тусламж, хандив үзүүлэгч болон хүлээн авагч талын хооронд байгуулсан хамтын ажиллагааны болон төслийн гэрээ;

15.10.3. тээврийн баримт, үнийн дагалдах баримт, баглаа боодлын жагсаалт, илгээгч байгууллагын тодорхойлолтын хуулбар;

15.11. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 15.10-т заасан баримт бичгийг хүлээн авч татвараас чөлөөлүүлэх тухай албан бичгийг ажлын 5 өдөрт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

15.12. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг импортлох, экспортлоход дараах зүйлийг хориглоно:

15.12.1. энэ хуулийн 15.1-д заасны дагуу тогтоосноос өөр хилийн боомтоор нэвтрүүлэх;

15.12.2. "Монгол Улсад үйлдвэрлэв" гэсэн шошготой эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг импортлох;

15.12.3. тусгай зөвшөөрөлгүй хуулийн этгээд эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг импортлох;

15.12.4. зөвшөөрөлд заасан нэр, хэлбэр, тун, тоо хэмжээнээс илүү буюу өөр нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг улсын хилээр нэвтрүүлэх;

15.12.5. мал эмнэлгийн зориулалтаар мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийг шуудангийн илгээмжээр хүлээн авах;

15.12.6. хадгалалт, тээвэрлэлтийн нөхцөл, горим зөрчсөний улмаас эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтэд учирсан гэмтэл нь мал, амьтны эрүүл мэндэд хор хөнөөл учруулж болзошгүй нь тогтоогдсон;

15.12.7. тусламж, хандиваар хуурамч, стандартын бус, хадгалалт, тээвэрлэлтийн шаардлага хангаагүй, хугацаа дууссан мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг нэвтрүүлэх.

15.13. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Гаалийн тухай хуулиар зохицуулна.

## **16 дугаар зүйл. Мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн зохицуулалт**

16.1. Мал эмнэлгийн байгууллага нь мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт, хэрэглээний тайланг хуульд заасан хугацаанд гарган мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бичгээр, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

16.2. Мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн жилийн тайланг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хуульд заасан хугацаанд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн төв байгууллагад бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

16.3. Мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт, хэрэглээний явцад мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хяналт тавина.

16.4. Мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийг хууль бусаар хэрэглэсэн, зарцуулсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээг авна.

16.5. Мал эмнэлгийн байгууллагад хэрэглэсэн мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн орлого, зарлага, устгалын бүртгэл хөтлөх, зарцуулалтын журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **17 дугаар зүйл. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл олгох**

17.1. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12.12, 8.2 дугаар зүйлийн 11.4-т заасан энгийн зөвшөөрлийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус олгоно.

17.2. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгохдоо Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлтийн хамт хүргүүлнэ:

17.2.1. мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрийн барилга, байгууламж, түүний зохион байгуулалт, хүний нөөцтэй холбогдох зохистой дадлын стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангасан талаарх мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, нотлох баримт;

17.2.2. үйлдвэрлэлд ашиглах тоног төхөөрөмжийн үндсэн үзүүлэлт, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан тухай баримт бичиг.

17.3. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөл олгохдоо Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлтийн хамт хүргүүлнэ:

17.3.1. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

17.3.2.гадаад улсын ханган нийлүүлэгч байгууллагатай байгуулсан худалдааны гэрээ, итгэмжлэл, эсхүл албан ёсны төлөөлөл болохыг нотлох баримт;

17.3.3.бүтээгдэхүүний гарал үүсэл, сорилтын дүн, тохирлын гэрчилгээ;

17.3.4.экспортлогч орны эмийн цувралын чанарын баталгаажилт;

17.3.5.эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн олон улсын болон тухайн орны чанар баталгаажилтын болон гарал үүслийн гэрчилгээ, хэрэглэх заавар үйлдвэрлэгч, эсхүл нийлүүлэгчийн олон улсын чанар, стандартын шаардлага хангасан гэрчилгээ.

17.4.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт импортлох, экспортлох энгийн зөвшөөрөл олгохдоо Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлтийн хамт хүргүүлнэ:

17.4.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

17.4.2.үйлдвэрлэгч болон албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ;

17.4.3.бүтээгдэхүүн нь олон улсын чанарын стандартын шаардлага хангасныг нотлох гэрчилгээ;

17.4.4.импортлох энгийн зөвшөөрлийн хувьд бүтээгдэхүүний хэрэглэх заавар монгол хэл дээрх орчуулгын хамт;

17.4.5.тухайн бүтээгдэхүүний хүчинтэй байх хугацааны дөрөвний гурав нь дуусаагүй болохыг нотлох баримт.

17.4.6.бүтээгдэхүүний нэр, хэлбэр, тун, тоо хэмжээ /баглаа боодол/, үйлдвэрлэгчийн нэр, хилээр нэвтрүүлэх хугацаа, нэвтрүүлэх хилийн боомтын талаарх мэдээлэл;

17.4.7.ачаа, тээврийн баримтын гаальд бүртгэгдсэн эх хувь, баглаа, боодлын дэлгэрэнгүй бүртгэл, нэхэмжлэлийн хуулбар, үйлдвэрлэгчээс олгосон сертификат.

17.5.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг импортлох болон экспортлох энгийн зөвшөөрөл олгосноос хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

17.6.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгох асуудлыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан журмыг баримтлан хугацаанд нь шийдвэрлэнэ.

17.7.Тусгай болон энгийн зөвшөөрөлтэй холбогдсон энэ хуулиар зохицуулснаас бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

17.8.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэлийн хангамжийн талаар бүх шатны Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.8.1.нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд мал, амьтны өвчинтэй тэмцэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлж, хэрэгжилт, зарцуулалтад нь хяналт тавих;

17.8.2.мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн зохистой хэрэглээний талаар нутаг дэвсгэрийн хэмжээнд соён гэгээрүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;

Тайлбар: “эмийн зохистой хэрэглээ” гэж мал, амьтны эмийг өвчний оношид нийцүүлэн хэрэглэх зааврын дагуу зохих тун, зориулалт, тогтоосон давтамжаар хэрэглэхийг ойлгоно.

17.8.3.гамшиг, аюулт үзэгдэл, гоц халдварт, халдварт өвчин зэрэг мал, амьтанд хор хөнөөл учруулах нөхцөл бий болсон үед ашиглах шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн нөөцийг бүрдүүлэх.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МАЛ, АМЬТНЫ ЭМ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ**

### **18 дугаар зүйл.Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх**

18.1.Тэсвэржсэн бичил биетэнтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хязгаарлах, орлуулах, хориглох, бүртгэлээс хасах зарчмыг мөрдлөг болгоно.

18.2.Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх, тэсвэржсэн бичил биетнийг илрүүлэх, хянах үйл ажиллагаа нь эрсдэлийн үнэлгээнд суурилна.

Тайлбар:“бичил биетний тэсвэржилт” гэж ижил зүйлийн мэдрэмтгий бичил биетэнтэй харьцуулахад бичил биетний эсрэг эмийн тунг ихэсгэн хэрэглэсэн тохиолдолд үржсээр байх, эсхүл тогтвортой орших бичил биетний чадварыг ойлгоно.

18.3.Олон улсын жишгийн дагуу шаталсан сайжруулалтын аргад үндэслэсэн бичил биетний тэсвэржилтийн тандалт шинжилгээг итгэмжлэгдсэн лаборатори хэрэгжүүлнэ.

18.4.Бичил биетний тэсвэржилтийг тандах, түүнээс сэргийлэх, тэмцэх үндэсний хэмжээний төлөвлөгөөг эрүүл мэндийн болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

18.5.Бичил биетний тэсвэржилтийг тандах, сэргийлэх, тэмцэх жилийн төлөвлөгөөг үндэсний хэмжээний төлөвлөгөөнд үндэслэн мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга баталж, хэрэгжүүлнэ.

18.6.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бичил биетний тэсвэржилтийн тандан судалгааны дүн, илэрцийн байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээллийг холбогдох олон улсын байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

### **19 дүгээр зүйл.Мал, амьтны эмийн үлдцээс сэргийлэх**

19.1.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мал, амьтны биед илрэх эмийн үлдцийн босго үзүүлэлт болон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн эмийн нэр, тоон үзүүлэлтийг лабораторийн шинжилгээний дүнд үндэслэн жил бүр шинэчлэн тогтоож, өөрийн орны судалгааны дүн болон олон улсын удирдамжийг баримтлан хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

19.2.Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн, түүний орчинд эмийн үлдцийг илрүүлэх, тодорхойлох, баталгаажуулахад олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргуудыг хэрэглэнэ.

19.3.Мал, амьтны эмийн үлдцийг илрүүлэх, үлдцийн хэмжээг тодорхойлох, эрсдэлийг үнэлэх, хяналтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

**20 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн зохистой хэрэглээний зохицуулалт**

20.1.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28.1-д заасан байгууллага мал, амьтны эмийн сэрэмжлүүлгийг өвчний зөв онош, эмийн зөв сонголт, тунгийн зөв сонголт, хэрэглээний зөв арга, цаг хугацааны зөв сонголт гэсэн зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

Тайлбар:“эмийн сэрэмжлүүлэг” гэж эмийн гаж нөлөөг илрүүлэх, үнэлэх, сэргийлэх үйл ажиллагааг ойлгоно.

20.2.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь жоргүй олгохоор зөвшөөрөгдсөн эм хэрэглэхдээ малын эмчээс зөвлөгөө, зааварчилгаа авна.

20.3.Мал, амьтныг өвчнөөс сэргийлэх, эмчлэх зориулалтаар хэрэглэж байгаа эмийг зөвхөн зааварт заасан тунгаар, хэрэглэх аргын дагуу зохих давтамжаар хэрэглэнэ.

20.4.Мал, амьтны эмийг жороор олгох журам, эмийн жагсаалтыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга жил бүр шинэчлэн батална.

20.5.Мал, амьтанд хэрэглэсэн эмийн гаж нөлөө болон бичил биетний тэсвэржилт, мал, амьтны биед үлдэц үүсгэдэг эм, бэлдмэлийн мэдээллийг сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг бүртгэж, улирал бүр цахим мэдээллийн санд оруулна.

20.6.Ханган нийлүүлэх байгууллага нь бичил биетний тэсвэржилт, мал, амьтны биед үлдэц үүсгэдэг эм, бэлдмэлийн орлого, зарлагын тайланг хагас жил тутамд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

20.7.Мал эмнэлгийн эмийг хэрэглэх явцад малын эмч нь эмийн сонголт, аюулгүй хэрэглээ, сөрөг үйлдэл болон хэрэглээний горимыг багтаасан сэрэмжлүүлгийг малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгчид тайлбарлаж таниулна.

20.8.Мал, амьтны эмийн зохистой хэрэглээг хэвшүүлэх сургалт, сурталчилгааг мал эмнэлгийн байгууллагууд харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна.

20.9.Малын эмч нь мал, амьтны эмчилгээнд хэрэглэсэн эмийн нэр, огноо, хэрэглэсэн тун, хэмжээний талаарх мэдээллийг тухай бүр тэмдэглэж, баримтжуулна.

20.10.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм худалдан авах, хэрэглэхийг хориглоно.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ**

**21 дүгээр зүйл. Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтэд тавих хяналт шалгалт**

21.1.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хяналт шалгалтыг аймаг, нийслэл, сум, дүүрэгт мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч, хил дээр ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид хэрэгжүүлнэ.

21.2.Энэ хуулийн 21.1-д заасан улсын байцаагч нь мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн талаар гарсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын биелэлтэд хяналт тавина.

21.3.Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-т заасан бүрэн эрхээс гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

21.3.1.мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг үйлдвэрлэх, импортлох, худалдаалах үйл ажиллагааны талаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан санал, хүсэлтийг хянах, дүгнэлт гаргах;

21.3.2.мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг импортлох тусгай зөвшөөрөл, малын эмч, эм зүйчийн мэргэжлийн итгэмжлэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл, дүгнэлтээ холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

21.3.3.мал, амьтны эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй, сорилт, баталгаажуулалт хийгдээгүй, эсхүл олон улсын хэрэглээнээс хасагдсан эм, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг зах зээлээс эгүүлэн татах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

21.3.4.зөрчил гаргасан хуулийн этгээдийн үйл ажиллагааг зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд бүхэлд нь болон хэсэгчлэн зогсоох, давтан гаргасан бол үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл цуцлах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх;

21.3.5.жороор олгох мал, амьтны эмийг дур мэдэн хэрэглэсэн бол тухайн хот айл, эрчимжсэн аж ахуйгаас мал, амьтан, тэдгээрийн гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэх эрхийг гурван сараар хязгаарлах.

21.3.6.мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтээс дээж авах, чанарын шаардлага хангаагүй тохиолдолд устгах, эгүүлэн татах талаар дүгнэлт гаргах;

21.3.7.хангамжийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх ажлын байрны стандартын шаардлага хангасан эсэхийг хянаж, дүгнэлт гаргах;

21.4.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хангамжийн байгууллагын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, эрсдэлийн шалгуурыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **ЗУРГААДУГААР БҮЛЭГ МАЛ, АМЬТНЫ ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, ЭМИЙН ТҮҮХИЙ ЭД, АРИУТГАЛ, ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН БЭЛДМЭЛ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ЗАР СУРТАЛЧИЛГАА**

**22 дугаар зүйл.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн мэдээлэл**

22.1.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн мэдээлэл нь оновчтой, зүй зохистой, үр дүнтэй хэрэглэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн байна.

22.2.Зар сурталчилгаанд статистик мэдээ, эм судлалын үзүүлэлт, эмнэл зүйн судалгааны дүн, баримтыг ашиглахдаа тухайн эх сурвалжийг нь заавал тусгасан байна.

22.3.Бүх шатны Засаг дарга нь малын эмч, эм зүйч, малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгчид эм зүйн мэргэжлийн сургалт, сурталчилгааг бие даан болон холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

22.4.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг сурталчлахад зар сурталчилгааны тухай хуулийн 13.4-т зааснаас гадна дараах зүйлийг хориглоно:

22.4.1.малын эмчийн зөвлөгөө, эмчилгээ, үйлчилгээг үгүйсгэх ойлголт төрүүлэх мэдээлэл өгөх;

22.4.2.мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг ховор, чухал, цорын ганц, маш өндөр идэвхтэй, үр дүн нь бусад эмээс илүү, аюулгүй, гаж нөлөөгүй, шинэ эм, патентлагдсан гэж хэрэглэгчийг төөрөгдүүлэх;

22.4.3.мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн худалдан авалтад урамшуулал олгох буюу үнийн хямдрал үзүүлэх тухай нийтэд сурталчлах.

22.4.4.мэргэжлийн бус иргэн, хуулийн этгээд Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн талаар олон нийтэд мэдээлэл өгөх.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

**23 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

23.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

23.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### **24 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

24.1.Энэ хуулийг 20.. оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

**1/11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт:**

“11.1.4.Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалтад багтсан өвчинтэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг оролцогч талууд хамтран санхүүжүүлж болно.”

**2 дугаар зүйл.**Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.16 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.1.16.“тэжээлийн нэмэлт” гэж Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн 4.1.4-т заасныг;”.

**3 дугаар зүйл.**Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Эм эмнэлгийн хэрэгслийн тухай” гэснийг “Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 24, 25, 26 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 28.11, 28.12, 28.13 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТӨСӨЛ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт "Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 13.10 дугаар зүйл нэмсүгэй:

**1/13.10 дугаар зүйл:**

**“13.10 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль зөрчих**

1.Мал, амьтны эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн үйлдвэрлэл эрхлэхэд тавигдах шаардлага, хориглох зүйлийг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлт импортлоход тавигдах шаардлага, хориглох зүйлийг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Мал, амьтны эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага, хориглох зүйлийг зөрчсөн бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Эм барих эрх бүхий малын эмч, эсхүл мал эмнэлгийн эм зүйч:

4.1.жороор олгох эмийг жоргүйгээр олгосон;

4.2.эмийг хүчингүй жороор олгосон бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр төгрөгөөр торгоно.

5.Хангамжийн байгууллага, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж:

5.1.эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, эсхүл чанарын баталгаажилтгүй, эсхүл хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтээр үйлчилсэн;

5.2.эмийн хадгалалт, хамгаалалтын журам зөрчсөн;

5.3.мал, амьтны эмийн сав, баглаа боодлын хаяглалт, шошго, тэмдэглэгээнд тавигдах шаардлагыг зөрчсөн;

5.4.Монгол Улсад үйлдвэрлэх, импортлох, худалдах мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг эмийн улсын бүртгэлд бүртгүүлээгүй;

5.5.мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн чанарын баталгаажилтыг хийлгээгүй;

5.6.ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор малын эмчийг мал, амьтны эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлт худалдах, үр дүнгээр урамшуулах, түүнтэй адилтгах үйл ажиллагаанд оролцуулсан бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Хуулиар хориглосон хэлбэрээр мал, амьтны эмийн зар сурталчилгаа явуулсан бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.11 дэх заалтын "13.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг," гэсний дараа "13.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг," гэж, мөн зүйлийн 6.14 дэх заалтын "11.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг," гэсний дараа "13.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг," гэж, мөн зүйлийн 6.44 дэх заалтын "13.9 дүгээр зүйл," гэсний дараа "13.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг," гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

Улаанбаатар  
хот

ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ  
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн гарчгийн "Эрүүл мэндийн" гэсний дараа "мал эмнэлгийн" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх хэсэг:**

"4.1.11."мал, амьтны эмийн үлдэц" гэж мал, амьтны гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, тэдгээрийн малын биед орж хувирсан нэгдлийн үлдэгдлийг;"

**2 дугаар зүйл.** Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтын "малын эм, биобэлдмэлийн" гэснийг "мал, амьтны эмийн үлдэц" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын "хүн, мал, амьтанд" гэснийг "хүнд" гэж, мөн зүйлийн 3.1.14 дэх заалтын "хүн болон мал, амьтанд" гэснийг "хүнд" гэж, мөн зүйлийн 3.1.23 дахь заалтын "байгууллага болон мал эмнэлгийг" гэснийг "байгууллагыг" гэж, 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсгийн "болон малын эмийн зөвлөл хамтран хуралдаж" гэснийг "эмийн зөвлөл" гэж, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн "бүртгэх бөгөөд мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 11.4-т заасан зөвшөөрлийг олгоно." гэснийг "бүртгэнэ." гэж, мөн зүйлийн 15.5 дахь хэсгийн "гишүүн болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын" гэснийг "гишүүний" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн "болон мал эмнэлгийн зориулалттай" гэснийг, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай" гэснийг, 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.5, 3.1.18 дахь заалтын "болон мал, амьтны" гэснийг, мөн зүйлийн 3.1.14 дэх заалт, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн "болон хөдөө аж ахуйн" гэснийг, мөн зүйлийн 3.1.24 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.2, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн "мал эмнэлэг" гэснийг, 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтын "холбогдох" гэснийг, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн " , мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд малын эмийн асуудал хариуцсан зөвлөл" гэснийг, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн "Мал, амьтны тэжээлийн нэмэлт, эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлоход мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна." гэснийг, мөн зүйлийн 15.7, 15.8, 22 дугаар зүйлийн 22.6, 23 дугаар зүйлийн 23.3, 23.4 дэх хэсгийн "болон хөдөө аж ахуйн" гэснийг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн "болон мал эмнэлгийн зориулалтаар хэрэглэх" гэснийг, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн "хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон" гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1.3 заалтын "холбогдох" гэснийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.**Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.5, 7.6, 7.7, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 15<sup>1</sup> дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг, мөн зүйлийн 16.5.2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ..... дугаар  
сарын .....-ны өдөр

Улаанбаатар  
хот

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн 12.12 дахь заалтын “Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэж өөрчилсүгэй.


3 дугаар зүйл. Энэ хуулийг Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ



Улаанбаатар хот  
2023 он

**АГУУЛГА**

<b>УДИРТГАЛ</b>	<b>4-5</b>
<b>НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ</b>	
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;	
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;	
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тогтоох;	<b>5-11</b>
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох;	
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;	
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.	
<b>ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ</b>	
2.1. Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах;	<b>11</b>
2.2. Судалгааны аргаар цуглуулсан мэдээллийг боловсруулах.	
<b>ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ</b>	
3.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Эмийн зөвлөлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтын талаархи төрийн зохицуулалт:	
3.4. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 10 дугаар зүйл. Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагааны зарчим, нийтлэг үүрэг:	
3.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11 дүгээр зүйл. Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагаанд хориглох зүйлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.7. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 12 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд тавих шаардлагын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.8. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 13 дугаар зүйл. Эмийн санд эм найруулахын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	<b>11-30</b>
3.9. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.10. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлохын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.11. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 16 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.12. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 18 дугаар зүйл. Эмийн хаяглалт, тэмдэглэгээний хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.13. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 19, 20, 21 дүгээр зүйл. Шинэ эмийг хэрэглээнд гаргах, Эмнэлзүйн өмнөх судалгаа, Эмнэлзүйн туршилтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.14. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 22 дугаар зүйл. Эмийн бүртгэлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	

3.15. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 23 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, хяналтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.16. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 24 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн хяналтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.17. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 25 дугаар зүйл. Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээлэлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.18. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 26 дугаар зүйл. Эмийн мэдээлэлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.19. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 27 дугаар зүйл. Эмийн зар сурталчилгааны хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.20. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 28 дугаар зүйл. Эм хангамжийн үйл ажиллагаан дахь төрийн бус байгууллагын оролцооны хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
3.21. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 29 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:	
<b>ДӨРӨВ. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЛДАН ГАРСАН ЗАХИРГААНЫ ХЭМЖЭЭ ТОГТООСОН АКТУУД ТАЛААР</b>	<b>30-32</b>
<b>ТАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</b>	
5.1. Дүгнэлт	32-34
5.2. Зөвлөмж	
<b>ЗУРГАА. ХАВСРАЛТУУД</b>	<b>35-49</b>

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

- ✚ ХХААХҮЯ – Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
- ✚ МЭЕГ – Мал эмнэлгийн ерөнхий газар
- ✚ УМЭАЦТЛ – Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори
- ✚ МЭЭСБУЛ – Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори
- ✚ БИОКОМБИНАТ ТӨХХК- БИОКОМБИНАТ төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
- ✚ АНМЭГ – Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар
- ✚ СДМЭТ – Сум, дүүргийн Мал эмнэлгийн тасаг
- ✚ МЭҮН – Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж

## УДИРТГАЛ

Монгол Улсад мал эмнэлгийн салбар нь анх 1923 онд Засгийн газрын шийдвэрээр тэр үеийн Сангийн яамны дэргэд Мал эмнэлэг, үржлийн хэлтэс байгуулагдсан бөгөөд Мал тариалангийн яам, Хөдөө аж ахуйн яам, Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам зэрэг байгууллагуудад хэлтэс, удирдах газар, ерөнхий газар, алба гэсэн нэртэйгээр ажиллаж байсан ч үйл ажиллагааны чиглэл нь өөрчлөгдөөгүй хамгийн сүүлд 2014 онд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газрын үйл ажиллагаагаа хэрэгжүүлж ажиллаж байсан.

Монгол Улсын Их Хурлаас 2017 онд “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийг баталж Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулалтын шинэ эрх зүйг бүрдүүлж, мал эмнэлгийн байгууллагуудыг мэргэжлийн нэгдсэн босоо тогтолцоонд шилжүүлсэн.

Сүүлийн жилүүдэд даяаршил, уур амьсгалын өөрчлөлт, гадаад, дотоод аялал жуулчлал, Мал, амьтан болон тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний экспорт, импорт, дотоод худалдааны өсөлт, хүн, мал, амьтны гадаад, дотоод шилжилт хөдөлгөөн зэрэг олон хүчин зүйлээс хамаарч халдварт өвчнүүд ихээр гарах болсон төдийгүй өмнө нь гарч байгаагүй өвчнүүд шинээр бүртгэгдэн хүн, мал, амьтны эрүүл мэнд, нийгэм эдийн засагт сөргөөр нөлөөлж байна.

Мал, амьтнаас хүнд халдварладаг өвчнийг зооноз гэх бөгөөд дэлхий дээр 1500 орчим хүний халдварт өвчин бүртгэгдсэний 60% нь зооноз өвчин байна. Жил бүр хүний 4-5 халдварт өвчин шинээр бүртгэгдэж байгаагаас 3-4 нь буюу 75-80 % нь амьтнаас хүнд халдварлаж (зооноз өвчин) байгааг судалгаагаар тогтоосон. Нийт зооноз өвчний 60%, сүүлийн 20 жилд шинээр бүртгэгдсэн зооноз өвчний 80% нь вирусээр үүссэн байна.

Монгол Улсад хүний болон мал, амьтны зориулалттай эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар зохицуулж байна.

Эмийн тухай хууль нь 1998 онд батлагдаж, 2006 онд нэмэлт, өөрчлөлт оруулж Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болгосон бөгөөд 2010 онд тус хуулийг шинэчлэн найруулснаас хойш нийтдээ 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үүнд:

- 2011 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр;
- 2012 оны 08 дугаар сарын 17-ний өдөр;
- 2012 оны 12 дугаар сарын 20-ны өдөр;
- 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр;
- 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр;
- 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр;
- 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр;

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиар 2010 онд батлагдаж, мал эмнэлгийн зориулалттай эм, түүний дотор уламжлалт эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагааг зохицуулж, хэрэгжсэнээс хойш арван хоёр жилийн хугацаа өнгөрсөн байна.

Аливаа улс орны мал эмнэлгийн алба нь мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, өвчин эмгэгтэй тэмцэх, эрт илрүүлэх, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах замаар нийтийн эрүүл мэндийг хамгаалах, гадаад, дотоод худалдааны чөлөөт байдлыг хангах үндсэн үүрэгтэй байдаг.

Нөгөө талаас Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны хувьд Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага /OIE/-аас батлан гаргасан стандарт, удирдамж, заавар, зөвлөмжид нийцүүлэн үндэсний бодлого, эрх зүйн орчныг өөрчлөх, шинээр боловсруулах үүрэг хүлээж байна.

Малын эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах, нянгийн тэсвэржилт үүсэх, мал эмнэлгийн эмийн бүтээгдэхүүнд зөвшөөрөл олгох, импортлох, үйлдвэрлэх, бөөний болон жижиглэнгийн үнээр ханган нийлүүлэх,

хэрэглэх, худалдаалах, устгах зохицуулалт зэрэг хүн, мал, амьтан, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах эрх зүйн үндсийг мал эмнэлгийн хууль тогтоомжоор тогтоохыг удирдамж болгодог билээ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт "...хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно." гэж заасан тул Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу "хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ"-г **ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮНЭЛЭХ** гэсэн гурван үе шаттайгаар гүйцэтгэлээ.

Үнэлгээг бие даасан, хараат бус байдлаар, судалгааны арга зүйг ашиглан хийж, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмаар гүйцэтгэсэн болно.

## НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль хүний болон мал эмнэлгийн зориулалттай эм, түүний дотор уламжлалт эм, биобэлдмэл, оношлуур /цаашид "эм" гэх/, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж ирсэн.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын 3.2-т заасныг үндэслэн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль нь 2010 онд батлагдан, мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд буюу хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хуулийн эрх зүйн зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүйгээс сөрөг үр дагаварууд гарах болсон зэргийг харгалзан хэрэгжилтийн үр дагаварт нь үнэлгээ хийх шаардлагатай гэж үзсэн.

Уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийж буй үнэлгээ нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл, хуулиар зохицуулсан харилцаа нь зорилгодоо хүрч чадаж байгааг тодорхойлох, хэрэгжилтийн явцыг тодорхойлон хуулийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо оновчтой байгаа эсэх, хариуцлагын тогтолцоо үүргээ гүйцэтгэж байгаа эсэхийг тогтоохыг зорилго болгосон.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаан дахь нийгмийн харилцаа болон төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, үйл ажиллагааны өөрчлөлт, хөгжлөөс шалтгаалан тус хуулийн зохицуулалтыг Олон Улсын Үнэлгээний Стандартад нийцүүлэн өөрчлөн шинэчлэх, хэрэгжүүлэхэд ээдрээ түвэгтэй, нэг мөр ойлгож, хэрэглэхэд хүндрэлтэй зарим зохицуулалтуудыг засаж сайжруулах хуулийн үйлчлэх хүрээг шинээр авч үзэх хэрэгцээ, шаардлага бий болсоор байна.

### 1.1. Үнэлгээ хийх хүрээ

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг бүхэлд нь үнэлэх бөгөөд шаардлагатай зүйл, хэсгийг хүснэгтээр үзүүлбэл;

Хүснэгт 1. Үнэлгээний хүрээг тогтоосон байдал

№	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, хэсэг
1	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
2	Хоёрдугаар бүлэг. төрөөс эмийн талаар баримтлах бодлого, зохицуулалт, эм	5 дугаар зүйл. Эмийн зөвлөл
		6 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт,

	хангамжийн тогтолцоо, эм барих үйл ажиллагаа	худалдаа, түгээлт, хяналтын талаархи төрийн зохицуулалт 7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл 9 дүгээр зүйл. Эм хангамжийн байгууллага 10 дугаар зүйл. Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагааны зарчим, нийтлэг үүрэг 11 дүгээр зүйл. Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагаанд хориглох зүйл
3	Гуравдугаар бүлэг. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэх	12 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд тавих шаардлага 13 дугаар зүйл. Эмийн санд эм найруулах
4	Дөрөвдүгээр бүлэг. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх	14 дүгээр зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх 15 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлох
5	Тавдугаар бүлэг. Эмийн түгээлт	16 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагаа 18 дугаар зүйл. Эмийн хаяглалт, тэмдэглэгээ
6	Зургаадугаар бүлэг. Шинэ эм бүтээх	19 дүгээр зүйл. Шинэ эмийг хэрэглээнд гаргах 20 дугаар зүйл. Эмнэлзүйн өмнөх судалгаа 21 дүгээр зүйл. Эмнэлзүйн туршилт
7	Долдугаар бүлэг. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал	22 дугаар зүйл. Эмийн бүртгэл 23 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, хяналт 24 дүгээр зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн хяналт 25 дугаар зүйл. Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээлэл
8	Наймдугаар бүлэг. Эмийн мэдээлэл, зар сурталчилгаа	26 дугаар зүйл. Эмийн мэдээлэл 27 дугаар зүйл. Эмийн зар сурталчилгаа
9	Есдүгээр бүлэг. Бусад зүйл	28 дугаар зүйл. Эм хангамжийн үйл ажиллагаан дахь төрийн бус байгууллагын оролцоо 29 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Үнэлгээ хийх хүрээг тогтоох зорилгоор Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий ХХААХҮЯ, МЭЕГ, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ, БИОКОМБИНАТ ХХК, АНМЭГ, СДМЭТ, МЭҮН, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагын мэдээлэл, тайланд тандалтын судалгаа хийсний үндсэн дээр үнэлгээний хүрээг тогтоосон.

Үнэлгээ хийх явцад урьдчилан тогтоосон үнэлгээний хүрээг өргөжүүлэх, эсхүл багасгах нөхцөл байдал үүсч болно.

## 1.2. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тогтоох

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг тогтоохдоо Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийг бодитойгоор илэрхийлж чадах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзан сонгов.

Үнэлгээ хийх ажлын төлөвлөлтийн шатанд хийгддэг шалгуур үзүүлэлтийг тогтоох зорилго нь мал эмнэлгийн зориулалттай эм, түүний дотор уламжлалт эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна гэсэн зорилгоо бүрэн хангаж, зорилгодоо хүрсэн эсэхийг тогтоож, түүний хэрэгжилтийн явцыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг сонгох ажиллагаа юм.

Аргачлалын дагуу “практикт нийцэж байгаа байдал”, “хүлээн зөвшөөрөгдсөн байдал” гэсэн үндсэн шалгуур үзүүлэлтийг үнэлгээний хамрах хүрээнд тухайн зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийг хэмжих боломжтой гэдгийг харгалзан үзэж сонгож авсан болно.

Шалгуур үзүүлэлтийг сонгохдоо тухайн зүйл, хэсэг, заалтын "хэрэгжилтийг хамгийн сайнаар илэрхийлэн гаргаж ирэх" гэсэн шаардлагаар сонгосон бөгөөд тухайн хуулийн зохицуулалтад төдийлөн ач холбогдолтой бус шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

Хүснэгт 2. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тогтоосон байдал

№	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, хэсэг	Шалгуур үзүүлэлт
1	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	Практикт нийцэж байгаа байдал
2	Хоёрдугаар бүлэг. Төрөөс эмийн талаар баримтлах бодлого, зохицуулалт, эм хангамжийн тогтолцоо, эм барих үйл ажиллагаа	5 дугаар зүйл. Эмийн зөвлөл	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
		6 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтын талаархи төрийн зохицуулалт	Зорилгод хүрсэн түвшин
		7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл	Практикт нийцэж байгаа байдал
		9 дүгээр зүйл. Эм хангамжийн байгууллага	Практикт нийцэж байгаа байдал
		10 дугаар зүйл. Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагааны зарчим, нийтлэг үүрэг	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
		11 дүгээр зүйл. Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагаанд хориглох зүйл	Практикт нийцэж байгаа байдал
3	Гуравдугаар бүлэг. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэх	12 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд тавих шаардлага	Практикт нийцэж байгаа байдал
		13 дугаар зүйл. Эмийн санд эм найруулах	Практикт нийцэж байгаа байдал
4	Дөрөвдүгээр бүлэг. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх	14 дүгээр зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх	Практикт нийцэж байгаа байдал
		15 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлох	Практикт нийцэж байгаа байдал
5	Тавдугаар бүлэг. Эмийн түгээлт	16 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагаа	Практикт нийцэж байгаа байдал
		18 дугаар зүйл. Эмийн хаяглалт, тэмдэглэгээ	Практикт нийцэж байгаа байдал
6	Зургаадугаар бүлэг. Шинэ эм бүтээх	19 дүгээр зүйл. Шинэ эмийг хэрэглээнд гаргах	Практикт нийцэж байгаа байдал
		20 дугаар зүйл. Эмнэлзүйн өмнөх судалгаа	Практикт нийцэж байгаа байдал
		21 дүгээр зүйл. Эмнэлзүйн туршилт	Практикт нийцэж байгаа байдал
7	Долдугаар бүлэг. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал	22 дугаар зүйл. Эмийн бүртгэл	Практикт нийцэж байгаа байдал
		23 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, хяналт	Практикт нийцэж байгаа байдал
		24 дүгээр зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн хяналт	Практикт нийцэж байгаа байдал
		25 дугаар зүйл. Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээлэл	Практикт нийцэж байгаа байдал
8	Наймдугаар бүлэг. Эмийн мэдээлэл, зар сурталчилгаа	26 дугаар зүйл. Эмийн мэдээлэл	Практикт нийцэж байгаа байдал
		27 дугаар зүйл. Эмийн зар сурталчилгаа	Практикт нийцэж байгаа байдал
9	Есдүгээр бүлэг. Бусад зүйл	28 дугаар зүйл. Эм хангамжийн үйл ажиллагаанд төрийн бус байгууллагын оролцоо	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал

	29 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
--	--	-----------------------------

### 1.3. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний үндэс нь судалж буй зохицуулалтын талаарх ажиглагдаж буй болон хэмжиж болохуйц мэдээллийг цуглуулж, түүний зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулах явдал юм.

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практикт тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаан дээр үндэслэнэ.

Өөрөөр хэлбэл, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас нь үнэлэх учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрд тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээ хийх болно.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг үнэлэх сонгож авсан «зорилгод хүрсэн түвшин», «практикт нийцэж байгаа байдал», «хүлээн зөвшөөрөгдсөн байдал» шалгуур үзүүлэлтүүд нь хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь анх хуулиар тавьсан зорилгоо хангаж чадаж байгаа эсэхийг харьцуулах аргаар буюу уг хуулийг хэрэгжүүлэгч чиг үүрэг бүхий байгууллагын тайлан, статистик, мэдээллийг ашиглаж тодорхойлох болно.

Дээрх харьцуулалтын хэлбэрийн хүрээнд өнөөгийн өөрчлөгдөн буй эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, хөгжлийн хандлагад нийцэж байгаа эсэх, төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хэрхэн зохицуулж байгаа болон уг хуулийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг судалж тогтоох юм.

Хүснэгт 3. Үнэлгээний харьцуулах хэлбэр

№	Үнэлэх бүлэг	Үнэлэх зүйл, хэсэг	Харьцуулах хэлбэр
1	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
2	Хоёрдугаар бүлэг. төрөөс эмийн талаар баримтлах бодлого, зохицуулалт, эм хангамжийн тогтолцоо, эм барих үйл ажиллагаа	5 дугаар зүйл. Эмийн зөвлөл	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		6 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтын талаархи төрийн зохицуулалт	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		9 дүгээр зүйл. Эм хангамжийн байгууллага	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		10 дугаар зүйл. Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагааны зарчим, нийтлэг үүрэг	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		11 дүгээр зүйл. Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагаанд хориглох зүйл	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
3	Гуравдугаар бүлэг. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэх	12 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд тавих шаардлага	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		13 дугаар зүйл. Эмийн санд эм найруулах	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
4	Дөрөвдүгээр бүлэг. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх	14 дүгээр зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		15 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлох	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
5	Тавдугаар бүлэг. Эмийн түгээлт	16 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагаа	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших

		18 дугаар зүйл. Эмийн хаяглалт, тэмдэглэгээ	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
6	Зургаадугаар бүлэг. Шинэ эм бүтээх	19 дүгээр зүйл. Шинэ эмийг хэрэглээнд гаргах	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		20 дугаар зүйл. Эмнэлзүйн өмнөх судалгаа	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		21 дүгээр зүйл. Эмнэлзүйн туршилт	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
7	Долдугаар бүлэг. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал	22 дугаар зүйл. Эмийн бүртгэл	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		23 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, хяналт	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		24 дүгээр зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн хяналт	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		25 дугаар зүйл. Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээлэл	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
8	Наймдугаар бүлэг. Эмийн мэдээлэл, зар сурталчилгаа	26 дугаар зүйл. Эмийн мэдээлэл	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		27 дугаар зүйл. Эмийн зар сурталчилгаа	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
9	Есдүгээр бүлэг. Бусад зүйл	28 дугаар зүйл. Эм хангамжийн үйл ажиллагаан дахь төрийн бус байгууллагын оролцоо	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших
		29 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших

#### 1.4. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг, заалт бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтээ томъёолох юм.

Шалгуур үзүүлэлтийг томъёолох хүрээнд Хөрөнгийн үнэлгээний тухай хуулиар зохицуулсан зүйл тус бүрийг шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавих бөгөөд таамаглал дэвшүүлэх болон асуулт тавихдаа аль болох товч, тодорхой томъёолох зарчим баримтлан ажиллаа.

Хүснэгт 4. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг томъёолсон байдал

№	Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлтийн зорилго	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлтийн томъёолол
1	3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Мал эмнэлгийн практикт хэрэглэж хэвшсэн эсэх?
2	5 дугаар зүйл. Эмийн зөвлөл	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эмийн зөвлөлийн үйл ажиллагаа хэвийн хэрэгжиж байгаа эсэх?
3	6 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтын талаархи төрийн зохицуулалт	Зорилгод хүрсэн түвшин	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтын талаархи төрийн зохицуулалт практикт нийцэж буй байдал хэр байна вэ?
4	7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөл олгогддог эсэх?
	8 дугаар зүйл. Эм барих үйл	Практикт нийцэж	Хүчин төгөлдөр	Эм барих үйл ажиллагаа

	ажиллагаа эрхлэх	байгаа байдал	мөрдөж эхэлснээс хойших	эрхлэх үйл ажиллагаа малын эмийн санд хийгддэг эсэх?
5	9 дүгээр зүйл. Эм хангамжийн байгууллага	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эм хангамжийн байгууллага шинээр нэмэгдсэн эсэх?
6	10 дугаар зүйл. Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагааны зарчим, нийтлэг үүрэг	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Уг зарчим нь цаг үетэйгээ нийцэж чадаж байгаа эсэх буюу практикт нийцэж буй байдал хэр байна вэ?
7	11 дүгээр зүйл. Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагаанд хориглох зүйл	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эм хангамжийн байгууллагын үйл ажиллагаанд хориглох зүйл хэрэгжсэн эсэх?
8	12 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд тавих шаардлага	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд тавих шаардлага мөрдөгдөж буй эсэх?
9	13 дугаар зүйл. Эмийн санд эм найруулах	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эмийн санд эм найруулах үйл ажиллагааг хийгддэг эсэх?
10	14 дүгээр зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх шийдвэр байгаа эсэх?
11	15 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлох	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлох лиценз олгодог эсэх?
12	16 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагаа	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагаа хяналт тавьдаг эсэх?
13	18 дугаар зүйл. Эмийн хаяглалт, тэмдэглэгээ	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эмийн хаяглалт, тэмдэглэгээг хэрэглэж хэвшсэн эсэх?
14	19 дүгээр зүйл. Шинэ эмийг хэрэглээнд гаргах	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын шинэ эмийг хэрэглээнд гаргаж буй эсэх?
15	20 дугаар зүйл. Эмнэлзүйн өмнөх судалгаа	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эмэнд эмнэлзүйн өмнөх судалгаа хийгддэг эсэх?
16	21 дүгээр зүйл. Эмнэлзүйн туршилт	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эмэнд эмнэлзүйн туршилт судлагаа хийгддэг эсэх?
17	22 дугаар зүйл. Эмийн бүртгэл	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эмийн бүртгэлтэй эсэх?
18	23 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, хяналт	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, хяналт хийгддэг эсэх?
19	24 дүгээр зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн хяналт	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн хяналт байгаа эсэх?
20	25 дугаар зүйл. Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээлэл	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээлэлийн сантай эсэх?

21	26 дугаар зүйл. Эмийн мэдээлэл	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Малын эмийн мэдээллийг ямар эх сурвалжаар хүргэдэг эсэх?
22	27 дугаар зүйл. Эмийн зар сурталчилгаа	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Мал, амьтны эмийн зар сурталчилгааг хяналттай эсэх?
23	28 дугаар зүйл. Эм хангамжийн үйл ажиллагаан дахь төрийн бус байгууллагын оролцоо	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Эм хангамжийн үйл ажиллагаан дахь төрийн бус байгууллагын оролцоо хэрхэн эсэх?
24	29 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	Практикт нийцэж байгаа байдал	Хүчин төгөлдөр мөрдөж эхэлснээс хойших	Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага хүлээдэг эсэх?

### 1.5. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Үнэлгээ хийх шалтгаан, үнэлгээний хүрээ, тогтоосон шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр, томъёолсон шалгуур үзүүлэлтүүдээс хамаарч тоон болон чанарын мэдээллийг ашиглаж дараах мэдээлэл цуглуулах аргыг ашигласан болно. Үүнд:

- ✦ *Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах.* Хуулийн хэрэгжилттэй МЭЕГ, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ, БИОКОМБИНАТ ТӨХХК, АНМЭГ-ийн тайлан, статистик тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалж зэргийг ашигласан.
- ✦ *Холбогдох субъектүүдээс судалгаа авах.* Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага, МЭЕГ, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ, БИОКОМБИНАТ ТӨХХК, АНМЭГ-аас нэмэлт мэдээлэл, тодруулга, тайлбарыг авсан.

### ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргыг ашиглан 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд хэрэгжилтийн үе шатыг хийж гүйцэтгэв. Энэ үе шатанд холбогдох төрийн байгууллагатай уулзалт ярилцлага хийж, холбогдох тоо баримт, судалгааны ажил зэргийг судалж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулан ашигласан болно.

**2.1. Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах:** Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд ХХААХҮ-ийн сайдаар батлуулсан 6 захиргааны хэм хэмжээ тогтоосон актууд, хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн тоон мэдээлэл зэрэг бэлэн байгаа мэдээлэлд тулгуурласан болно.

**2.2. Судалгааны аргаар цуглуулсан мэдээлэл:** Хуулийн хэрэгжилтийн явцын талаар тандалтын судалгааг МЭЕГ, УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ, БИОКОМБИНАТ ТӨХХК, АНМЭГ-ийн тайлан, статистик тоо баримт, мэдээллийг цуглуулсан болно.

### ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатанд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулиас сонгож авсан үнэлэх зүйл, хэсэг, заалт бүрийг хэрэгжүүлэх үе шатанд олж авсан мэдээлэл дээр тулгуурлан үнэлэв.

**3.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Мал эмнэлгийн практикт дараах нэр томъёолол хэрэгжилт бүрэн хэрэгжиж байна. Үүнд:

- а) 3.1.1."эм" гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэлзүйн сорилт туршилтаар нотлогдсон, нийлэг буюу амьтан, ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорхой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэлийг;
- б) 3.1.2."биобэлдмэл" гэж хүний болон мал, амьтны өвчнийг эмчлэх, оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалтаар амьд бие, бие махбодь, түүний эд, эсээс болон лабораторийн аргаар гаргаж авсан бүтээгдэхүүнийг;

- с) 3.1.4."оношлуур" гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, түүний явцыг хянах зорилгоор хүн, мал, амьтанд болон орчны сорьцын шинжилгээнд хэрэглэдэг, тодорхой тун, хэмжээ, найрлага, өвөрмөц чанар, идэвх бүхий бүтээгдэхүүнийг;
- д) 3.1.9."эмийн түүхий эд" гэж эмчилгээний идэвхт бодис агуулсан цэвэр язгуур махбодь, нийлэг болон ургамал, амьтан, эрдсийн гаралтай зүйлийг;
- е) 3.1.10."эмийн туслах бодис" гэж эм үйлдвэрлэх, найруулахад зайлшгүй шаардлагатай нэмэлт зүйлийг;
- ф) 3.1.11."цуврал" гэж үйлдвэрлэлийн технологийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн эмийн бүтээгдэхүүний багцын тоо хэмжээг;
- г) 3.1.12."эмийн үнэлэмж" гэж эмийн чанар, аюулгүй байдал, үйлчлэлийн идэвхийг эм зүй, эм судлал болон эмнэлзүйн судалгаагаар нарийвчлан тогтоосон илэрхийллийг;
- х) 3.1.13."эмийн бүртгэл" гэж хими, биологи, эм судлал, эмийн үнэлэмжийн үндсэн дээр урьдчилан сэргийлэлт, оношлогоо, эмчилгээнд хэрэглэж болох нь нотлогдсон эмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэглээнд гаргахыг зөвшөөрөх үйл ажиллагааг;
- и) 3.1.14."зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт" гэж хүн болон мал, амьтанд үзүүлэх эмнэлгийн тусламжид эн тэргүүнд хэрэглэхээр эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан эм, эмнэлгийн хэрэгслийн нэрсийг;
- й) 3.1.15."эм барих" гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.17-д заасныг;
- к) 3.1.16."эмийн жор" гэж эмчээс эм зүйч, эм найруулагчид хандан эмийг тухайн өвчтөнд зориулан бэлтгэх, олгох, хэрэглэх аргыг заасан баримт бичгийг;
- л) 3.1.17."эмийн зохистой хэрэглээ" гэж эмийг шаардлагатай тохиолдолд эмч, эм зүйчийн заавар, зөвлөмжийн дагуу зөв хэрэглэхийг;
- м) 3.1.19."фармакопейн өгүүлэл" гэж эмэнд тавих шаардлага, чанарын үзүүлэлт болон тэдгээрийг шинжлэх аргыг заасан зайлшгүй мөрдөх стандартыг;
- н) 3.1.20."фармакопей" гэж фармакопейн өгүүллийн эмхтгэлийг;
- о) 3.1.21."хуурамч эм" гэж хууль бусаар ашиг олох зорилгоор эм үйлдвэрлэгчийн нэрээр хуурамч шошго хэрэглэж, дуурналган үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг;
- р) 3.1.22."эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр" гэж эмийн түүхий эд болон эмийн туслах бодис ашиглан эм зүйн технологийн дагуу эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;
- қ) 3.1.23."эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага" гэж эмийн сан, эрүүл мэндийн байгууллага болон мал эмнэлгийг эм, эмнэлгийн хэрэгслээр бөөний үнээр хангах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;
- г) 3.1.24."эмийн сан" гэж эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, хүн амыг эм, эмнэлгийн хэрэгслээр жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

Дээрх хуульд заасан нэр томъёолол нь мал эмнэлгийн практик нийцэж байгаа харуулж байна. Түүнчлэн практикт дараах хуульд заасан нэр томъёолол хэрэглээ багатай байна. Тухайлбал:

*Хүснэгт 5. Хэрэглээ багатай нэр томъёололыг үнэлсэн үнэлгээ*

№	Хуулийн заалт	Шалтгаан	
1	3.1.3."уламжлалт эм" гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх зорилгоор тодорхой тун, хэмжээгээр хэрэглэдэг, уламжлалт анагаах ухааны жорын дагуу ургамал, амьтан, эрдсийн гаралтай бодис болон үнэт эрдэнэс оруулан уламжлалт болон үйлдвэрийн аргаар бэлдсэн байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг;	"уламжлалт эм"-ийг мал эмнэлгийн практикт уламжлалт жорын дагуу хэрэглэх байдал бага бөгөөд эрдэм шинжилгээ, судалгааны зориулалтаар ашиглаж байна. Үйлдвэрийн аргаар бэлдсэн байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл бага болно.	Практикт нийцүүлэн хэрэглэх боломжтой.

2	3.1.5."эмнэлгийн хэрэгсэл" гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, сувилах болон бие махбодийн бүтэц, үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашигладаг туслах зориулалтын эд зүйлийг;	Мал эмнэлгийн зориулалттай "эмнэлгийн хэрэгсэл"-ийг 100 хувь импортын хамралтай. Үйлдвэрлэл хөгжөөгүй.	Практикт нийцүүлэн хэрэглэх боломжтой.
3	3.1.6."мансууруулах эм" гэж донтуулах нөлөөлөл үзүүлдэг, "Мансууруулах эмийн тухай" 1961 оны Нэгдсэн Конвенцийн жагсаалтад орсон эм бэлдмэлийг;	"мансууруулах эм", "сэтгэцэд нөлөөлөх эм"-ийн хэрэглээ бага бөгөөд сүүлийн жилүүдэд жижиг, амьтны хувийн эмнэлэгүүдэд мэс заслын зориулалтаар хэрэглэж эхэлж байна. Одоогор Хүний эм ханган нийлүүлэх байгууллагаас худалдан авч мал эмнэлгийн зориулалтаар хэрэглэж байна.	Практикт нийцүүлэн хэрэглэх боломжтой.
4	3.1.7."сэтгэцэд нөлөөлөх эм" гэж сэтгэцэд хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, "Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай" 1971 оны Конвенцийн жагсаалтад орсон бодисыг;		Практикт нийцүүлэн хэрэглэх боломжтой.
5	3.1.8."өнчин эм" гэж ховор тохиолддог өвчнийг эмчлэхэд болон улсын хэмжээгээр харьцангуй бага хэрэглэдэг эмийг;	Мал эмнэлэгт одоогоор ховор тохиолддог өвчин бүртгэгдээгүй бөгөөд сүүлийн жилүүдэд вирусийн гаралтай олон улсын хорио цээрт өвчнүүд бүртгэгдэж байгаа тул энэ хуульд заасан томьёолол хэрэглэгддэггүй.	Мал эмнэлгийн практикт нийцэхгүй.
6	3.1.18."эмийн гаж нөлөө" гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг оношлох, эмчлэх зорилгоор зохист тунгаар хэрэглэхэд бие махбодид гарч болзошгүй болон гарч байгаа сөрөг илэрлийг;	Мал эмнэлгийн салбарт "эмийн гаж нөлөө" бүртгэгдэж байгаагүй болно.	Практикт нийцүүлэн хэрэглэх боломжтой.
7	3.1.25."биологийн идэвхт бүтээгдэхүүн" гэж хүний бие махбодийн үйл ажиллагааг дэмжих, зайлшгүй шаардлагатай эрдэс бодисоор нөхөх, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ бүхий бүтээгдэхүүнийг.	Мал эмнэлгийн салбарт тэжээлийн нэмэлт гэсэн нэр томьёолоор хэрэглэж байна. Хүн эмнэлгийн салбарт энэ нэр томьёолоор ашиглах боломжтой.	Практикт нийцүүлэн хэрэглэх боломжгүй.

*Хүснэгт 6. Шинээр хуульд нэмэлт оруулах үеэр шаардлагатай нэр томьёололыг үнэлсэн үнэлгээ*

№	Хуулийн заалт	Шалтгаан	
1	"эмжүүлсэн тэжээл"	Олон улсын болон Дэлхий амьтны эрүүл мэндийн байгууллагын шаардлагад нийцүүлэх шаардлага үүссэн.	Практикт нийцүүлэх шаардлагатай.
2	"эмийн сэрэмжлүүлэг" (Pharmacovijilance)	Олон улсын болон Дэлхий амьтны эрүүл мэндийн байгууллагын шаардлагад нийцүүлэх шаардлага үүссэн.	Практикт нийцүүлэх шаардлагатай.
3	"Бичил биетний тэсвэржилт"	Олон улсын болон Дэлхий амьтны эрүүл мэндийн байгууллагын шаардлагад нийцүүлэх шаардлага үүссэн.	Практикт нийцүүлэх шаардлагатай.
4	"Эмийн чанар"	Олон улсын болон Дэлхий амьтны эрүүл мэндийн байгууллагын шаардлагад нийцүүлэх шаардлага үүссэн.	Практикт нийцүүлэх шаардлагатай.

5	“Бичил биетний эсрэг эм”	Олон улсын болон Дэлхий амьтны эрүүл мэндийн байгууллагын шаардлагад нийүүлэх шаардлага үүссэн.	Практикт нийцүүлэх шаардлагатай.
6	“Өсөлт идэвхжүүлэгч”	Олон улсын болон Дэлхий амьтны эрүүл мэндийн байгууллагын шаардлагад нийүүлэх шаардлага үүссэн.	Практикт нийцүүлэх шаардлагатай.
7	“Шинжилгээний нийцэлт арга”	Олон улсын болон Дэлхий амьтны эрүүл мэндийн байгууллагын шаардлагад нийүүлэх шаардлага үүссэн.	Практикт нийцүүлэх шаардлагатай.
8	“Скринингийн арга”	Олон улсын болон Дэлхий амьтны эрүүл мэндийн байгууллагын шаардлагад нийүүлэх шаардлага үүссэн.	Практикт нийцүүлэх шаардлагатай.
9	“Баталгаажуулалтын арга”	Олон улсын болон Дэлхий амьтны эрүүл мэндийн байгууллагын шаардлагад нийүүлэх шаардлага үүссэн.	Практикт нийцүүлэх шаардлагатай.
10	“Үйлдвэрлэлийн зохистой дадал”	Олон улсын болон Дэлхий амьтны эрүүл мэндийн байгууллагын шаардлагад нийүүлэх шаардлага үүссэн.	Практикт нийцүүлэх шаардлагатай.
11	“дархлаажуулах бэлдмэл”	Олон улсын болон Дэлхий амьтны эрүүл мэндийн байгууллагын шаардлагад нийүүлэх шаардлага үүссэн.	Практикт нийцүүлэх шаардлагатай.

3.2. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Эмийн зөвлөлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2017 оны А/49 дугаар баталсан “Малын эмийн салбар зөвлөлийн ажиллах дүрэм”-ийн дагуу малын эмийн зөвлөл үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Малын эмийн салбар зөвлөл нь холбогдох төрийн захиргааны болон хяналтын асуудал эрхэлсэн байгууллага, сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн байгууллагын төлөөлөл оролцсон 9 –өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш малын эмийн салбар зөвлөл нь дараах үүргийн дагуу үйл ажиллагаа явуулж ирсэн. Үүнд:

1. Эмийн үндэсний бодлогын асуудлаар санал, зөвлөмж боловсруулж холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар хэлэлцүүлэх;
2. Эмийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтэд дүгнэлт өгөх, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар Эмийн үндэсний зөвлөлд санал, танилцуулга, зөвлөмж бэлтгэж өгөх;
3. Эм, биобэлдмэл, эмийн түүхий эдийг бүртгэх, өөрчлөлт оруулах асуудлыг эмийн үндэсний бодлогын хүрээнд шийдвэрлэх;
4. Мал эмнэлгийн зориулалтаар хэрэглэж буй эм, эмийн түүхий эдийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, эмийн мэдээлэл, зар сурталчилгааны агуулгын асуудлаар хяналт тавих, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж гаргах, энэ талаар нийтэд мэдээлэх;
5. Мал эмнэлгийн зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг шинэчлэх, хэрэглээнд шаардагдах эмийн нэр төрөлд хяналт тавих, эмчилгээ, оношлогоонд олон улсын жишигт нийцсэн эм хэрэглэх асуудлаар зөвлөмж гаргах;
6. Мал эмнэлгийн зориулалтаар хэрэглэж буй эмийн лавлах товхимол гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх;
7. Эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах;
8. Мал, амьтны биед дасах болон гаж нөлөө ихтэй эмийг хориглох, хязгаарлах асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргах;
9. Эмийн чанар, аюулгүй байдал, хүн, мал, амьтны биед үзүүлж байгаа нөлөөллийн талаар гарсан санал, гомдлын дагуу тухайн эм, бэлдмэлийг шалгалт туршилтад хамруулах, дүгнэлт гаргаж, нийтэд мэдээлэх;
10. Эрх хэмжээний асуудлаар олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах, туршлага солилцох, улс, орон нутгийн чанартай хуралд оролцох, зохион байгуулах.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль 2017 онд батлагдснаар малын эмийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг Мал эмнэлгийн ерөнхий газрын чиг үүрэгт харьяалагдаж “Малын эмийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2019 оны А/14 дугаар тушаалаар шигэчлэн баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.


Хууль хэрэгжих хугацаанд 827 эм, вакцин, эмийн түүхий эдийг мал эмнэлгийн эмийн бүртгэлд бүртгэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. /Хавсралт 2 үзүүлэв./

**3.3. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтын талаархи төрийн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Малын эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналттай холбоотой үйл ажиллагааг төрийн зүгээс нэгдсэн зохицуулалтыг дараах бүтэц, мэргэжлийн байгуулагууд улсын хэмжээнд хэрэгжүүлж байна.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28.1-д зааснаар мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах тогтолцоо нь улсын хэмжээнд мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллага, аймаг, нийслэлд мал эмнэлгийн байгууллага, лаборатори, сум, дүүрэгт мал эмнэлгийн тасаг, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс бүрдэнэ гэж заасан.

Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор УИХ болон Засгийн газраас дараах тогтоолыг баталсан. Үүнд:



✚ “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их хурлын 2018 оны 05 сарын 30 өдрийн 41 дүгээр тогтоолоор Мал эмнэлгийн ерөнхий газрыг байгуулав.

✚ “Засгийн газрын агентлагийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн 186 дугаар тогтоолоор Мал эмнэлгийн ерөнхий газрын бүтэц, орон тоог батлав.

✚ “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн 188 дугаар тогтоолоор Мал эмнэлгийн ерөнхий газрын харьяанд “Биокомбинат” улсын төсөвт үйлдвэрийн газар, “Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулж, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газрыг ажиллуулахаар батлав.

✚ “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ний өдрийн 267 дугаар тогтоолоор Аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, сум, мал бүхий дүүрэгт Мал эмнэлгийн тасаг байгуулахаар батлав.

*Мал эмнэлгийн боловсон хүчин:* Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, мал аж ахуйн гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийг хангахад нийт 9 төрийн болон орон нутгийн мал эмнэлгийн байгууллага, 1 хувийн хэвшлийн байгууллагуудад нийт 3089 ажиллагсад ажиллаж байгаа бөгөөд үүнээс хувийн хэвшлийн нэгжүүдэд 1449 малын их, бага эмч ажиллаж байна.

Хүснэгт 7. Мал эмнэлгийн салбарын ажиллагсад:

№	Төрийн болон орон нутгийн байгууллагууд	Ажиллагсад
1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	3
2	Мал эмнэлгийн ерөнхий газар	44

3	Аймаг, нийслэлийн газар, лаборатори	457
4	Биокомбинат ТӨААУҮГ	254
5	Сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг	674
6	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори	52
7	Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын лаборатори	28
8	Мал эмнэлгийн биотехнологийн их сургууль	40
9	Мал эмнэлгийн хүрээлэн	88
10	Хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж	1449
Нийт		3089

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газар

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар 22 аймаг, нийслэлд Хувийн мал эмнэлгийн үйлчилгээний 1038 нэгжид 797 их, 426 бага эмч ажиллаж, малын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг гардан хэрэгжүүлж байна.

Хүснэгт 8. Хувийн хэвшлийн Мал эмнэлгийн нэгжийн ажиллагсад /2022 оны байдлаар/:

№	Аймгийн нэр	МЭҮН тоо	Ажиллаж буй эмчийн тоо		
			МЭҮН-д ажиллаж байгаа малын их эмч	МЭҮН-д ажиллаж байгаа малын бага эмч	Нийт малын эмчийн тоо
1	Архангай	41	44	40	84
2	Баян-Өлгий	61	10	51	61
3	Баянхонгор	49	46	41	87
4	Булган	55	48	14	62
5	Говь-Алтай	56	25	31	56
6	Говьсүмбэр	10	9	3	12
7	Дархан-Уул	11	9	4	13
8	Дорноговь	31	38	1	39
9	Дорнод	52	18	7	25
10	Дундговь	38	48	8	56
11	Завхан	51	38	26	64
12	Орхон	7	9	4	13
13	Өвөрхангай	48	37	12	49
14	Өмнөговь	36	30	9	39
15	Сүхбаатар	58	61	19	80
16	Сэлэнгэ	47	33	18	51
17	Төв	92	62	34	96
18	Увс	72	39	23	62
19	Ховд	44	27	17	44
20	Хөвсгөл	89	60	28	88
21	Хэнтий	74	81	28	109
22	Нийслэл	16	25	8	33
Дүн		1038	797	426	1223

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газар

Хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг ажлын ачааллыг тооцон үзэхэд нэг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 67.0 мянган толгой мал, нэг малын эмчид 44.2 мянган толгой мал тус тус ногдож байна.

**Биокомбинат ХХК:** Биокомбинат УТҮГ нь 1923 онд байгуулагдсан ба 1973 онд Унгар Улсын техник, эдийн засгийн тусламжтайгаар бүрэн шинэчлэлт хийгдэж малын халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, биобэлдмэл болон оношлогооны бэлдмэл үйлдвэрлэн ажиллаж байна.

Тус үйлдвэр нь дотоодын цэргээр хамгаалуулсан “Улсын онц чухал объект” бөгөөд нийт 12.8 га газрыг хамарсан газарт 37 объект, барилга байгууламж ашиглагдаж, нийтдээ 250 гаруй ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж байна. Биокомбинат үйлдвэр нь жилдээ улсын захиалга даалгавраар улсын төсвөөс

нийт 10.0-12.0 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 44 нэр төрлийн 120,000-130,000 литр малын шингэн вакцин болон биобэлдмэл, 18.0-25.0 сая тун хатаасан вакцин, биобэлдмэл үйлдвэрлэдэг.

#### **Улсын Мал Эмнэлэг Ариун Цэврийн Төв Лаборатори (УМЭАЦТЛ):**

Тус лаборатори нь Монгол Улсын Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Малын эрүүл мэндийн талаар талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, улсын хэмжээнд мал, амьтны элдэв өвчин, хордлогыг оношлох, гадаад, дотоодын зах зээлд борлуулах мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон хашаа байр, тэжээл, ус, хөрс, ургамалд ариун цэвэр, эрүүл ахуйн үзлэг, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, баталгаажуулан гэрчилгээ олгох, орон нутгийн мал эмнэлгийн шинжилгээний байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангах зорилготой.

- Мал, амьтны гоц халдварт өвчнийг биоаюулгүй нөхшлийн дор оношлох, тандах, дүгнэлт гаргах, оношийг шаардлагатай үед олон улсын лавлагаа лабораториор баталгаажуулах;
- Мал, амьтны халдварт, паразиттах, халдваргүй өвчин, хордлогыг оношлох, тандан судлах, мал сүргийг эрүүлжсэний баталгаа гаргах, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд лабораторийн аргаар хяналт тавих, малын өвчний гаралтад шалтгаалах гадаад орчны хүчин зүйлийг тогтоох, дүгнэлт гаргах
- Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд эрүүл ахуй, ариун цэврийн магадлан шинжилгээ, мал, амьтны эд эрхтэн, тэжээл, үр тариа, хүнсний ногоо, жимс, ус, хөрс, ургамалд биохими, мөөгөнцөр, цацраг, хор судлал, эм, химийн бодисын үлдэгдлийн, бэлчээрийн ургамал, ус, өвс, тэжээл, малын байранд эрүүл ахуйн шинжилгээ хийж үзүүлэлтүүдийг тогтоох, чанарын үнэлгээ өгөх, баталгаажуулах;
- Малын өвчний гаралт, тархалт, онош, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуйн үзүүлэлтийн талаар холбогдох байгууллагыг байнгын мэдээллээр хангах, мал, амьтны өвчин, хордлогоос сэргийлэх талаар олон нийтэд мэдээлэх, сэрэмжлүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх;
- Мал эмнэлгийн лаборатори, мал аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэл, худалдаа, үйлдвэрлэлийн аж ахуйн дэргэдэх лабораторийн шинжлэгч нарт сургах, дадлагажуулах, арга зүйгээр хангах, нарийн мэргэжлийн чиглэлээр богино хугацааны дамжаа, семинар, зөвлөлгөөн зохион байгуулах;
- Эрхэлсэн асуудлаар хөрөнгө оруулалт хийх, шинжлэх ухаан, технологийн болон болон технологи нэвтрүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, судалгаа хийх, бүтээл хэвлүүлэх.

Тус лаборатори нь 2009 оноос хойш гоц халдварт өвчний оношлогоо тандалтын, халдварт, паразиттах өвчний оношлогоо тандалтын, хүнсний эрүүл ахуй үлдэгдлийн шинжилгээний, байгаль орчноос шалтгаалах өвчний оношлогоо-тандалтын, санхүү аж ахуйн гэсэн 5 тасагтай, нарийн мэргэжлийн 18 лабораторитой, шинжилгээ судалгаанд 386 төрлийн багаж төхөөрөмж, 640 нэрийн оношлуур, урвалж бодис, 450 нэрийн туслах хэрэглэгдэхүүнийг ашиглан, үндсэн үйл ажиллагааг явуулж байна.

УМЭАЦТЛ нь 1999, 2001, 2003, 2005, 2007, 2010, 2015, 2019 ондуудад олон улсын болон үндэсний стандартын байгууллагаар итгэмжлэгдсэн.

Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй ариун цэврийн баталгаажуулалт, мал эмнэлгийн оношлогоо, шинжилгээг УМЭАЦТЛ болон аймаг, нийслэлийн 22 лаборатори, аймаг, нийслэлийн томоохон зах, худалдааны төвийн 37, нийт 50 гаруй лабораториуд үйл ажиллагаа явуулж байна.

Малын эмийн үлдэгдлийн чиглэлээр Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторит шинжилгээг олон улсад зөвшөөрөгдсөн арга зүйн дагуу хийж байна.

Зураг 4. Мал эмнэлгийн сүлжээ лабораториудын байршил:



Монгол улсын хэмжээнд экспортын болон олон хүн төвлөрсөн хот суурин газрын хэрэгцээний мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийн эрүүл ахуй, ариун цэвэр, эмийн болон химийн бодисын үлдэгдлийг хянах, шинжилгээ хийх үүргийг УМЭАЦТЛ, орон нутгийн мал эмнэлгийн лаборатори өвчний оношлогоо, эрүүл ахуй, ариун цэврийн баталгаажуулалтыг хариуцан ажиллаж байна.

УМЭАЦТЛ-д 2000 онд үлдэгдлийн шинжилгээний лаборатори, 2003 онд Олон улсын атомын энергийн агентлагийн төслөөр нянгийн өсөлтийг саатуулах, фермент холбоот эсрэг биенийн урвалаар малын эмийн үлдэгдлийг тодорхойлох, 2004 онд КОИСА байгууллагаас авч хэрэгжүүлсэн “Мал эмнэлгийн эрүүл ахуйн лабораторийн шинжилгээний чадавхийг сайжруулах” төслийн хүрээнд өндөр мэдрэмжит шингэний хроматографи (HPLC) болон бусад багаж, тоног төхөөрөмж, эм урвалжаар хангагдаж, малын гаралтай бүтээгдэхүүнд үлдэгдэл илрүүлэх шинжилгээг тогтмол хийж байна.

Хүснэгт 9. УМЭАЦТЛ-ийн эмийн үлдэгдлийн шинжилгээний чадавхи:

№	Үлдэгдэл бодисын нэр	Түүхий эд, бүтээгдэхүүн	Арга зүй
1	Нянгийн эсрэг бодисын үлдэгдэл	Сүү Эд эрхтэн, засаг, өндгөн дэх	Таван хавтангийн арга Зургаан хавтангийн арга
2	Сульфаметазин үлдэгдэл	Сүү, бөөр, маханд	Тоон шинжилгээний өрсөлдөөнт ЭЛИЗА
3	Хлорамфеникол	Шээс, сүү, хуурай сүү, өндөг, эд, мах, самхорхой, засаг, ийлдэс, бал, тэжээлд	Тоон шинжилгээний өрсөлдөөнт ЭЛИЗА
4	Тетрациклин	Сүү, мах, зөгийн баланд	Тоон шинжилгээний өрсөлдөөнт ЭЛИЗА
5	Ивермектин	Шээс, ийлдэс, эд, сүүнд	Тоон шинжилгээний өрсөлдөөнт ЭЛИЗА
6	фуразолидон	Загас, сам хорхой, тэжээл, мах /үхэр, тахиа, гахай/, өндөг, бал, сүү, ийлдэс, шээсэнд	Тоон шинжилгээний өрсөлдөөнт ЭЛИЗА
7	стрептомицин	Тэжээл, бал, бөөр, элэг, мах, /үхэр, тахиа, гахай/, сүү, ийлдэс, шээсэнд	Тоон шинжилгээний өрсөлдөөнт ЭЛИЗА
8	Глютен	Сүү, хуурай сүү, улаан буудайнд	Шууд болон өрсөлдөөнт ЭЛИЗА
9	Меламин	Малын тэжээлд	Шууд болон өрсөлдөөнт ЭЛИЗА
10	Тетрациклин /окситетрациклин, тетрациклин, хлортетрациклин/	Эд, мах, өндгөнд	Шингэний хроматограф
11	Бензимидазол /тиабендазол, мебендазол, флюбендазол, албендазол, фенбендазол/	Эд, маханд	Шингэний хроматограф

12	Сульфонамидууд /сульфеметазин, сульфамеразин, сульфамонетоксин, сульфахинолин/	Эд, мах, сүү, өндгөнд	Шингэний хроматограф
13	Хлорафенокол	Эд, маханд	Шингэний хроматограф
14	Авермектины үлдэгдэл	Элгэнд	Шингэний хроматограф
15	Моксидектины үлдэгдэл		
16	Хлорамфеникол болон бусад антибиотик пестицидийн үлдэгдлийн баталгаажуулалт		Хийн хроматограф / масспектрометр

Эх сурвалж: УМЭАЦТЛ

**Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори (МЭЭСБУЛ):** Монгол улсад үйлдвэрлэгдэж, импортлогдож, шинээр зохион бүтээгдэж буй мал амьтны гоц халдварт, халдварт, паразиттах болон халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, оношлох эм, биобэлдмэл, эмийн түүхий эдэд хими, биологи, вирусологи, бактериологи, паразитологийн сорилт шинжилгээ хийж, сорилтын дүн, баталгаажуулалтын дүгнэлт, тохирлын гэрчилгээ олгох эрх бүхий нарийн мэргэжлийн байгууллага юм.

Лабораторийн зорилго нь мал эмнэлгийн зориулалтаар үйлдвэрлэгдэж, импортлогдож, зохион бүтээгдэж буй эм, биобэлдмэл, эмийн түүхий эдэд чанарын шалгалт хийх, мал эмнэлгийг чанартай баталгаатай эм, биобэлдмэлээр хангах төрийн бодлогыг дэмжихэд оршино.

Лабораторийн үндсэн чиг үүрэг:

- ↓ Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж Монгол улсын мал эмнэлгийн ажил үйлчилгээг фармакопейн шаардлага хангасан, эм, биобэлдмэлээр тасралтгүй хангахад дэмжлэг үзүүлэх;
- ↓ Малын эмийн салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх;
- ↓ Малын эмийн шалгалтанд чанарын удирлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэх;
- ↓ Шинээр зохион бүтээгдэж байгаа болон нийлүүлэгдэж буй эм, биобэлдмэлийн чанар аюулгүй байдал, стандартын төсөлд санал оруулах.

Лабораторийн Баталгаажуулалтын алба болон Сорилтын лаборатори нь анх 2004 онд MNS ISO/IEC 17025 болон MNS ISO/IEC 17065 стандартын дагуу шалгуулж итгэмжлэгдэж лабораторийн эрх авсан бөгөөд 2007 болон 2009, 2017 онуудад дахин итгэмжлэгдэж итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтын дагуу малын эм, биобэлдмэл, эмийн түүхий эдэд сорилт, баталгаажуулалт гүйцэтгэж байна.

Олон улсын фармакопей-8 боть, Монгол улсын фармакопей-2 боть /185 өгүүлэл/, 60 Монгол улсын стандарт, Дагалдах НТББ-ийн хүрээнд шинжилгээ, баталгаажуулалтыг явуулж байна.

**Мал Эмнэлгийн Хүрээлэн (МЭХ):** Мал эмнэлгийн хүрээлэн нь Монгол улсын мал эмнэлгийн шинжлэх ухааны цорын ганц байгууллагын хувьд мал, амьтны гоц халдварт, халдварт, паразиттах болон халдваргүй өвчнүүдийн оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шинжлэх ухааны үндэстэй боловсруулах, үндэсний технологи бүхий шинэ эм, биобэлдмэл зохион бүтээх, мал эмнэлгийн арга хэмжээг боловсронгуй болгох, шинэ технологи, арга, аргачлал боловсруулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх замаар мал сүргийг эрүүлжүүлэх зорилгын хүрээнд онолын болон хавсарга судалгааны ажил гүйцэтгэж ирлээ.

Одоо тус хүрээлэн нь Халдварт өвчин, дархлаа судлал, Вирус судлал, Эрүүл ахуй, ариун цэвэр, Эмгэг судлал, Молекул генетикийн лаборатори, Хачиг, шавж, эгэл биетэн судлал, Гельминт судлалын лаборатори, Малын бодис солилцоо, биохимийн лаборатори, Үржлийн эмгэг, даавар судлалын лаборатори, Төлийн физиологи, эмгэг судлалын лаборатори, Эм, хор судлалын лаборатори гэсэн нийт 11 лаборатори, Захиргаа, аж ахуйн нэгж, туршлагын жижиг амьтны Вивар, Биобэлдмэлийн цех, туслах аж ахуй бүхий бүтэцтэйгээр ажиллаж байна.

МЭХ-гийн ойрын ирээдүйн зорилт нь өөрийн орны мал эмнэлгийн эрдэм шинжилгээний толгойлогч байгууллагын хувьд ойрын ирээдүйн зорилт чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна:

- ↓ Мал эмнэлгийн эрдэм судлалын ажлын арга зүйг дэлхийн хөгжилтэй орнуудын мал эмнэлгийн байгууллагын түвшинд хүрэхэд чиглүүлэх;

- ✚ Тус орны мал эмнэлгийн шинжлэх ухааны өнөөгийн хүрсэн төвшинг цааш нь улам гүнзгийрүүлэн тэргүүний хөгжилтэй орнуудын ижил төстэй байгууллагуудтай гадаад харилцаагаа өргөтгөх;
- ✚ Биотехнологийн орчин үеийн шинэ шинэ ололтод тулгуурлан молекул биологийн судалгааг эрчимтэй явуулж, зарим өвчнийг найдвартай сэргийлэх амьд болон мутант рекомбинант вакцин, пробиотик бэлдмэл ELISA-оношлогооны дан язгуурт өвөрмөц эсрэгтөрөгч, конъюгатууд, цаашилбал полимеразын гинжин урвалын праймер, дан язгуурт эсийн эсрэгбием зэргийг эх орондоо бэлтгэх технологи боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх талаар тус хүрээлэнгийн ажилтнуудын оюуны хүчийг чиглүүлэх;
- ✚ Эсийн физиологи, эмгэг физиологийн in vivo, in vitro судалгааны орчин үеийн арга зүйг ашиглан төрөл бүрийн өвчний эмгэг жамыг нарийвчлан судлах боломжийг бүрдүүлэх;
- ✚ Эрдэм шинжилгээний ажлыг оновчтой төлөвлөх арга зүйн түвшинг байнга дээшлүүлэх, бүтээлийн онол, практикийн ач холбогдол, чанар өгөөжийг дээшлүүлэхийн тулд хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөс тавих хяналт шаардлагыг эрс өндөржүүлэхэд онцгой анхаарах;
- ✚ Тус хүрээлэнгээс сонгомол аргаар эртэмтэдийн зохион бүтээсэн вакцин ийлдэс, оношлуур ургамал амьтны гаралтай эм бэлдмэлийн идэвхит чанарыг дээшлүүлэхийн зэрэгцээ ДНХ-ийн эрлийзжүүлэг, генийн инженерчлэл, ген шилжүүлэн суулгах, эд зохицлын иж бүрдэл, цагаан эсийн гадаргуугийн ялгарлын кластер, идэвхжүүлсэн эсүүдийн шүүрэл болох интерлейкинүүд болон интерферон зэргийг ашиглан бактери болон вирусийн эсрэг үүсэх дархлалыг идэвхжүүлэх;
- ✚ Малын үржин төлжих чадавхийг дээшлүүлэх халдваргүй өвчин эмчлэн сэргийлэх зориулалтаар биологийн гаралтай эм бэлдмэлийн технологийн шийдлийг боловсронгуй болгох, шинээр зохион бүтээх, нэгэнт бий болсон технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд ихээхэн анхаарал тавьж ажиллах.

**Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори (МЭЛ)** нь мал, амьтаны өвчнийг лабораторийн аргаар оношлох, тандан судлах болон мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд ариун цэврийн шинжилгээ хийж дүн, дүгнэлт гаргах үүрэгтэй.

Иймд Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон мал эмнэлгийн эм зүйн үйл ажиллагаанд оролцогч хуулийн этгээдийн чиг үүргийн зохицуулалтгүй байна.

### 3.4. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг мөрдөж байсан бөгөөд энэ хуулийг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр баталсан зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцно. Энэ хуулийг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр баталсан Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон.

Зөвшөөрлийн тухай хуульд Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр дараах тусгай зөвшөөрөл олгохоор заасан. Үүнд:

1. тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх;
2. сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архинаас бусад согтууруулах ундаа үйлдвэрлэх;
3. таримал ургамлын үр үйлдвэрлэх;
4. малын эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох;
5. ургамал хамгаалахад ашиглах бодисыг импортлох, борлуулах;
6. шинээр малын үүлдэр, омог бий болгох, үр, өндгөн эс, хөврөлийг үйлдвэрлэх, үйлчилгээнд нэвтрүүлэх, бичил биетнийг өсгөвөрлөх, мал, үржүүлгийн бүтээгдэхүүн гадаадад гаргах, гадаадаас сайжруулагч мал, амьтан авах;

Хуулийн 8.1 дугаар зүйлийн 12.2 хэсэгт “Малын эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрлийг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгоно.” гэж заасны дагуу тусгай зөвшөөрлийг олгож байна.

Мөн хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.4 дахь хэсэгт “мал, амьтны тэжээлийн нэмэлт, эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлох” энгийн зөвшөөрлийг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага олгохоор заасан.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль батлагдан мөрдөгдөж эхэлснээс хойш 110 аж ахуй нэгж малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрлийг байгууллага, аж ахуй нэгжид олгосон байна. Өнөөдрийн байдлаар нийт 91 байгууллага, аж ахуй нэгж эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх, 7 байгууллага, аж ахуй нэгж эм үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг холбогдох хуульд заасаны дагуу олгосон байна. (Хавсралт 1-д үзүүлэв)

**3.5. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 8 дугаар зүйл. Эм барих үйл ажиллагаа эрхлэх хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Эм барих үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагааг мал эмнэлгийн Хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж Малын эмийн санд ажиллаж буй итгэмжлэл бүхий малын их эмч гүйцэтгэж байна. Улсын хэмжээнд 22 аймаг, нийслэл, 330 сум 6 дүүршийн Хувийн мал эмнэлгийн үйлчилгээний 1038 нэгжид 1223 их эмч хэрэгжүүлж байна.

Нийслэлд 49 эмийн сан, аймаг, нийслэлд 37, нийт улсын хэмжээнд 86 эмийн сан үйл ажиллагаа явуулж байна.

Вакцины 90 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, бусад эм, нян, шимэгчийн эсэрэг бэлдмэлийг 100 хувь импортоор худалдан хэрэглэж байна.

**3.6. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 9 дүгээр зүйл. Эм хангамжийн байгууллага хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Түүнчлэн малын эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх 91, үйлдвэрлэгч 6 аж ахуй нэгж, байгууллага, 60 малын эмийн сан ажиллаж байна. (Хавсралт 1-д үзүүлэв)

**3.7. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 10 дугаар зүйл. Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагааны зарчим, нийтлэг үүрэг хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Эм хангамжийн байгууллага нь үйл ажиллагаандаа эмийн бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр мал эмнэлгийн байгууллагыг жигд хангах зарчмыг баримтлан ажиллаж ирсэн.

Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх 91 аж ахуй нэгж, байгууллага ажиллаж байна. (Хавсралт 1-д үзүүлэв)

**3.8. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 11 дүгээр зүйл. Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагаанд хориглох зүйлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

*Хүснэгт 10. Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:*

Хуулийн заалт	Хэрэгжилт
11.1.1.энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөлгүйгээр эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах;	Малын эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх 91, үйлдвэрлэгч 6 аж ахуй нэгж, байгууллага холбогдох хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авч ажиллаж байна.
11.1.2.Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, чанарын баталгаажуулалтгүй, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлэх;	Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, чанарын баталгаажуулалтгүй эмийг хилийн боомт бүхий аймгуудын иргэд, малчид оруулах асуудал Мэргэжлийн хяналтын байгууллагаар тогтоогдож байсан. Тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжүүдэд зөрчил гарч байгаагүй болно.
11.1.3.эм, эмнэлгийн хэрэгслийг эм хангамжийн байгууллагаас бусад эх үүсвэрээс авах;	Зөрчил гарч байгаагүй болно.
11.1.4.эм барих зөвшөөрөлгүй этгээдийг эм найруулах, бэлтгэх, шалгах, олгох үйл ажиллагаанд оролцуулах;	Зөрчил гарч байгаагүй болно.
11.1.5.эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага иргэдэд эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах;	Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага иргэдэд эм, худалдах зөрчил гардаг. Ялангуяа малчдад худалдах зөрчил их гардаг.
11.1.6.ашиг, орлогоо нэмэгдүүлэх зорилгоор эмчийг эм, эмнэлгийн хэрэгсэл худалдах, үр дүнгээр нь урамшуулах буюу түүнтэй адилтгах үйл ажиллагаанд оролцуулах;	

11.1.7.хуурамч эм үйлдвэрлэх, импортлох, худалдах.	БНХАУ-тай хил залгаа Дорнод, Сүхбаатар аймгуудад улсыг бүртгэлд бүртгэгдээгүй эм, биобэлдмэлийг оруулж ирэх зөрчил гарч байгаагүй болно.
--	--

**Хүснэгт 11. Эмнэлгийн үйл ажиллагаанд дараахь зүйлийг хориглоно:**

Хуулийн заалт	Хэрэгжилт
11.2.1.эм барих эрхгүй мэргэжилтнээр эм барих үйл ажиллагаа эрхлүүлэх;	Зөрчил гарч байгаагүй болно.
11.2.2.эмийн хадгалалт, хамгаалалтын журам зөрчих.	
11.3.Зориулалтын бус газар эм, эмнэлгийн хэрэгсэл хадгалах, худалдахыг хориглоно.	Сум, дүүрэг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүд зөрчил их гардаг.

**3.9. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 12 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд тавих шаардлагын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд тавигдах үндсэн шаардлагыг үйлдвэрлэл эрхлэх 6 аж ахуй нэгж байгууллагуудад хангуулж байна.

“Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгслийг ханган нийлүүлэх байгууллагад тавих шаардлага” MNS 6461:2020 стандартыг стандарт хэмжил зүйн газрын 2020 оны 02 дугаар сарын 21-ний А/44 дугаар тушаалаар батлан, энэхүү стандартаар мал эмнэлгийн бусад эм хангамжийн байгууллагуудыг стандартад нийцсэн, чанарын баталгаатай, байгаль орчин, хүн, мал, амьтанд аюулгүй мал, амьтны эм, тэжээлийн нэмэлт, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй, хүртээмжтэй, жигд хангах үйл ажиллагаанд мөрдөх ерөнхий шаардлагуудыг тогтооно. Энэхүү стандартыг мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх /цаашид МАЭЭХНБ/ үйл ажиллагаа эрхлэх, тусгай зөвшөөрөл олгох, байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, дүгнэлт гаргахад мөрдүүлэн ажиллаж байна.

**3.10. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 13 дугаар зүйл. Эмийн санд эм найруулахын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Малын эмийн сангийн үйл ажиллагаа эрхэлж буй эмийн сангуудад малын эмчийн жорын дагуу эмийн бүртгэлд бүртгэгдсэн үндсэн түүхий эд, чанарын шаардлага хангасан туслах түүхий эдийг ашиглан эмийн санд эм найруулах үйл ажиллагаа хийгддэггүй. Нийт эмийн 90 гаруй хувийг импортоор худалдан авдаг болно.

“Мал, амьтны эмийн санд тавих ерөнхий шаардлага” MNS 5545:2020 стандартыг стандарт хэмжил зүйн газрын 2020 оны 02 дугаар сарын 21-ний А/44 дугаар тушаалаар батлуулан, энэхүү стандартаар мал эмнэлгийн байгууллага болон малчин, мал бүхий иргэдийг чанарын баталгаатай, эмчилгээний идэвхтэй, аюулгүй эм, тэжээлийн нэмэлт, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангах, эмзүйн тусламж үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага болон мэргэжилтэнд тавигдах шаардлагыг тогтоон. хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**3.11. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомт, улсын хилээр нэвтрүүлэхээр чиг үүргийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын “Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх хилийн боомтыг тогтоох тухай” 2011 оны 73 дугаар тогтоолоор Эм, эмнэлгийн хэрэгслийг Чингис хаан, Сүхбаатар, Алтанбулаг, Замын-Үүд, Гашуунсухайт, Ханги боомтоор нэвтрүүлж байхаар тогтоосон.

**3.12. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 15 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлохын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал 2010 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/212 дугаар тушаалаар “Мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох лиценз олгох журам”-ыг батлуулан, Монгол Улсын нутаг дэвсгэрт Мал эмнэлгийн зориулалттай эм, биобэлдмэл (вакцин, ийлдэс, оношлуур) эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэх бодисийг импортлох лиценз олгох хэрэгжилтийг зохион байгуулж байна.

Мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох лиценз олгоход дараах шаардлагыг хангасан аж ахуй нэгж, байгууллагуудад олгож байна. Үүнд:

- ✚ Эм, эмнэлгийн хэрэгслийг импортлох байгууллага нь “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 15.11.4 дэх заалтын дагуу төрийн захиргааны төв байгууллагаас малын эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөлтэй байна.
- ✚ Эм, эмнэлгийн хэрэгслийг импортлохыг хүссэн эм ханган нийлүүлэх байгууллага нь дараахь бичиг баримтыг бүрдүүлсэн байна.
  - хуулийн этгээдийн аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар
  - эм, эмнэлгийн хэрэгслийг импортлох үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
  - импортлогчийн гадаадын эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэгч байгууллагатай байгуулсан худалдааны гэрээ, итгэмжлэл эсвэл албан ёсны төлөөлөл болохыг нотлох баримт,
  - эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн гэрчилгээний хуулбар, /эмнэлгийн хэрэгсэл, оношлуурд хамаарахгүй/
  - эм, эмийн түүхий эд бүтээгдэхүүний гарал үүсэл, чанарын сертификат, тохирлын гэрчилгээ
  - экспортлогч орны эмийн цувралын чанарын баталгаажилт
  - эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн олон улсын болон тухайн орны чанар баталгаажилтын болон гарал үүслийн гэрчилгээ, хэрэглэх заавар
  - үйлдвэрлэгч эсвэл нийлүүлэгчийн / GMP, ISO / олон улсын чанар стандартын шаардлага хангасан гэрчилгээ
- ✚ Эм, биобэлдмэл импортлох үед:
  - a) ачаа, тээврийн баримтын гаальд бүртгэгдсэн эх хувь (AWB)
  - b) баглаа, боодлын дэлгэрэнгүй бүртгэл, нэхэмжлэлийн хуулбар
  - c) үйлдвэрлэгчээс олгосон сертификат

Мал эмнэлгийн зориулалттай эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох лицензийг дунджаар сард 4 аж ахуй нэгж, жилдээ 48 лицензийг олгож байна.

**3.13. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 16 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, малын эмийн сангуудад ажиллаж буй малын эмч нь эм хангамжийн байгууллагаас авсан малын эм, эмнэлгийн хэрэгслээр мал, амьтан бүхий иргэнд үйлчилж байна.

Малын эмийн санд малын эмийг жоргүйгээр олгох зөрчил ихээр гарч байна. Жороор олгох эмийн зохицуулалт хэрэгжихгүй байна. Тухайлбал: жороор олгох эмийг жоргүйгээр, мал, амьтны зориулалттай эм, эмнэлгийн хэрэгслийг хүнд хэрэглэхээр олгох зэрэг болно. Жор бичилтийн журам, стандарт боловсрогдож батлагдаагүй.

**3.14. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 18 дугаар зүйл. Эмийн хаяглалт, тэмдэглэгээний хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Мал эмнэлгийн зориулалттай эм, биобэлдмэл (вакцин, ийлдэс, оношлуур) эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэх бодисийг хуульд заасан эмийн сав, баглаа боодол дээрх хаяглалт, тэмдэглэгээг мөрдүүлэн ажиллаж байна.

- ✚ эмийн худалдааны болон олон улсын нэр, хэлбэр;
- ✚ тун, хэмжээ, тоо ширхэг;
- ✚ үйлдвэрлэгчийн нэр;
- ✚ цувралын дугаар;
- ✚ хэрэглэх арга;
- ✚ үйлдвэрлэсэн он, сар, өдөр, хүчинтэй хугацаа;
- ✚ олгох нөхцөл;
- ✚ хадгалах нөхцөл;
- ✚ Монгол Улсын эмийн бүртгэлийн дугаар.
- ✚ Мал, амьтны эм гэж бүртгэгдсэн эмийн савлалт дээр "Мал, амьтанд зориулсан" гэсэн бичээс байна.

Тухайлбал: Биокомбинат ХХК-аас үйлдвэрлэж буй 50 гаруй нэрийн мал эмнэлгийн зориулалттай нийт 10.0-12.0 тэрбум төгрөгний үнэ бүхий 44 нэр төрлийн 120,000-130,000 литр малын шингэн вакцин болон биобэлдмэл, 18.0-25.0 сая тун хатаасан вакцин, биобэлдмэл, малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн 589 нэрийн эмийн хаяглалт, тэмдэглэгээг шаардлагад нийцүүлсэн.

3.15. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 19, 20, 21 дүгээр зүйл. Шинэ эмийг хэрэглээнд гаргах, Эмнэлзүйн өмнөх судалгаа, Эмнэлзүйн туршилт, ын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Мал эмнэлгийн хүрээлэн нь Монгол улсын мал эмнэлгийн шинжлэх ухааны цорын ганц байгууллагын хувьд мал, амьтны гоц халдварт, халдварт, паразиттах болон халдваргүй өвчнүүдийн оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шинжлэх ухааны үндэстэй боловсруулах, үндэсний технологи бүхий шинэ эм, биобэлдмэл зохион бүтээх, мал эмнэлгийн арга хэмжээг боловсронгуй болгох, шинэ технологи, арга, аргачлал боловсруулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх замаар мал сүргийг эрүүлжүүлэх зорилгын хүрээнд онолын болон хавсарга судалгааны ажил гүйцэтгэж байна.

Хууль хэрэгжснээс хойших хугацаанд сүүлийн 8 жилийн хугацаанд Шинжлэх ухаан технологийн 15 төсөл, Инновацийн 17 төсөл, Цөм технологийн 1 төслийг хэрэгжүүлж, 18 Вакцин оношлуурын технологи, 44 Эм, биобэлдмэлийн технологи, 38 Патент тус тус шинээр гаргасан байна.

✚ “Сүүний магадлан шинжилгээний цомог, меламина илрүүлэх аргачлал” дэд сэдэвт бүтээгдэхүүн:

- Сүүний магадлан шинжилгээний цомог
- Махны магадлан шинжилгээний цомог,

✚ “Эрдэст элементийн дутагдлаас үүсдэг малын эндемик өвчнийг оношлох, эмчлэх, сэргийлэх эм бэлдмэлийн технологи” дэд сэдэвт бүтээгдэхүүн:

- Тамир бэлдмэл
- Эрдэст нэмэгдэл тэжээл
- Купрад Б
- Иодын тест
- Калдимаг Г

✚ “Пробиотик бэлдмэлийн туршилт, үйлдвэрлэл, нийлүүлэлт” дэд сэдэвт бүтээгдэхүүн:

- Тэжээлийн нэмэлт “Лактобактерин стх” пробиотик
- Тэжээлийн нэмэлт “Целлюлолит” бэлдмэл
- Пробиотик
- Лакто-паст
- Бифидо-лакт

✚ “Малын ороог идэвхжүүлэх, олон өндгөн эс гадагшлуулах амьтны гаралтай дааврын болон эдийн бэлдмэлийн технологи” дэд сэдэвт бүтээгдэхүүн:

- Хээлтэй гүүний ийлдэс
- Неогистол-1
- Неогистол-2
- Пептидол бэлдмэл
- Овариопептид бэлдмэл

✚ “Нөхөн үржихүйн эмгэгээс сэргийлэх, эмчлэх эм бэлдмэлийн технологи” дэд сэдэвт бүтээгдэхүүн:

- Амин дэм-эрдэс-уургийн хосолмол бэлдмэл
- Амин дэм-эрдэс-уургийн зэхмэл
- Мал тэнхрүүлэх бэлдмэл -1
- Хаг унагаах бэлдмэл
- Шар буурцгийн бэлдмэл

✚ “Мал, амьтны хордлогыг эмчлэх, сэргийлэх эм, бэлдмэлийн технологи” дэд сэдэвт бүтээгдэхүүн:

- Карбитин бэлдмэл
- Полинат (хтс-3) бэлдмэл
- Кремкол бэлдмэл
- Чемшир бэлдмэл

✚ Биобэлдмэлийн бүтээгдэхүүн:

"Акритракт" бэлдмэл, "Цармон" нэмэгдэл  
тэжээлийг үйлдвэрлэн нийлүүлэх" 2011-2013.

"Малын халдварт өвчний оноолуур,  
праймер, эмчлэх сэргийлэх шинэ  
эмийн үйлдвэрлэл" 2012-2013.

"Адууны сальмонеллёзыг оноилох түргэвчилсэн оноолуурыг шинэ  
технологийн" 2012-2014.

"Малын сааны үрэвсэл, өндгөвчийн эмгэгээс  
сэргийлэх, шингэцийг нэмэгдүүрх бэлдмэлийн  
үйлдвэрлэл" 2012-2014.

"Гахайн сальмонеллёз өвчнийг оноилох оноолуур,  
урьдчилан сэргийлэх вакцин үйлдвэрлэл" 2013-2015

Гүүний вирус (Герпес-1)-т хэвл хаялтаас сэргийлэх эсийн  
өгсгөөрт амьд вакцины үйлдвэрлэл 2013-2015.6.

"Экспортын зориулалттай, зураг агуулсан хүнсний  
нэмэлт бүтээгдэхүүн" 2014.6-2015.12

"Малын гадар, дотор паразитын эсрэг үйлчилгээтэй  
арьсанд дусааж хэрэглэх "Монгоур" бэлдмэлийг  
үйлдвэрлэлд нэвтрүүлэх" төсөл, 2014-2015.

"Мал эмчлэх, мал аж ахуйн салбарт ашиглах  
микробиологийн бэлдмэлийн үйлдвэрлэл, хэрэглээг бий  
болгох" 2014-2016.

"Малын шинэ эмийн үйлдвэрлэл" 2015-2016.

"Монгаструм бэлдмэлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх"  
2016-2018.

"Нэг дамжлагаар импортыг орлох байгалийн  
гаралтай гураан төрлийн бэлдмэл үйлдвэрлэх  
нь" 2016-2018.

"Одой далан түрүүнээс гаралтай "2С" бэлдмэлийг  
үйлдвэрлэлд нэвтрүүлэх нь" ИТ, 2017-2018.

#### 4 Шинээр гаргасан малын өвчний оноолуурууд

Үхрийн шүтхийг шүүд бус фермент холбоот эсрэг  
биохимийн урсалаар оноилох цомог

*B. anthracis*-ийн эсрэг биом илрүүлэх рекомбинант  
оноолуур (МЭХ)

Галзуу өвчний түргэн оноолуур (МЭХ)

Үхрийн лейкоз оноилох нэгчин тундаасжуулах  
урвалын цомог

Адууны нийлүүлэгчийн өвчний түргэн тест (МЭХ)

Адууны ямыг оноилох шүүд иммунофлуоресцент ур  
валын ийлдэс

Үхрийн цусан халдварыг оноилох флуоресцент  
ийлдэс

Малын бруцеллёзыг оноилох нэгчин тундаасжих  
урвалын эсрэгтөрөгч

Үхрийн бруцеллёзыг оноилох шүүд бус фермент  
холбоот урвалын цомог

Гахайн сальмонеллёзыг оноилох нэгчин  
тундаасжих урвалын Полисахаридын эсрэгтөрөгч

Гахайн сальмонеллёзыг оноилох наалдуулах  
урвалын эсрэгтөрөгч



↓ Үйлдвэрлэлд нэвтрүүлсэн оношлуурууд:

1	Гахайн сальмонеллээ оношлох Нэвчин тундасжих урвалын эсрэгтөрөгч MNS -5439 : 2005, Хяналтын эерэг ийлдэс MNS -5440 : 2005	цомог	тун	450	400
2	Ям өвчин оношлох Шууд иммунофлуоресцент урвалын флуоресцент ийлдэс	цомог	тун	2,500	380
3	Цусан халдварыг оношлох Шууд иммунофлуоресцент урвалын ийлдэс	цомог	тун	2,500	400
4	Үхрийн лейкоз оношлох НТУ-ын цомог	цомог	тун	450	1000
5	Адууны бабезиозын үүсгэгч T. equi-ийн оношлох ФХЭБУ-ын цомог MNS 6174:2010	цомог	тун	5,000	575
6	Адууны бабезиозын үүсгэгч B. caballi-ийг оношлох ФХЭБУ-ын цомог MNS 6175:2010	цомог	тун	5,000	675
7	Нийлүүлгийн өвчний үүсгэгч T.equiperdum-ийн эсрэг үүсэх эсрэг бием илрүүлэх түргэн оношлуур (МЭУФӨ энэ онд гарна)	цомог	ширхэг	4,000	1420
8	Нийлүүлгийн өвчний үүсгэгч T.equiperdum-ийг оношлох ФХЭБУ-ын цомог (МЭУФӨ болон МУ-ын стандарт гарна)	цомог	ширхэг	5,000	700
9	Боомын ЭЛИЗА цомог	цомог	цомог		25
10	Мах, махан бүтээгдэхүүний магадлан шинжилгээний цомог, Техникийн шаардлага стандарт MNS 6035:2009	Цомог	ширхэг	50,000	25
11	Сүү, сүүн бүтээгдэхүүний магадлан шинжилгээний цомог, Техникийн шаардлага MNS 6269:2011	цомог	ширхэг	55,000	25

↓ Шинээр гаргасан вакцинууд:

*Шүдхийг үе эсргийлэх тосон адьюванттай 3 цэнэт Монгол вакцин*

*Үхрийн цусан халдвараас эсргийлэх амьд вакцин*

*Бруцеллёзоос эсргийлэх B.abortus 159 № 5-R омгийн вакцин*

*Гахайн сальмонеллёзоос эсргийлэх идэвхигүйжүүлсэн вакцин*

*Гахайн сальмонеллээ, колибактериозоос эсргийлэх хам вакцин*

*Бог малын шовоог яраас эсргийлэх эсийн өсгөвөрт амьд вакцин*



↓ Мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтран ажиллаж буй эм үйлдвэрлэлийн гарааны компаниуд:

- “Гарааны рецептор” ХХК
- “Гарааны монбиотик” ХХК
- “Гарааны нэмэлт тун” ХХК
- “Гарааны вет био тех” ХХК
- “Гарааны праймер” ХХК

**3.16. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 22 дугаар зүйл. Эмийн бүртгэлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль батлагдан мөрдөгдөж эхэлснээс хойш хуулийн “22.6.Улсын бүртгэлд эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүн бүртгэх, түргэвчилсэн журмаар бүртгэх, хугацаа, бүртгэлийн төлбөр тогтоох, зарцуулах журмыг эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

үйлдвэрийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/49 тушаалаар /2 дугаар хавсралт/ батлан хэрэгжилтийг хангасан. Өнөөдрийн байдлаар малын эмийн бүртгэлд 589 эм бүртгэгдсэн. Малын эмийн бүртгэлийг цахимжуулалтын <https://vetdrug.mn/> систем рүү шилжүүлэх үйл ажиллагааг 2019 оноос эхлүүлээд байна. . (Жагсаалтыг хавсралтад үзүүлэв)

**3.17. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 23 дугаар зүйл. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, хяналтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

МЭЭСБУЛ нь Монгол Улсад үйлдвэрлэгдэж, импортлогдож, шинээр зохион бүтээгдэж буй мал амьтны гоц халдварт, халдварт, паразиттах болон халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, оношлох эм, биобэлдмэл, эмийн түүхий эдэд хими, биологи, вирусологи, бактериологи, паразитологийн сорилт шинжилгээ хийж, сорилтын дүн, баталгаажуулалтын дүгнэлт, тохирлын гэрчилгээ олгох эрх бүхий нарийн мэргэжлийн байгууллага гүйцэтгэж байна.

Лабораторийн зорилго нь мал эмнэлгийн зориулалтаар үйлдвэрлэгдэж, импортлогдож, зохион бүтээгдэж буй эм, биобэлдмэл, эмийн түүхий эдэд чанарын шалгалт хийх, мал эмнэлгийг чанартай баталгаатай эм, биобэлдмэлээр хангах төрийн бодлогыг дэмжихэд оршино.


Лабораторийн үндсэн чиг үүрэг:

- ↳ Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж Монгол улсын мал эмнэлгийн ажил үйлчилгээг фармакопейн шаардлага хангасан, эм, биобэлдмэлээр тасралтгүй хангахад дэмжлэг үзүүлэх;
- ↳ Малын эмийн салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх;
- ↳ Малын эмийн шалгалтанд чанарын удирлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэх;
- ↳ Шинээр зохион бүтээгдэж байгаа болон нийлүүлэгдэж буй эм, биобэлдмэлийн чанар аюулгүй байдал, стандартын төсөлд санал оруулах.

Лабораторийн Баталгаажуулалтын алба болон Сорилтын лаборатори нь анх 2004 онд MNS ISO/IEC 17025 болон MNS ISO/IEC 17065 стандартын дагуу шалгуулж итгэмжлэгдэж лабораторийн эрх авсан бөгөөд 2007 болон 2009, 2017 онуудад дахин итгэмжлэгдэж итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтын дагуу малын эм, биобэлдмэл, эмийн түүхий эдэд сорилт, баталгаажуулалт гүйцэтгэж байна.

Олон улсын фармакопей-8 боть, Монгол улсын фармакопей-2 боть /185 өгүүлэл/, 60 Монгол улсын стандарт, Дагалдах НТББ-ийн хүрээнд шинжилгээ, баталгаажуулалтыг явуулж байна.

Зураг2. Малын эмийн бүртгэл, чанарын баталгаажуулалт



**3.18. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 24 дугаар зүйл. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн хяналтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:**

Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн хэрэглээ бага бөгөөд жижиг амьтны хувийн эмнэлэгт мэс засал зориулалтаар, мал эмнэлгийн эрдэм шинжилгээ судалгаа, сургалтын байгууллагад туршилтад хэрэглэж байна. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийг хүний эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагаас худалдан авах замаар хэрэглээг хангаж байна.

3.19. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 25 дугаар зүйл.Эмний гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Малын эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийн нэгдсэн байхгүй бөгөөд цаашид малын эмийн бүргэлийн цахим сан <https://vetdrug.mn/> өргөтгөн, хэрэжүүлэх боломжтой.

Мал эмнэлгийн зориулалтаар эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээллийг бүртгэж байгаагүй бөгөөд мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлоход импортлогч улс орнууд гаж нөлөөг бүртгэсэн байхыг шаарддаг. Иймд цаашид эмийн гаж нөлөөг бүртгэх зохицуулалтыг хуульд оруулах шаардлагатай байна.

3.20. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 26 дугаар зүйл.Эмний мэдээллийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Эмний мэдээллийг мэргэжлийн байгууллагаас бүрэн хянах, иргэд, аж ахуй нэгж, малчдад хүргэх мэдээллийн нэгдсэн сан хөгжөөгүй байна.

3.21. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 27 дугаар зүйл. Эмийн зар сурталчилгааны хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Мал эмнэлгийн салбарт жоргүй олгох эм, тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүнийг мэргэжлийн хэвлэл болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилах зохицуулалт сайжруулах шаардлагатай. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлт бүтээгдэхүүний зар сурталчилгааны агуулгыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, болон Мал эмнэлгийн ерөнхий газраас хяналт сул байна.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлт ханган нийлүүлэгч, үйлдвэрлэгч цахим (facebook) хаягаар сурталчилгааг хийж байна. Тухайлбал: Малын санчдын нэгдсэн бүлэг



3.22. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 28 дугаар зүйл. Эм хангамжийн үйл ажиллагаан дахь төрийн бус байгууллагын оролцооны хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Малын эмийн хангамжийн үйл ажиллагаанд дараах төрийн бус байгууллагууд идэвхитэй оролцож байна. Үүнд:

- ✚ Монголын мал эмнэлгийн дундын хоршоо ТББ
- ✚ "МОНГОЛ ВИ. И.ТИ. НЕТ" ТББ
- ✚ Хувийн малын эмч нарын холбоо ТББ

3.23. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 29 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх харцуцлагын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ:

Хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага, мөн зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага тус тус хүлээлгэнэ гэж заасан.

Зөрчлийн тухай хуульд:

6.4 дүгээр зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих

1.Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөлтэй мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй, сэтгэцэд нөлөөт эм, бодис, тэдгээрийн түүхий эдийг:

1.1.эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл, экспортлогч, импортлогч талууд байгуулсан гэрээнд заасан нэр төрөл, тоо, хэмжээнээс хэтрүүлсэн;

1.2.эмийн сан, эм ханган нийлүүлэх байгууллагад зохих зөвшөөрөлгүйгээр олгосон бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй, сэтгэцэд нөлөөт эм, бодис, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг:

2.1.үйлдвэрлэх;

2.2.бэлтгэх;

2.3.боловсруулах;

2.4.хадгалах;

2.5.бүртгэх;

2.6.хуваарилах;

2.7.тээвэрлэх;

2.8.улсын хилээр нэвтрүүлэх;

2.9.устгах журам зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй, сэтгэцэд нөлөөт эм, бодисыг:

3.1.зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн худалдаалсан;

3.2.зохих зөвшөөрөлгүйгээр худалдаалсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

#### **6.6 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль зөрчих**

1.Эм, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, шинэ эм хэрэглээнд гаргах шаардлага, нөхцөлийг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Эм, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, эсхүл экспортлоход тавигдах шаардлага, эсхүл хориглох зүйлийг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. /Энэ хэсэгт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./ Тайлбар: Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчил гаргасан этгээдийн зардлаар улсын бүртгэлд бүртгэгдээгүй, улсын бүртгэлийн загвараас зөрүүтэй /өнгө, дүрс, бичгийн хэлбэр зэрэг/ эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхгүйгээр гаалийн хяналтын бүсээс буцаана./Энэ тайлбарт 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан./

3.Эмнэлгийн мэргэжилтэн:

3.1.эмийн жор, эм олгохдоо хэрэглэх арга, хадгалах нөхцөл, эсхүл зохистой хэрэглээний талаар буруу мэдээлэл өгсөн;

3.2.эмийн жорыг стандартын дагуу бичээгүй;

3.3.жороор олгох эмийг жоргүйгээр олгосон;

2. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын мал эмнэлгийн улсын байцаагч нарыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлсэн ч өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон мал эмнэлгийн улсын байцаагчийн эрх үүрэг зохицуулагдаагүй байгаа нь үйл ажиллагааны хийдлийг үүсгэх эрсдэл бий болгож байна.

3. Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн үйлдвэрлэл, төрөл, тоо хэмжээ нэмэгдэж, орчин үеийн дэвшилтэт технологи нэвтэрч, эм, эмнэлгийн хэрэгслийн хүртээмж сайжирч байгаа хэдий ч мал эмнэлгийн практикт бичил биетний эсрэг эмийн тэсвэржилт, малын эмийн үлдэц, малын эмийн зохисгүй хэрэглээ үүсэх эрсдэл нэмэгдэж байгаа тул зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байна.

4. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад эмийн зохистой хэрэглээ ихээхэн чухал. Нэг талаас малчид, мал бүхий иргэн, аж ахуй нэгж өөрсдөө дур мэдэн эм хэрэглэх, хэт дөвийлгөн сурталчилж буруу мэдээлэл түгээх, мал эмнэлгийн эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм, биобэлдмэлийг хэрэглэх зэрэг зөрчил гарсаар байна. Иймд эдгээр асуулдыг хуульчлах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Дэлхий дахинаа эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хурдацтай хөгжиж байгаа нь мал эмнэлгийн эмчилгээ, оношилгооны шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, эмийн худалдаа, хангамж, эмийн бүртгэл, баталгаажуулалт, эмийн нэгдсэн цахим бүртгэлийг нэвтрүүлэх, эмийн зохистой хэрэглээ, төрөөс баримтлах зарчим, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хяналт, мал эмнэлгийн эм, био бэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл олгох, төрийн зохицуулалт болон хяналт, дархлаажуулалт зэрэг хууль, эрх зүйн зохицуулалтыг цогцоор нь тусгах хэрэгцээ бий болоод байна.

### 3.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох:

*Асуудал 1. Эмийн чанар аюулгүй байдал хангагдаагүй:*

- ✦ Мал эмнэлгийн эмийн нэгдсэн зохицуулалтгүй, хариуцлагыг тодорхойлоогүй
- ✦ Зохистой дадлын шаардлагуудын хэрэгжилт хангалтгүй
- ✦ Эм хангамжийн байгууллага чанар, аюулгүй байдлаа бүрэн хариуцахгүй.

*Асуудал 2. Эмийн зохисгүй хэрэглээ түгээмэл:*

- ✦ Иргэд, малчид, амьтан өмчлөгчийн мэдлэг хангалтгүй;
- ✦ Малыг эмч нарын мэдлэг- эмийн үйлдэл, харилцан үйлчлэлийн талаарх дутмаг;
- ✦ Жороор эм олгодоггүй;
- ✦ Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг ёс зүйгүй, борлуулалтыг дэмжсэн хэлбэрээр явуулдаг.

*Асуудал 3. Эмийн хангамж хүртээмж жигд бус:*

- ✦ Хэрэгцээт эмийнхээ 100 гаруй хувь, биобэлдмэлийн 10 хувийг импортоор хангадаг;
- ✦ Эмийн худалдан авалтын зохион байгуулалт оновчгүйгээс тасалдал үүсэх явдал байсаар байна.

*Асуудал 4. Хуулийн нэр томъёоны тодорхойлолтод шинэ нэр томъёолол тусгах:*

- ↓ “эмжүүлсэн тэжээл”
- ↓ “эмийн сэрэмжлүүлэг”
- ↓ “Бичил биетний тэсвэржилт”
- ↓ “Эмийн чанар”
- ↓ “Бичил биетний эсрэг эм”
- ↓ “Өсөлт идэвхжүүлэгч”
- ↓ “Шинжилгээний нийцэлт арга”
- ↓ “Скринингийн арга”
- ↓ “Баталгаажуулалтын арга”
- ↓ “Үйлдвэрлэлийн зохистой дадал”
- ↓ “дархлаажуулах бэлдмэл”

*Асуудал 5: Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх, эмийн үлдэцээс сэргийлэх зохицуулалтгүй:*

- ↓ Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх, тэсвэржсэн бичил биетнийг илрүүлэх, хянах үйл ажиллагаа нь эрсдэлийн үнэлгээ;
- ↓ Хүнсний бүтээгдэхүүн дэх мал эмнэлгийн эмийн үлдэцийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ.

**3.2.Тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох:**

*Мал эмнэлгийн боловсон хүчин:* Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, мал аж ахуйн гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэврийг хангахад нийт 9 төрийн болон орон нутгийн мал эмнэлгийн байгууллага, 1 хувийн хэвшлийн байгууллагуудад нийт 3089 ажиллагсад ажиллаж байгаа бөгөөд үүнээс хувийн хэвшлийн нэгжүүдэд 1449 малын их, бага эмч ажиллаж байна.

*Хүснэгт 7. Мал эмнэлгийн салбарын ажиллагсад:*

№	Төрийн болон орон нутгийн байгууллагууд	Ажиллагсад
1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	3
2	Мал эмнэлгийн ерөнхий газар	44
3	Аймаг, нийслэлийн газар, лаборатори	457
4	Биокомбинат ТӨААУҮГ	254
5	Сум, дүүргийн мал эмнэлгийн тасаг	674
6	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори	52
7	Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын лаборатори	28
8	Мал эмнэлгийн биотехнологийн их сургууль	40
9	Мал эмнэлгийн хүрээлэн	88
10	Хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж	1449
<b>Нийт</b>		<b>3089</b>

*Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газар*

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар 22 аймаг, нийслэлд Хувийн мал эмнэлгийн үйлчилгээний 1038 нэгжид 797 их, 426 бага эмч ажиллаж, малын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг гардан хэрэгжүүлж байна.

*Хүснэгт 8. Хувийн хэвшлийн Мал эмнэлгийн нэгжийн ажиллагсад /2022 оны байдлаар/:*

№	Аймгийн нэр	МЭҮН тоо	Ажиллаж буй эмчийн тоо		
			МЭҮН-д ажиллаж байгаа малын их эмч	МЭҮН-д ажиллаж байгаа малын бага эмч	Нийт малын эмчийн тоо
1	Архангай	41	44	40	84

2	Баян-Өлгий	61	10	51	61
3	Баянхонгор	49	46	41	87
4	Булган	55	48	14	62
5	Говь-Алтай	56	25	31	56
6	Говьсүмбэр	10	9	3	12
7	Дархан-Уул	11	9	4	13
8	Дорноговь	31	38	1	39
9	Дорнод	52	18	7	25
10	Дундговь	38	48	8	56
11	Завхан	51	38	26	64
12	Орхон	7	9	4	13
13	Өвөрхангай	48	37	12	49
14	Өмнөговь	36	30	9	39
15	Сүхбаатар	58	61	19	80
16	Сэлэнгэ	47	33	18	51
17	Төв	92	62	34	96
18	Увс	72	39	23	62
19	Ховд	44	27	17	44
20	Хөвсгөл	89	60	28	88
21	Хэнтий	74	81	28	109
22	Нийслэл	16	25	8	33
Дүн		1038	797	426	1223

Эх сурвалж: Мал эмнэлгийн ерөнхий газар

Хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг ажлын ачааллыг тооцон үзэхэд нэг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 67.0 мянган толгой мал, нэг малын эмчид 44.2 мянган толгой мал тус тус ногдож байна.

Биокомбинат ХХК: Биокомбинат УТҮГ нь 1923 онд байгуулагдсан ба 1973 онд Унгар Улсын техник, эдийн засгийн тусламжтайгаар бүрэн шинэчлэлт хийгдэж малын халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, биобэлдмэл болон оношлогооны бэлдмэл үйлдвэрлэн ажиллаж байна.

Тус үйлдвэр нь дотоодын цэргээр хамгаалуулсан “Улсын онц чухал объект” бөгөөд нийт 12.8 га газрыг хамарсан газарт 37 объект, барилга байгууламж ашиглагдаж, нийтдээ 250 гаруй ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж байна. Биокомбинат үйлдвэр нь жилдээ улсын захиалга даалгавраар улсын төсвөөс нийт 10.0-12.0 тэрбум төгрөгийн санхүүжилт авч 44 нэр төрлийн 120,000-130,000 литр малын шингэн вакцин болон биобэлдмэл, 18.0-25.0 сая тун хатаасан вакцин, биобэлдмэл үйлдвэрлэдэг.

Улсын Мал Эмнэлэг Ариун Цэврийн Төв Лаборатори (УМЭАЦТЛ): Тус лаборатори нь Монгол Улсын Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Малын эрүүл мэндийн талаар талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, улсын хэмжээнд мал, амьтны элдэв өвчин, хордлогыг оношлох, гадаад, дотоодын зах зээлд борлуулах мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон хашаа байр, тэжээл, ус, хөрс, ургамалд ариун цэвэр, эрүүл ахуйн үзлэг, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, баталгаажуулан гэрчилгээ олгох, орон нутгийн мал эмнэлгийн шинжилгээний байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангах зорилготой.

- Мал, амьтны гоц халдварт өвчнийг биоаюулгүй нөхцлийн дор оношлох, тандах, дүгнэлт гаргах, оношийг шаардлагатай үед олон улсын лавлагаа лабораториор баталгаажуулах;
- Мал, амьтны халдварт, паразиттах, халдваргүй өвчин, хордлогыг оношлох, тандан судлах, мал сүргийг эрүүлжсэний баталгаа гаргах, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх ажлын үр дүнд лабораторийн аргаар хяналт тавих, малын өвчний гаралтад шалтгаалах гадаад орчны хүчин зүйлийг тогтоох, дүгнэлт гаргах;
- Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд эрүүл ахуй, ариун цэврийн магадлан шинжилгээ, мал, амьтны эд эрхтэн, тэжээл, үр тариа, хүнсний ногоо, жимс, ус, хөрс, ургамалд биохими, мөөгөнцөр, цацраг, хор судлал, эм, химийн бодисын үлдэгдлийн,

- бэлчээрийн ургамал, ус, өвс, тэжээл, малын байранд эрүүл ахуйн шинжилгээ хийж үзүүлэлтүүдийг тогтоох, чанарын үнэлгээ өгөх, баталгаажуулах;
- Малын өвчний гаралт, тархалт, онош, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуйн үзүүлэлтийн талаар холбогдох байгууллагыг байнгын мэдээллээр хангах, мал, амьтны өвчин, хордлогоос сэргийлэх талаар олон нийтэд мэдээлэх, сэрэмжлүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх;
  - Мал эмнэлгийн лаборатори, мал аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэл, худалдаа, үйлдвэрлэлийн аж ахуйн дэргэдэх лабораторийн шинжлэгч нарт сургах, дадлагажуулах, арга зүйгээр хангах, нарийн мэргэжлийн чиглэлээр богино хугацааны дамжаа, семинар, зөвлөлгөөн зохион байгуулах;
  - Эрхэлсэн асуудлаар хөрөнгө оруулалт хийх, шинжлэх ухаан, технологийн болон болон технологи нэвтрүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, судалгаа хийх, бүтээл хэвлүүлэх.

Тус лаборатори нь 2009 оноос хойш гоц халдварт өвчний оношлогоо тандалтын, халдварт, паразиттах өвчний оношлогоо тандалтын, хүнсний эрүүл ахуй үлдэгдлийн шинжилгээний, байгаль орчноос шалтгаалах өвчний оношлогоо-тандалтын, санхүү аж ахуйн гэсэн 5 тасагтай, нарийн мэргэжлийн 18 лабораторитой, шинжилгээ судалгаанд 386 төрлийн багаж төхөөрөмж, 640 нэрийн оношлуур, урвалж бодис, 450 нэрийн туслах хэрэглэгдэхүүнийг ашиглан, үндсэн үйл ажиллагааг явуулж байна.

УМЭАЦТЛ нь 1999, 2001, 2003, 2005, 2007, 2010, 2015, 2019 ондуудад олон улсын болон үндэсний стандартын байгууллагаар итгэмжлэгдсэн.

Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд бүтээгдэхүүний эрүүл ахуй ариун цэврийн баталгаажуулалт, мал эмнэлгийн оношлогоо, шинжилгээг УМЭАЦТЛ болон аймаг, нийслэлийн 22 лаборатори, аймаг, нийслэлийн томоохон зах, худалдааны төвийн 37, нийт 50 гаруй лабораториуд үйл ажиллагаа явуулж байна.

Малын эмийн үлдэгдлийн чиглэлээр Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторит шинжилгээг олон улсад зөвшөөрөгдсөн арга зүйн дагуу хийж байна.

Зураг 4. Мал эмнэлгийн сүлжээ лабораториудын байршил:



Монгол улсын хэмжээнд экспортын болон олон хүн төвлөрсөн хот суурин газрын хэрэгцээний мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, ариун цэвэр, эмийн болон химийн бодисын үлдэгдлийг хянах, шинжилгээ хийх үүргийг УМЭАЦТЛ, орон нутгийн мал эмнэлгийн лаборатори өвчний оношлогоо, эрүүл ахуй, ариун цэврийн баталгаажуулалтыг хариуцан ажиллаж байна.

УМЭАЦТЛ-д 2000 онд үлдэгдлийн шинжилгээний лаборатори, 2003 онд Олон улсын атомын энергийн агентлагийн төслөөр нянгийн өсөлтийг саатуулах, фермент холбоот эсрэг биеийн урвалаар малын эмийн үлдэгдлийг тодорхойлох, 2004 онд KOICA байгууллагаас авч хэрэгжүүлсэн “Мал эмнэлгийн эрүүл ахуйн лабораторийн шинжилгээний чадавхийг сайжруулах” төслийн хүрээнд өндөр мэдрэмжит шингэний хроматографи (HPLC) болон бусад багаж, тоног төхөөрөмж, эм урвалжаар хангагдаж, малын гаралтай бүтээгдэхүүнд үлдэгдэл илрүүлэх шинжилгээг тогтмол хийж байна.

Мал эмнэлгийн эмийн сорилт баталгаажуулалтын улсын лаборатори (МЭЭСБУЛ): Монгол улсад үйлдвэрлэгдэж, импортлогдож, шинээр зохион бүтээгдэж буй мал амьтны гоц халдварт, халдварт, паразиттах болон халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх, оношлох эм, биобэлдмэл, эмийн түүхий эдэд хими, биологи, вирусологи, бактериологи, паразитологийн сорилт шинжилгээ хийж, сорилтын дүн, баталгаажуулалтын дүгнэлт, тохирлын гэрчилгээ олгох эрх бүхий нарийн мэргэжлийн байгууллага юм.

Лабораторийн зорилго нь мал эмнэлгийн зориулалтаар үйлдвэрлэгдэж, импортлогдож, зохион бүтээгдэж буй эм, биобэлдмэл, эмийн түүхий эдэд чанарын шалгалт хийх, мал эмнэлгийг чанартай баталгаатай эм, биобэлдмэлээр хангах төрийн бодлогыг дэмжихэд оршино.

Лабораторийн үндсэн чиг үүрэг:

- ✦ Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлж Монгол улсын мал эмнэлгийн ажил үйлчилгээг фармакопейн шаардлага хангасан, эм, биобэлдмэлээр тасралтгүй хангахад дэмжлэг үзүүлэх;
- ✦ Малын эмийн салбарын бодлогыг хэрэгжүүлэхэд нарийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх;
- ✦ Малын эмийн шалгалтанд чанарын удирлагын тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлэх;
- ✦ Шинээр зохион бүтээгдэж байгаа болон нийлүүлэгдэж буй эм, биобэлдмэлийн чанар аюулгүй байдал, стандартын төсөлд санал оруулах.

Лабораторийн Баталгаажуулалтын алба болон Сорилтын лаборатори нь анх 2004 онд MNS ISO/IEC 17025 болон MNS ISO/IEC 17065 стандартын дагуу шалгуулж итгэмжлэгдэж лабораторийн эрх авсан бөгөөд 2007 болон 2009, 2017 онуудад дахин итгэмжлэгдэж итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтын дагуу малын эм, биобэлдмэл, эмийн түүхий эдэд сорилт, баталгаажуулалт гүйцэтгэж байна.

Олон улсын фармакопей-8 боть, Монгол улсын фармакопей-2 боть /185 өгүүлэл/, 60 Монгол улсын стандарт, Дагалдах НТББ-ийн хүрээнд шинжилгээ, баталгаажуулалтыг явуулж байна.

Мал Эмнэлгийн Хүрээлэн (МЭХ): Мал эмнэлгийн хүрээлэн нь Монгол улсын мал эмнэлгийн шинжлэх ухааны цорын ганц байгууллагын хувьд мал, амьтны гоц халдварт, халдварт, паразиттах болон халдваргүй өвчнүүдийн оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг шинжлэх ухааны үндэстэй боловсруулах, үндэсний технологи бүхий шинэ эм, биобэлдмэл зохион бүтээх, мал эмнэлгийн арга хэмжээг боловсронгуй болгох, шинэ технологи, арга, аргачлал боловсруулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх замаар мал сүргийг эрүүлжүүлэх зорилгын хүрээнд онолын болон хавсарга судалгааны ажил гүйцэтгэж ирлээ.

Одоо тус хүрээлэн нь Халдварт өвчин, дархлаа судлал, Вирус судлал, Эрүүл ахуй, ариун цэвэр, Эмгэг судлал, Молекул генетикийн лаборатори, Хачиг, шавж, эгэл биетэн судлал, Гельминт судлалын лаборатори, Малын бодис солилцоо, биохимийн лаборатори, Үржлийн эмгэг, даавар судлалын лаборатори, Төлийн физиологи, эмгэг судлалын лаборатори, Эм, хор судлалын лаборатори гэсэн нийт 11 лаборатори, Захиргаа, аж ахуйн нэгж, туршлагын жижиг амьтны Вивар, Биобэлдмэлийн цех, туслах аж ахуй бүхий бүтэцтэйгээр ажиллаж байна.

Аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лаборатори (МЭЛ) нь мал, амьтаны өвчнийг лабораторийн аргаар оношлох, тандан судлах болон мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд ариун цэврийн шинжилгээ хийж дүн, дүгнэлт гаргах үүрэгтэй.

Иймд Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон мал

эмнэлгийн эм зүйн үйл ажиллагаанд оролцогч хуулийн этгээдийн чиг үүргийн зохицуулалтгүй байна.

Эм барих үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагааг мал эмнэлгийн Хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж Малын эмийн санд ажиллаж буй итгэмжлэл бүхий малын их эмч гүйцэтгэж байна.

Улсын хэмжээнд 22 аймаг, нийслэл, 330 сум 6 дүүршийн Хувийн мал эмнэлгийн үйлчилгээний 1038 нэгжид 1223 их эмч хэрэгжүүлж байна.

Нийслэлд 49 эмийн сан, аймаг, нийслэлд 37, нийт улсын хэмжээнд 86 эмийн сан үйл ажиллагаа явуулж байна.

Вакцины 90 хувийг дотоодын үйлдвэрлэлээр, бусад эм, нян, шимэгчийн эсэрэг бэлдмэлийг 100 хувь импортоор худалдан хэрэглэж байна.

### **ДӨРӨВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛОХ**

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай төсөл батлагдсаар мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн зөвшөөрөл, бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдаа, хангамж, хэрэглээ, хяналттай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдэнэ. Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна:

Зорилго “Мал эмнэлгийн эмийн зохицуулалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын чиг үүрэг, хяналтын үүрэг илүү тодорхой болж, эмийн чанар, аюулгүй байдал, хангамж сайжирч, хүнсний аюулгүй байдлыг хангах”

### **ТАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРЫГ ТОГТООЖ, ЭЭРЭГ БОЛОН СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛАХ**

5.1. Асуудал зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулан үзэх ажлын хүрээнд энэхүү аргачлалын Дөрөв дэх хэсэгт заасан зорилгыг биелүүлэхэд чиглэсэн зохицуулалтын хувилбаруудыг тогтооно. Зохицуулалтын дараах хувилбарууд байна:

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн	
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгыг бүрэн хангахгүй	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрнэ.
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн чанар, аюулгүй байдлын норм, стандарт, хяналтыг хөндлөнгийн нэгдсэн зохицуулалтын байгууллагын оролцоогүйгээр бүрэн хангаж чадахгүй	Тодорхой хэмжээний зардал гарна. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй

4	Төрөөс санхүүгийн интервенци хийх		Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй
5	Захиргааны шийдвэр гаргах		Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаварыг бүрэн бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрнэ.
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн зөвшөөрөл, бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдаа, хангамж, хэрэглээ, хяналттай холбогдсон харилцааг зохицуулахтодорхой болгосноор тэдгээрийн хүний эрүүл мэндэд үзүүлэх үр нөлөө, чанар аюулгүй байдал, талуудын хариуцлага өндөрсөнө.	Энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн хэрэглээтэй холбоотой асуудал нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний салшгүй эрхийг хөндөж байгаа тул хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонголоо.

### **ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДЛАСАН БАЙДАЛ**

Хууль, тогтоомжийн тухай хуулийн 13, 14 дүгээр зүйл, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судлахдаа аргачлалд заасан дор дурдсан суурь асуултуудыг ашиглана судалгааг хийлээ. (Хүснэгт 1, 2, 3, 4-т харуулав)

#### **6.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа: /Хүснэгт 1/**

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх;	Үгүй	
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх;	Үгүй	
	1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх;	Үгүй	
	1.2. Оролцоог хангах		

	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх;	Тийм		
	1.2.2. Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх;	Тийм		
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариушлага			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх;		Үгүй	
	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх;	Тийм		
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариушлагыг тусгах эсэх;		Үгүй	
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх;		Үгүй	
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх;		Үгүй	
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх;	Тийм		
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх;		Үгүй	
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх;		Үгүй	
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй);		Үгүй	
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх;	Тийм		
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх;		Үгүй	
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх;		Үгүй	

6.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа: /Хүснэгт 2/

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
			Үгүй	

	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан);		Үгүй	
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх;	Тийм		
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх;		Үгүй	
	2.3. Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх;		Үгүй	
	2.4. Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх;		Үгүй	
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх;		Үгүй	
	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх;		Үгүй	
	3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх;		Үгүй	
	3.5. Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх;		Үгүй	
4. Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1. Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх;		Үгүй	
5. Өмчлөх эрх	5.1. Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх;		Үгүй	
	5.2. Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх;		Үгүй	
	5.3. Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх;		Үгүй	
6. Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1. Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх;		Үгүй	
	6.2. Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх;		Үгүй	
7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1. Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	
	7.2. Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх;		Үгүй	
	7.3. Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх;		Үгүй	

	7.4. Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
8. Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх;		Үгүй	
	8.2. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	8.3. Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
9. Төрийн захиргааны байгууллага	9.1. Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	9.2. Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх;		Үгүй	
	9.3. Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх;		Үгүй	
10. Макро эдийн засгийн хүрээнд	10.1. Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	10.2. Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх;		Үгүй	
	10.3. Инфляци нэмэгдэх эсэх;		Үгүй	
11. Олон улсын харилцаа	11.1. Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх;	Тийм		

5.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа: /Хүснэгт 3/

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1. Шинээр ажлын байр бий болох эсэх;		Үгүй	
	1.2. Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх;		Үгүй	
	1.3. Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх;	Тийм		
	1.4. Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх;		Үгүй	
2. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1. Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх;	Тийм		
	2.2. Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх;	Тийм		
	2.3. Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх;			
	2.4. Шинээр ажлын стандарт гаргах эсэх;		Үгүй	
	2.5. Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх;		Үгүй	
3. Нийгмийн тодорхой	3.1. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх;		Үгүй	

бүлгийг хамгаалах асуудал	3.2. Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт;		Үгүй	
	3.3. Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх;		Үгүй	
4. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1. Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх;		Үгүй	
	4.2. Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх;	Тийм		
	4.3. Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх;		Үгүй	
	4.4. Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх;		Үгүй	
	4.5. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх;		Үгүй	
5. Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1. Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх;		Үгүй	
	5.2. Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	5.3. Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх;		Үгүй	
6. Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1. Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх;		Үгүй	
	6.2. Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх;		Үгүй	
	6.3. Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	6.4. Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	6.5. Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх;		Үгүй	
7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1. Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх;		Үгүй	
	7.2. Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх;		Үгүй	
	7.3. Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	7.4. Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	

8. Соёл	8.1. Соёлын өвнийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	8.2. Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх;		Үгүй	
	8.3. Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх;		Үгүй	

6.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний тандан судалгаа: /Хүснэгт 4/

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1. Агаар	1.1. Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх;		Үгүй	
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1. Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх;		Үгүй	
	2.2. Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх;		Үгүй	
	2.3. Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	2.4. Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх;		Үгүй	
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх;		Үгүй	
	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх;		Үгүй	
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх;		Үгүй	
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх;		Үгүй	
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх;		Үгүй	
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх;		Үгүй	
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх;		Үгүй	
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх;		Үгүй	
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх;		Үгүй	
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх;		Үгүй	
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх;		Үгүй	
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх;		Үгүй	
7. Нөхөн сэргээгдэх /нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээ р зохистой ашиглах эсэх;		Үгүй	
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх;		Үгүй	

## **ДОЛОО.ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛСАН БАЙДАЛ**

### **7.1. Дүгнэлт:**

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтын дагуу хийлээ.

7.1.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон мал эмнэлгийн эм зүйн үйл ажиллагаанд оролцогч хуулийн этгээдийн чиг үүргийн зохицуулалт тусгагдаагүй бөгөөд чиг үүргийн давхардлыг арилгах шаардлагатай байна.

7.2.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 378 дугаар тогтоолоор мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын мал эмнэлгийн улсын байцаагч нарыг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шилжүүлсэн ч өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуульд мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон мал эмнэлгийн улсын байцаагчийн эрх үүрэг зохицуулагдаагүй байна.

7.3.Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн үйлдвэрлэл, төрөл, тоо хэмжээ нэмэгдэж, орчин үеийн дэвшилтэт технологи нэвтэрч, эм, эмнэлгийн хэрэгслийн хүртээмж сайжирч байгаа хэдий ч мал эмнэлгийн практикт бичил биетний эсрэг эмийн тэсвэржилт, малын эмийн үлдэц, малын эмийн зохисгүй хэрэглээ үүсэх эрсдэл нэмэгдэж байгаа тул энэхүү асуудлыг тусгайлан зохицуулах шаардлагатай байна.

7.4.Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах зорилгоор мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад эмийн зохистой хэрэглээ ихээхэн чухал. Нэг талаас малчид, мал бүхий иргэн, аж ахуй нэгж өөрсдөө дур мэдэн эм хэрэглэх, хэт дөвийлгөн сурталчилж буруу мэдээлэл түгээх, мал эмнэлгийн эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм, бэлдмэлийг хэрэглэх зэрэг зөрчил гарсаар байна. Иймд эдгээр асуудлыг хуульчлан зохицуулах зайлшгүй шаардлага тулгарч байна.

7.5.Дэлхий дахинд эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хурдацтай хөгжиж байгаа нь мал эмнэлгийн эмчилгээ, оношилгооны шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, эмийн худалдаа, хангамж, эмийн бүртгэл, баталгаажуулалт, эмийн нэгдсэн цахим бүртгэлийг нэвтрүүлэх, эмийн зохистой хэрэглээ, төрөөс баримтлах зарчим, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хяналт, мал эмнэлгийн эм, био бэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн зөвшөөрөл олгох, төрийн зохицуулалт болон хяналт, дархлаажуулалт зэрэг тулгамдаж буй асуудлуудыг шинээр хуульчлан зохицуулах хэрэгцээ шаардлага байна.

### **7.2.Зөвлөмж:**

Хуульд оруулах шаардлагатай байгаа нэмэлт, өөрчлөлтийг тусгахын тулд шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хэрэгтэй бөгөөд зохицуулалтын чиглэлээр дараахь асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна:

7.2.1.Хуулийн зорилт, мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль тогтоомж, төрөөс баримтлах зарчим, нэр томъёоны тодорхойлолт зэргийг тусгах;

7.2.2.Мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн бүртгэл, мал эмнэлгийн эмийн зөвлөл болон фармакопейн хорооны бүрэн эрхийг талаар тусгах;

7.2.3.Эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн баталгаажуулалт, хаяглалт, түүнд тавигдах шаардлагын талаар тусгах;

7.2.4.Судалгаа, шинжилгээ, үйлдвэрлэлийн өргөн туршилт, хэрэглээнд шинэ эм гаргах, эмнэлзүйн өмнөх судалгаа, эмнэлзүйн судалгааны зохицуулалтыг тусгах;

7.2.5. Мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн худалдаа, хангамжийн байгууллага, мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн үйлдвэр, импортлогч ханган нийлүүлэх байгууллага, мал эмнэлгийн эмийн сан, мал эмнэлгийг үйлчилгээний нэгжийн дэргэдэх эмийн сан болон эдгээрт тавих нийтлэг шаардлага болон үйл ажиллагаанд нь хориглох зүйлийг тусгах;

7.2.6. Хуулийн этгээд, малчин, амьтан маллагч, мал өмчлөгч иргэнд эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн зохицуулалттай холбоотой харилцаанд хориглох зүйлийг тусгах;

7.2.7. Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийг улсын хилээр нэвтрүүлэх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хяналт, мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмийн түүхий эд, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн зөвшөөрөл олголтын зохицуулалтыг тусгах;

7.2.8. Мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмжүүлсэн тэжээлийн зохистой хэрэглээний зохицуулалтыг тодорхойлох

7.2.9. Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх, малын эмийн үлдэцээс сэргийлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх зэрэг зохицуулалтыг тусгах;

7.2.10. Мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн асуудлаар засгийн газрын бүрэн эрх, мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бүрэн эрхийг тусгах;

7.2.11. Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, бүх шатны засаг дарга бүрэн эрх, хувийн ба мэргэжлийн төрийн бус байгууллагын оролцооны талаар тусгах;

7.2.12. Мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлд тавих хяналт шалгалтын зохицуулалтыг тусгах;

7.2.13. Дархлаажуулах бэлдмэлийн талаархи төрийн зохицуулалт, дархлаажуулалтын бүтээгдэхүүнд тавих шаардлага, дархлаажуулалтын бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх, дархлаажуулах бүтээгдэхүүний хангамжын зохицуулалтыг тусгах;

7.2.14. Мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн мэдээлэл, мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн зар сурталчилгааны зохицуулалтыг тусгах зэрэг болно.

-----o0o-----



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# МАЛ, АМЬТНЫ ЭМ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

УЛААНБААТАР ХОТ  
2024 он

## МАЛ, АМЬТНЫ ЭМ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮНЭЛГЭЭ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>1</sup> 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад заасны дагуу Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн зүйл, хэсэг, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулах болон хуулийн төслийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын<sup>2</sup> 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийнэ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх;
5. Дүгнэлт, зөвлөмж өгөх.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл нь дараах бүтэцтэйгээр боловсруулагдсан байна.

**Нэгдүгээр бүлэг:** Нийтлэг үндэслэлийг тодорхойлох: Энэхүү бүлэгт хуулийн зорилт, мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль тогтоомж, төрөөс баримтлах зарчим, нэр томъёоны тодорхойлолт зэргийг тусгасан байна.

**Хоёрдугаар бүлэг:** Мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн бүртгэл, баталгаажуулалт: Энэхүү бүлэгт мал, амьтны эм, биобэлдмэл, оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн бүртгэл, мал, амьтны эмийн зөвлөл болон фармакопейн хорооны бүрэн эрх, мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн чанарын баталгаажуулалт, мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн хаяглалт, түүнд тавигдах шаардлага, мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн судалгаа, шинжилгээний зохицуулалтыг тусгасан байна.

**Гуравдугаар бүлэг:** Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн худалдаа, хангамж, зөвшөөрөл: Энэхүү бүлгээр мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хангамжийн байгууллага, мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн үйлдвэр, мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг ханган нийлүүлэх байгууллага, мал, амьтны эмийн сан, малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч иргэн, хуулийн этгээдэд хориглох зүйл, мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг улсын хилээр нэвтрүүлэх, мал эмнэлэгт хэрэглэгдэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зохицуулалт, мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл олголтын зохицуулахаар тусгав.

**Дөрөвдүгээр бүлэг:** Энэхүү бүлэгт мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн зохистой хэрэглээ: Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх, малын эмийн үлдцээс сэргийлэх, мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн зохистой хэрэглээний зохицуулалтыг тусгасан.

<sup>1</sup> Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2015 оны № 25 дугаарт албан ёсоор хэвлэгдсэн

<sup>2</sup> Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан.

**Тавдугаар бүлэг:** Энэхүү бүлэгт төрийн хяналт шалгалт: Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтэд тавих хяналт шалгалтын зохицуулалтыг тусгасан.

**Зургаадугаар бүлэг:** Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зар сурталчилгааны зохицуулалтыг тусгав.

**Долоодугаар бүлэг:** Бусад зүйл: Төгсгөлийн бүлэгт хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг тус тус заасан.

## **ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

**2.1. “Зорилгод хүрэх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл болон түүний зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдсан болон бодит үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн болоод хүргэх боломжтой эсэхийг үнэлнэ. Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг судлан үзэж хуулийн төслөөс түүний зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авлаа.

**2.2. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалт иргэд, байгууллагад хэрхэн нөлөөлөх, түүнийг эдгээр этгээдүүд (хуулийн төсөл шууд нөлөөлөх иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг шалгана.

**2.3. “Практикт хэрэгжих боломж”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо (санхүү, хүний нөөц зэрэг) байгаа эсэхийг шалгаж тооцно.

**2.4. “Ойлгомжтой байдал”** гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдэд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар шалгана.

**2.5. “Зардал”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон улсын төсөвт ачаалал, хөнгөлөлтийг үүсгэх, төрийн байгууллагад хуулийн төслийг хэрэгжүүлэхэд үүсэх зардал, уг зардлын улмаас үүсэх үр дагавар зэргийг тооцон судална.

**2.6. “Харилцан уялдаа”** гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх, тухайн чиг үүргийг төрийн байгууллага зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай эсэх, уг чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэхийг шалгана. Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан б шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Ойлгомжтой байдал;
3. Харилцан уялдаа зэрэг болно.

## **ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Үнэлгээний ажлын энэ хэсэгт аргачлалд заасны дагуу Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгийг сонгох буюу тогтоож, өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлттэй үнэлэгдэх зүйл, хэсэг, заалтыг тохируулан үнэлэхэд

бэлтгэх юм.

Эдгээр үнэлэгдэх зүйл, хэсэг, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа буюу голлох ач холбогдолтой, үзэл баримтлалын буюу зарчмын шинжтэй, мөн анхаарах шаардлагатай заалтуудыг сонгож авсан болно.

Өөрөөр хэлбэл, тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ товч бөгөөд оновчтой байх үүднээс хуулийн төслөөс шинэлэг, хууль зүйн үр дагавар бий болгож буй, агуулгын хувьд чухал ач холбогдолтой, мөн асуудал дагуулах магадлалтай, анхаарах шаардлагатай заалтуудыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судлан үнэлэх болно. Шалгуур үзүүлэлт бүрийн хүрээнд үнэлэгдэх зүйл, хэсэг, заалтыг тоймловол:

*Хүснэгт 2. Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг хүснэгтийн дагуу тогтоолоо. Үүнд:*

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авна. /Хуулийн төсөл 8 бүлэг, 33 зүйлтэй./ Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
3	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг “харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар тогтоох юм. Уг шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зохицуулалтыг үнэлэхдээ тодорхой стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах тул хуулийн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, зохицуулалтыг бус төслийг бүхэлд нь сонгон авч үнэлэх нь зүйтэй байна. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь энэхүү шалгуур үзүүлэлтээр үнэлэх юм. Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах.

## **ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ**

Өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх хуулийн төслийн зохицуулалтыг тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх юм. Шалгуур үзүүлэлтийг дараах шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болно.

#### 4.1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн үнэлгээ:

Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаанд дүн шинжилгээ хийж үзвэл:

4.1.1.Хуулийн төслийн бүтцийг авч үзвэл: Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийн бүтцийг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн бүтэц /Шинэчилсэн найруулга/-гэй харьцуулахад хүн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтаас Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн зохицуулахаар тодорхойлсон нь хуулийн төсөл зорилгодоо хүрэх боломжийг бүрдүүлсэн байна.

Түүнчлэн хуулийн төслийн 3 дугаар зүйлд “Төрөөс мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн талаар баримтлах зарчим”-ыг тодорхойлж өгсөн нь зорилгодоо хүрэх боломжийг нээж өгсөн байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн бүтэц /Шинэчилсэн найруулга/ 9 бүлэг, 30 зүйл	Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийн бүтэц 7 бүлэг, 24 зүйл
<p><i>Нэгдүгээр бүлэг.Нийтлэг үндэслэл</i></p> <p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>2 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль тогтоомж</p> <p>3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p><i>Хоёрдугаар бүлэг.Төрөөс эмийн талаар баримтлах бодлого, зохицуулалт, эм хангамжийн тогтолцоо, эм барих үйл ажиллагаа</i></p> <p>4 дүгээр зүйл.Эмийн үндэсний бодлого</p> <p>5 дугаар зүйл.Эмийн зөвлөл</p> <p>6 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, экспорт, худалдаа, түгээлт, хяналтын талаархи төрийн зохицуулалт</p> <p>7 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл</p> <p>8 дугаар зүйл.Эм барих үйл ажиллагаа эрхлэх</p> <p>9 дүгээр зүйл.Эм хангамжийн байгууллага</p> <p>10 дугаар зүйл.Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагааны зарчим, нийтлэг үүрэг</p> <p>11 дүгээр зүйл.Эм хангамжийн байгууллагын үйл ажиллагаанд хориглох зүйл</p> <p><i>Гуравдугаар бүлэг.Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэх</i></p> <p>12 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэхэд тавих шаардлага</p> <p>13 дугаар зүйл.Эмийн санд эм найруулах</p> <p><i>Дөрөвдүгээр бүлэг.Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх</i></p> <p>14 дүгээр зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх</p> <p>15 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, экспортлох</p> <p>15<sup>1</sup> дүгээр зүйл.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлт импортлох, экспортлох зөвшөөрөл олгох</p> <p><i>Тавдугаар бүлэг.Эмийн түгээлт</i></p> <p>16 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг худалдах үйл ажиллагаа</p> <p>17 дугаар зүйл.Эмийн зохистой хэрэглээ</p> <p>18 дугаар зүйл.Эмийн хаяглалт, тэмдэглэгээ</p> <p><i>Зургаандугаар бүлэг.Шинэ эм бүтээх</i></p>	<p><i>Нэгдүгээр бүлэг.Нийтлэг үндэслэл</i></p> <p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>2 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль тогтоомж</p> <p>3 дугаар зүйл. Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн талаар төрөөс баримтлах зарчим</p> <p>4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p><i>Хоёрдугаар бүлэг. Мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн бүртгэл, баталгаажуулалт</i></p> <p>5 дугаар зүйл.Мал, амьтны эмийн зөвлөл болон фармакопейн хороо</p> <p>6 дугаар зүйл.Мал, амьтны эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийг бүртгэх</p> <p>7 дугаар зүйл.Мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн чанарын баталгаажуулалт</p> <p>8 дугаар зүйл.Мал, амьтны эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хаяглалт, түүнд тавигдах шаардлага</p> <p>9 дүгээр зүйл.Мал, амьтны эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн судалгаа, шинжилгээ</p> <p><i>Гуравдугаар бүлэг. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, Ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн худалдаа, хангамж, зөвшөөрөл</i></p> <p>10 дугаар зүйл.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн хангамжийн байгууллага</p> <p>11 дүгээр зүйл.Мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн үйлдвэр</p> <p>12 дугаар зүйл.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг ханган нийлүүлэх байгууллага</p> <p>13 дугаар зүйл.Мал, амьтны эмийн сан</p>

19 дүгээр зүйл.Шинэ эмийг хэрэглээнд гаргах	14 дүгээр зүйл.Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч иргэн, хуулийн этгээдэд хориглох зүйл
20 дугаар зүйл.Эмнэлзүйн өмнөх судалгаа	15 дугаар зүйл.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг улсын хилээр нэвтрүүлэх
21 дүгээр зүйл.Эмнэлзүйн туршилт	16 дугаар зүйл.Мал эмнэлэгт хэрэглэгдэх мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн зохицуулалт
<i>Долдугаар бүлэг.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал</i>	17 дугаар зүйл.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл олгох
22 дугаар зүйл.Эмийн бүртгэл	<i>Дорөвдүгээр бүлэг.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн зохистой хэрэглээ</i>
23 дугаар зүйл.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, хяналт	18 дугаар зүйл.Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх
24 дүгээр зүйл.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эмийн хяналт	19 дүгээр зүйл.Мал, амьтны эмийн үлдцээс сэргийлэх
25 дугаар зүйл.Эмийн гаж нөлөөний бүртгэл, мэдээлэл	20 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн зохистой хэрэглээний зохицуулалт
<i>Наймдугаар бүлэг.Эмийн мэдээлэл, зар сурталчилгаа</i>	<i>Тавдугаар бүлэг.Төрийн хяналт шалгалт</i>
26 дугаар зүйл.Эмийн мэдээлэл	21 дүгээр зүйл.Мал эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтэд тавих хяналт шалгалт
27 дугаар зүйл.Эмийн зар сурталчилгаа	<i>Зургаандугаар бүлэг. Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зар сурталчилгаа</i>
<i>Есдүгээр бүлэг.Бусад зүйл</i>	22 дугаар зүйл.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн мэдээлэл
28 дугаар зүйл.Эм хангамжийн үйл ажиллагаан дахь төрийн бус байгууллагын оролцоо	<i>Долоодугаар бүлэг.Бусад зүйл</i>
29 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	24 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага
30 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох	25 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

Мөн хуулийн төслийн Хоёрдугаар бүлэгт “Мал, амьтны эм, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн бүртгэл, баталгаажуулалт” Гуравдугаар бүлэгт “Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, Ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн худалдаа, хангамж, зөвшөөрөл”, Дөрөвдүгээр бүлэгт “Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн зохистой хэрэглээ”, Тавдугаар бүлэгт “Төрийн хяналт шалгалт”, Зургаандугаар бүлэгт “Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зар сурталчилгаа” зэргийн зохицуулалтыг цогцоор нь оновчтой дараалалд оруулж өгсөн нь зорилгодоо хүрсэн гэж дүгнэж болохоор байна.

#### 4.1.2.Хуулийн төслийн зохицуулах харилцааг авч үзвэл:

Хуулийн төслийн зорилт нь мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл, бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдаа, хангамж, хэрэглээ, холбогдсон харилцааг зохицуулахаар төсөлд тусгасан.

Энэхүү байдлаар тусгасан нь мал эмнэлгийн салбарын эм, эмнэлгийн хэрэгсэл, тэжээлийн нэмэлтийн зохицуулалтыг зөвшөөрөл, бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдаа, хангамж, хэрэглээ, хяналтыг оновчтой дэс дарааллаар тогтоосон нь зорилгодоо хүрсэн гэж

дүгнэж болохоор байна.

#### 4.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс судлаачийн зүгээс хуулийн төслийн ойлгомжтой байдалд дүн шинжилгээ хийсэн болно. Ингэхдээ дор дурдсанаар багцлан үнэлсэн:

##### 4.2.1. Хуульд хэрэглэсэн нэр томъёоны хувьд:

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөлд “үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих” шаардлага тавигддаг.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн нэр томъёо /Шинэчилсэн найруулга/	Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийн нэр томъёо
25 нэр томъёог тодорхойлсон.	18 нэр томъёог тодорхойлсон.
<p>3.1.1."эм" гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, дархлаажуулах зориулалттай, үйлчлэл нь эм судлал, эмнэлзүйн сорилт туршилтаар нотлогдсон, нийлэг буюу амьтан, ургамал, эрдсийн гаралтай бодисыг тодорхой хэлбэрт оруулсан, зохих тун, хэмжээгээр хэрэглэдэг бэлдмэлийг;</p> <p>3.1.2."биобэлдмэл" гэж хүний болон мал, амьтны өвчнийг эмчлэх, оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалтаар амьд бие, бие махбодь, түүний эд, эсээс болон лабораторийн аргаар гаргаж авсан бүтээгдэхүүнийг;</p> <p>3.1.3."уламжлалт эм" гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх зорилгоор тодорхой тун, хэмжээгээр хэрэглэдэг, уламжлалт анагаах ухааны жорын дагуу ургамал, амьтан, эрдсийн гаралтай бодис болон үнэт эрдэнэс оруулан уламжлалт болон үйлдвэрийн аргаар бэлдсэн байгалийн гаралтай бүтээгдэхүүнийг;</p> <p>3.1.4."оношлуур" гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, түүний явцыг хянах зорилгоор хүн, мал, амьтанд болон орчны сорьцын шинжилгээнд хэрэглэдэг, тодорхой тун, хэмжээ, найрлага, өвөрмөц чанар, идэвх бүхий бүтээгдэхүүнийг;</p> <p>3.1.5."эмнэлгийн хэрэгсэл" гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, сувилах болон бие махбодийн бүтэц, үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашигладаг туслах зориулалтын эд зүйлийг;</p> <p>3.1.6."мансууруулах эм" гэж донтуулах нөлөөлөл үзүүлдэг, "Мансууруулах эмийн тухай" 1961 оны Нэгдсэн Конвенцийн жагсаалтад орсон эм бэлдмэлийг;</p> <p>3.1.7."сэтгэцэд нөлөөлөх эм" гэж сэтгэцэд хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, "Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай" 1971 оны Конвенцийн жагсаалтад орсон бодисыг;</p> <p>3.1.8."өнчин эм" гэж ховор тохиолддог өвчнийг эмчлэхэд болон улсын хэмжээгээр харьцангуй бага хэрэглэдэг эмийг;</p>	<p>4.1.1."эм" гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин, эмгэгийг оношлох, эмчлэх зориулалттай, эм судлал, эмнэлзүйн болон бусад сорилт туршилтаар үйлдэл нь нотлогдсон цэвэр язгуур махбод, нийлэг болон амьтан, ургамал, эрдсийн гаралтай тодорхой хэлбэр, тун, хэмжээтэй бүтээгдэхүүнийг;</p> <p>4.1.1.1."биобэлдмэл" гэж мал, амьтны өвчнийг эмчлэх, оношлох, өвчнөөс сэргийлэх, дархлаажуулах зориулалтаар бичил биетэн ба амьд махбодын эс, эд, эрхтнээс биотехнологийн аргаар гаргаж авсан бүтээгдэхүүнийг;</p> <p>4.1.1.2."мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис" гэж Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасныг.</p> <p>4.1.2."тэжээлийн нэмэлт" гэж мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 4 дүгээр зүйлийн 4.1.16-д заасныг.</p> <p>4.1.3."оношлуур" гэж мал, амьтны өвчнийг илрүүлэх, оношлох, баталгаажуулах зорилгоор мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд болон орчны сорьцын шинжилгээнд хэрэглэдэг, тодорхой тун, хэмжээтэй, дан ба нийлмэл найрлагатай бүтээгдэхүүнийг;</p> <p>4.1.4. "эмийн түүхий эд" гэж эмийг бэлтгэх, үйлдвэрлэх зорилгоор ашигладаг биологийн идэвхи бүхий дан болон нийлмэл бүтэцтэй нийлэг ба ургамал, амьтан, эрдсийн гаралтай зүйлийг;</p> <p>4.1.5."эмийн гол үйлчлэгч бодис" гэж тухайн эмийн үйлдлийг нөхцөлдүүлэгч дан ба нийлмэл бүрэлдэхүүнтэй биологийн идэвхт нэгдлийг;</p> <p>4.1.6."эмийн туслах бодис" гэж эмийн гол үйлдлийг дэмжих, сөрөг нөлөөг бууруулах, амт үнэрийг дарах ба нэмэгдүүлэх, эмийг хэлбэржүүлэх, найрлагыг тогтворжуулах, үйлдлийн ба хадгалах хугацааг уртасгах, хадгалалт зэрэгт шаардлагатай зүйлийг;</p> <p>4.1.7."ерөнхий нэршлийн эм" гэж шинээр зохион бүтээсэн эмийн оюуны өмчийн эрхийн хугацаа дууссанаас хойш үйлдвэрлэсэн, эсхүл оюуны өмчийн эрх эзэмшигчээс зөвшөөрөлтэй, түүнтэй</p>

3.1.9."эмийн түүхий эд" гэж эмчилгээний идэвхт бодис агуулсан цэвэр язгуур махбодь, нийлэг болон ургамал, амьтан, эрдсийн гаралтай зүйлийг;

3.1.10."эмийн туслах бодис" гэж эм үйлдвэрлэх, найруулахад зайлшгүй шаардлагатай нэмэлт зүйлийг;

3.1.11."цуврал" гэж үйлдвэрлэлийн технологийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэсэн эмийн бүтээгдэхүүний багцын тоо хэмжээг;

3.1.12."эмийн үнэлэмж" гэж эмийн чанар, аюулгүй байдал, үйлчлэлийн идэвхийг эм зүй, эм судлал болон эмнэлзүйн судалгаагаар нарийвчлан тогтоосон илэрхийллийг;

3.1.13."эмийн бүртгэл" гэж хими, биологи, эм судлал, эмийн үнэлэмжийн үндсэн дээр урьдчилан сэргийлэлт, оношлогоо, эмчилгээнд хэрэглэж болох нь нотлогдсон эмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэглээнд гаргахыг зөвшөөрөх үйл ажиллагааг;

3.1.14."зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт" гэж хүн болон мал, амьтанд үзүүлэх эмнэлгийн тусламжид эн тэргүүнд хэрэглэхээр эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан эм, эмнэлгийн хэрэгслийн нэрсийг;

3.1.15."эм барих" гэж Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.17-д заасныг;

3.1.16."эмийн жор" гэж эмчээс эм зүйч, эм найруулагчид хандан эмийг тухайн өвчтөнд зориулан бэлтгэх, олгох, хэрэглэх аргыг заасан баримт бичгийг;

3.1.17."эмийн зохистой хэрэглээ" гэж эмийг шаардлагатай тохиолдолд эмч, эм зүйчийн заавар, зөвлөмжийн дагуу зөв хэрэглэхийг;

3.1.18."эмийн гаж нөлөө" гэж хүний болон мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг оношлох, эмчлэх зорилгоор зохист тунгаар хэрэглэхэд бие махбодид гарч болзошгүй болон гарч байгаа сөрөг илэрлийг;

3.1.19."фармакопейн өгүүлэл" гэж эмэнд тавих шаардлага, чанарын үзүүлэлт болон тэдгээрийг шинжлэх аргыг заасан зайлшгүй мөрдөх стандартыг;

3.1.20."фармакопей" гэж фармакопейн өгүүллийн эмхтгэлийг;

3.1.21."хуурамч эм" гэж хууль бусаар ашиг олох зорилгоор эм үйлдвэрлэгчийн нэрээр хуурамч шошго хэрэглэж, дууриалган үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг;

3.1.22."эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр" гэж эмийн түүхий эд болон эмийн туслах бодис ашиглан эм зүйн технологийн дагуу эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

3.1.23."эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага" гэж эмийн сан, эрүүл мэндийн байгууллага болон мал эмнэлгийг эм, эмнэлгийн хэрэгслээр бөөний үнээр хангах үйл ажиллагааг

дүйцэх эмчилгээний үр дүнтэй, харилцан орлуулж болох худалдааны болон олон улсын нэршил бүхий эмийг;

4.1.8."эмийн олон улсын нэршил" гэж дэлхийн олон улсад хүлээн зөвшөөрсөн, патентын бус, эмийн үйлчлэгч бодисын эсхүл эмийн албан ёсны ерөнхий нэрийг;

4.1.9."эмийн худалдааны нэршил" гэж эм үйлдвэрлэгч өөрийн орны зах зээлд гаргахдаа өгсөн оноосон нэрийг;

4.1.10."эм барих" гэж мал, амьтанд зориулж эм найруулах, бэлтгэх, шалгах, савлах, олгох үйл ажиллагааг;

4.1.11."цуврал" гэж үйлдвэрлэлийн технологийн нэг удаагийн шат дамжлагаар үйлдвэрлэгдсэн багцын тоо хэмжээг;

4.1.12."Мал, амьтны эмийн бүртгэл" гэж эм зүй, эм судлалын ба бусад судалгааны үндсэн дээр урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээнд хэрэглэж болох нь нотлогдсон эмийн чанар аюулгүй байдал, үр нөлөөг хянах, Монгол улсын хэмжээнд хэрэглэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг;

4.1.13."зайлшгүй шаардлагатай мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалт" гэж мал, амьтанд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээнд нэн тэргүүнд хэрэглэхээр баталсан эм, эмнэлгийн хэрэгслийн нэрсийг;

4.1.14."Мал, амьтны эмийн жор" гэж малын эмчээс эм зүйч, эм найруулагчид хандан эмийг өвчтэй мал, амьтанд зориулан бэлтгэх, олгох, хэрэглэх аргыг заасан баримт бичгийг;

4.1.15."эмийн зохистой хэрэглээ" гэж эмийг өвчний оношид нийцүүлэн хэрэглэх зааврын дагуу зохих тун, зориулалт, тогтоосон давтамжаар хэрэглэхийг;

4.1.16."эмийн гаж нөлөө" гэж мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх зорилгоор зааврын дагуу хэрэглэх явцад илэрч байгаа сөрөг хариу урвалыг;

4.1.17."бичил биетний тэсвэржилт" гэж ижил зүйлийн мэдрэмтгий бичил биетэнтэй харьцуулахад бичил биетний эсрэг эмийн тунг ихэсгэн хэрэглэсэн ч үржсээр байх, эсхүл тогтвортой орших бичил биетний чадварыг;

4.1.18."бичил биетний эсрэг эм" гэж мал, амьтныг халдварт өвчнийг эмчлэх зориулалтаар хэрэглэдэг нян, вирус, мөөгөнцөр, шимэгчийн эсрэг үйлдэлтэй эмийг;

<p>эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;</p> <p>3.1.24."эмийн сан" гэж эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, хүн амыг эм, эмнэлгийн хэрэгслээр жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;</p> <p>3.1.25."биологийн идэвхт бүтээгдэхүүн" гэж хүний бие махбодийн үйл ажиллагааг дэмжих, зайлшгүй шаардлагатай эрдэс бодисоор нөхөх, аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ бүхий бүтээгдэхүүнийг.</p>	
---	--

Хуулийн төслийн төслийн 4 дүгээр зүйлд “Хуулийн нэр томъёоны тодорхойлолт”-д нийт 20 нэр томъёог тусгасан байна. Үүнээс 6 нэр томъёо нь шинээр 14 нэр томъёо нь мал эмнэлгийн эмийн салбарт хэрэглэгдэж байсан байна.

Шинэ нэр томъёололыг авч үзвэл:

- ↓ 4.1.7.“ерөнхий нэршлийн эм”
- ↓ 4.1.8.“эмийн олон улсын нэршил”
- ↓ 4.1.9.“эмийн худалдааны нэршил”
- ↓ 4.1.17.“бичил биетний тэсвэржилт”
- ↓ 4.1.18.“Бичил биетний эсрэг эм”

4.2.2.Найруулгын хувьд:

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгасан. Үүнд:

№	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан байна.
2	29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Хуулийн төсөлд тусгаснаар хуулийн зорилт нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн хамрах хүрээ, төрөл, уг харилцаанд оролцогчдын эрх, чиг үүргийг тодорхойлж, мал аж ахуйг хөгжүүлэхэд үзүүлэх дэмжлэгтэй холбогдсон харилцааг зохицуулах гэж заасан.
3	29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан байна.
4	29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
5	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
6	29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
7	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн	Хуулийн төсөлд дараах хэсэг, заалтад ишлэл авч хэрэглэсэн байна. Үүнд: 6.2.1.энэ зүйлийн 6.3-д зааснаас бусад бүх төрлийн урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх

албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;

зориулалттай эм, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлт;

6.9.Энэ хуулийн 6.8-д заасан цахим санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх журмыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.1.Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын лаборатори нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 29.2-т зааснаас гадна дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

8.2.Энэ хуулийн 8.1.9, 8.1.10 дахь заалт нь зөвхөн үндэсний үйлдвэрлэгчид хамаарна.

9.3.Хангамжийн байгууллага нь энэ хуулийн 4.1.6-д заасан бүтээгдэхүүнийг шинээр хэрэглээнд нэвтрүүлэхээс өмнө Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 29.1-д заасан лабораториор харьцуулсан үр дүнгийн судалгааг хийлгэнэ.

10.3.Энэ хуулийн 10.2.1, 10.2.2-т заасан байгууллага нь эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг бөөний үнээр худалдан борлуулах салбар нэгж байгуулан ажиллаж болно.

10.8.Энэ хуулийн 10.7-д заасан жилийн тайлангийн зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

10.9.Энэ хуулийн 10.2-т заасан хангамжийн байгууллагаас бусад байгууллага, иргэн мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

11.5.Энэ хуулийн 10.2.1, 10.2.2-т заасан хуулийн этгээд нь хэрэглэгчийн захиалгын дагуу чанарын баталгаатай биобэлдмэлийг мал эмнэлгийн байгууллагын хяналт дор нийлүүлж болно.

13.6.Мал эмнэлгийн байгууллага, эмийн сан нь энэ хуулийн 13.5-д заасан жагсаалтад орсон эм, эмнэлгийн хэрэгслийг тусгай зөвшөөрөл бүхий хүн эмнэлгийн эм хангамжийн байгууллагаас гэрээний үндсэн дээр худалдан авна.

13.7.1.энэ хуулийн 13.3-т зааснаас бусад этгээдийг ажиллуулах;

15.7.1.энэ хуулийн 15.1-д заасны дагуу тогтоосноос өөр хилийн боомтоор нэвтрүүлэх;

17.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12.12, 12.15-д заасан тусгай зөвшөөрөл, 8.2 дугаар зүйлийн 11.4-т заасан энгийн зөвшөөрлийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 8.1 дүгээр зүйлийн 12.16-д заасан тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар тус тус олгоно.

17.7.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зөвшөөрөл олгох асуудлыг Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд заасан журмыг баримтлан хугацаанд нь шийдвэрлэнэ.

		<p>20.1.Мал, амьтын эрүүл мэндийн тухай хуулийн 28.1-д заасан байгууллага мал, амьтны эмийн сэрэмжлүүлгийг өвчний зөв онош, эмийн зөв сонголт, тунгийн зөв сонголт, хэрэглээний зөв арга, цаг хугацааны зөв сонголт гэсэн зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.</p> <p>21.2.Энэ хуулийн 21.1-д заасан улсын байцаагч нь мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн талаар гарсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын биелэлтэд хяналт тавина.</p> <p>21.3.Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9-т заасан бүрэн эрхээс гадна дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>22.4.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг сурталчлахад зар сурталчилгааны тухай хуулийн 13.4-т зааснаас гадна дараах зүйлийг хориглоно:</p> <p>23.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>23.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>Хуулийн төсөлд бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр эш татсан байна.</p>
8	29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
9	29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт	Хуулийн хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацааг тусгаагүй. Хууль зөрчсөн этгээдийн үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол холбогдох зөрчилд ногдуулах шийтгэлийг уг хуулийг дагалдах Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусган зохицуулсан.
10	29.1.10. Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон бусад хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх.	Дагалдах хуулийн төслүүд боловсруулагдсан байна.
11	29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг шаардлагыг хангасан байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага:

№	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Энэ шаардлагад нийцэж байна.
2	30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
3	30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
4	30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
5	30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

#### 4.3.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хүчин төгөлдөр бусад хууль тогтоомжтой болон өөр хоорондоо болон Монгол Улсын бусад хууль тогтоомжтой харилцан уялдаж нэгдмэл болж чадаж байгаа эсэх асуудлыг тогтоох юм.

Хуулийн төсөлд хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацааны талаар тодорхой заагаагүй ба хуулийн төсөлд хүчин төгөлдөр дагаж мөрдөх хугацааг тогтоохдоо үүнийг анхаарвал зохино. Түүнчлэн хуулийн төслийг дагалдан гарах холбогдох хуулийн төслүүдийг хамтад боловсруулсан байна.

Төслийн уялдаа холбоог шалгасан тайлан:

№	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.
2	Хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Хуулийн төслийн 2 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль тогтоомж 2.1.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Хэмжил зүйн тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль болон энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. 2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.
4	Хуулийн төслийн зүйл, заалт төслийн бусад заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.

Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх:

№	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Хуулийн төсөлд уг хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан.
2	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Байхгүй.

3	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Хуулийн төслөөр төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зохицуулалт байхгүй.
4	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор дор дурьдсан байдлаар гүйцэтгүүлэхээр хуулийн төсөлд тусгаагүй болно.
5	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Татвар хураамж тогтоосон хэсэг байхгүй.
6	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Хуулийн төслийн “Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл олгох” 17 дугаар зүйлийн 17.1.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 12.12, 12.15-д заасан тусгай зөвшөөрөл, 8.2 дугаар зүйлийн 11.4-г заасан энгийн зөвшөөрлийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 8.1 дүгээр зүйлийн 12.16-д заасан тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газар тус тус олгоно. гэж тусгасан.
7	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Ийм төрлийн зохицуулалт байхгүй. Хуулийн төслийн 2 дугаар зүйл.Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хууль тогтоомж 2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө.
8	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
9	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
10	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй.
11	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Хуулийн төслийн долоодугаар бүлэгт дор дуоьдсан байдлаар тусгасан байна. 24 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага 24.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 24.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

## ТАВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Судлаачийн зүгээс Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэх ажиллагааг хийлээ.

Хуулийн төслийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталгдсан аргачлалд заасан дараах шалгуур үзүүлэлтийг сонгон авч, уг шалгуур үзүүлэлтийг илтгэх зүйл, хэсэг, заалт бүрийг үнэлэв. Үүнд:

- ↓ Зорилгод хүрэх байдал
- ↓ Ойлгомжтой байдал
- ↓ Харилцан уялдаа

---

Хуулийн төсөлтэй холбоотой санал, дүгнэлтийг шалгуур үзүүлэлт бүрийн хэсэгт тодорхой дэлгэрэнгүй бичсэн бөгөөд түүнийг дараах байдлаар хураангуйлан тоймлож байна.

Хуулийн төсөл нь бүхэлдээ мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмжүүлсэн тэжээлийн зөвшөөрөл, бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдаа, хангамж, хэрэглээ, хяналтын үйл ажиллагаа явуулах боломжийг олгоход төрийн шат шатны байгууллагын чиг үүргийг системтэйгээр тусгаж өгсөн гэж үзэж байна.

Түүнчлэн хуулийн төслийг дагалдан гарах шаардлагатай хуулийн төслийг хамтад нь боловсруулсан нь хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхэд ач холбогдолтой байв.

Хуулийн төслийн хэрэгжүүлэхэд бэлтгэл ажил хангах тодорхой цаг хугацаа шаардлагатай байх тул хуулийн төсөлд хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацааны талаарх зохицуулалт тусгах нь зүйтэй байна.

-----o0o-----



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,  
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

# **МАЛ, АМЬТНЫ ЭМ, ТЭЖЭЭЛИЙН НЭМЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО**

**УЛААНБААТАР ХОТ**  
**2024 он**

## **АГУУЛГА**

### **НЭГ. УДИРТГАЛ**

#### **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ҮҮРЭГ, ЗАРДАЛ**

2.1.Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтыг тодорхойлсон нь

2.2. Хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоолол

#### **ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ИРГЭНД ҮҮСЭХ ҮҮРЭГ, ЗАРДАЛ**

3.1.Иргэнд үүрэг хүлээлгэсэн заалтыг тодорхойлсон нь

3.2. Иргэнд үүсэх зардлын тооцоолол

#### **ДӨРӨВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ҮҮРЭГ, ЗАРДАЛ**

4.1.Төрийн байгууллагын үүрэг хүлээсэн заалтыг тодорхойлсон нь

4.2. Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоолол

### **ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ**

## **НЭГ. УДИРТГАЛ**

Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төсөлд тусгасан байдлын дагуу урьдчилан тооцоолж гаргав.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг тандан судлах явцад тус тус гүйцэтгэхийг зорьсон.

Энэ нь тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулсан хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсгэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой байлаа.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл нь шинээр боловсруулж байгаа тул хуулийн төсөл дэх зардал үүсгэх боломжтой зүйл, заалтыг бүхэлд нь авч үзэн зардлыг тус тус тооцсон болно.

## **ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАХИРГААНЫ ЗАРДЛЫГ СТАНДАРТ ЗАРДЛЫН ЗАГВАРААР ТООЦОХ НЬ**

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсч байгаа зардлыг тооцож, түүний үндсэн дээр субъектэд ноогдох зардал, ачааллыг аль болох бага үүсгэх зохицуулалтын хувилбарыг боловсруулахад энэхүү судалгааны зорилго оршино.

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөл нь мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, оношлуур, тэжээлийн нэмэлтийн зөвшөөрөл, бүртгэл, үйлдвэрлэл, баталгаажуулалт, худалдаа, хангамж, хэрэглээ, хяналттай холбогдсон харилцаатай холбогдон гарах мөнгөн зардлыг энэхүү судалгааны тайланд тооцон тусгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсэгт заасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу алхам тус бүрийн хүрээнд мэдээлэл цуглуулан, стандарт үйл ажиллагааны жагсаалтад үндэслэн дараах тооцооллыг хийж, энэ бүлэгт тусгасан болно.

Зардлын тооцоог дараах алхмын хүрээнд хийв. Үүнд:

1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох;
2. Холбогдох зардлуудыг тооцох;
3. Тоон үзүүлэлтийг тооцох;
4. Зардлын дүнг нэгтгэн тооцож гаргах;
5. Хувилбарыг нягталж хялбарчлах боломжийг шалгах;
6. Нэмэлт зардал тооцох.

2.1. Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн заалтуудыг тодорхойлох

Мал, амьтны эм, тэжээлийн нэмэлтийн тухай хуулийн төсөлд хуулийн этгээдэд хамааралтай дараах зохицуулалт байна.

№	Үүрэг	Үүргийг хэрэгжүүлэгч байгууллага	Гүйцэтгэх үүрэг
1	10.5.Хангамжийн байгууллага нь үйлдвэрлэсэн, импортолсон эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн холбогдох баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд зах зээлд нэвтрүүлэхээс нэг сарын өмнө мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэн, бүртгэлийг шинэчлүүлсэн байна.	Эмийн үйлдвэр, Эм ханган нийлүүлэх байгууллага	Үүрэгтэй танилцах, судлах; Мэдээлэл цуглуулах; Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх; Тооцоо хийх; Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах; Алдааг засах; Тоо баримтыг боловсруулах; Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;
2	10.6.Хангамжийн байгууллагын байршил, барилга байгууламж, мэргэжлийн удирдлага, чанарын менежер өөрчлөгдсөн талаарх мэдээллийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр мэдэгдэнэ.	Эмийн үйлдвэр, Эм ханган нийлүүлэх байгууллага	Үүрэгтэй танилцах, судлах; Мэдээлэл цуглуулах; Тоо баримтыг боловсруулах; Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;
3	10.7.Хангамжийн байгууллага нь үйлдвэрлэсэн, импортолсон, нийлүүлсэн мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн бэлдмэлийн жилийн тайланг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн оны 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ.	Эмийн үйлдвэр, Эм ханган нийлүүлэх байгууллага	Үүрэгтэй танилцах, судлах; Мэдээлэл цуглуулах; Тоо баримтыг боловсруулах; Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;
4	13.6.Мал эмнэлгийн байгууллага, эмийн сан нь энэ хуулийн 13.5-д заасан жагсаалтад орсон эм, эмнэлгийн хэрэгслийг тусгай зөвшөөрөл бүхий хүн эмнэлгийн эм хангамжийн байгууллагаас гэрээний үндсэн дээр худалдан авна.	Эмийн үйлдвэр, Эм ханган нийлүүлэх байгууллага	Үүрэгтэй танилцах, судлах; Мэдээлэл цуглуулах; Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх; Тооцоо хийх; Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах; Алдааг засах; Тоо баримтыг боловсруулах; Бусадтай хамтран хийх хуралдаан ;
5	15.2.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг импортлох, экспортлоход мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас энгийн зөвшөөрөл авна.	Эмийн үйлдвэр, Эм ханган нийлүүлэх байгууллага	Үүрэгтэй танилцах, судлах; Мэдээлэл цуглуулах; Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх; Тооцоо хийх; Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах; Алдааг засах; Тоо баримтыг боловсруулах; Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;
6	18.5.Мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, эмжүүлсэн тэжээлийг импортлогч нь гадаад улсын эмийн үйлдвэр, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай, экспортлогч нь худалдан авагч байгууллагатай худалдааны гэрээ байгуулсан байна.	Эмийн үйлдвэр, Эм ханган нийлүүлэх байгууллага	Үүрэгтэй танилцах, судлах; Мэдээлэл цуглуулах; Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх; Тооцоо хийх; Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах; Алдааг засах; Тоо баримтыг боловсруулах; Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;
7			Үүрэгтэй танилцах, судлах; Мэдээлэл цуглуулах;

	16.2.Мал эмнэлгийн байгууллага нь мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт, хэрэглээний тайланг хуульд заасан хугацаанд гарган мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрний захиргааны байгууллагад бичгээр, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.	Эм ханган нийлүүлэх байгууллага	Тоо баримтыг боловсруулах;  Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;
8	17.3.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийг импортлох тусгай зөвшөөрөл олгохдоо Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрний захиргааны байгууллагад хүсэлтийн хамт хүргүүлнэ:	Эмийн үйлдвэр, Эм ханган нийлүүлэх байгууллага	Үүрэгтэй танилцах, судлах;
	17.3.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;		Мэдээлэл цуглуулах;
	17.3.2.гадаад улсын ханган нийлүүлэгч байгууллагатай байгуулсан худалдааны гэрээ, итгэмжлэл, эсхүл албан ёсны төлөөлөл болохыг нотлох баримт;		Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх;
	17.3.3.мал, амьтны эм, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн улсын бүртгэлийн гэрчилгээ;		Тоо баримтыг боловсруулах;
	17.3.4.бүтээгдэхүүний гарал үүсэл, сорилтын дүн, тохирлын гэрчилгээ;		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;
	17.3.5.экспортлогч орны эмийн цувралын чанарын баталгаажилт;		
	17.3.6.эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн олон улсын болон тухайн орны чанар баталгаажилтын болон гарал үүслийн гэрчилгээ, хэрэглэх заавар үйлдвэрлэгч, эсхүл нийлүүлэгчийн олон улсын чанар, стандартын шаардлага хангасан гэрчилгээ.		
9	17.4.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт импортлох, экспортлох энгийн зөвшөөрөл олгохдоо Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрний захиргааны байгууллагад хүсэлтийн хамт хүргүүлнэ:	Эмийн үйлдвэр, Эм ханган нийлүүлэх байгууллага	Үүрэгтэй танилцах, судлах;
	17.4.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;		Мэдээлэл цуглуулах;
	17.4.2.үйлдвэрлэгч болон албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ;		Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх;
	17.4.3.бүтээгдэхүүн нь олон улсын чанарын стандартын шаардлага хангасныг нотлох гэрчилгээ;		Тоо баримтыг боловсруулах;
	17.4.4.импортлох энгийн зөвшөөрлийн хувьд бүтээгдэхүүний хэрэглэх заавар монгол хэл дээрх орчуулгын хамт;		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;
	17.4.5.тухайн бүтээгдэхүүний хүчинтэй байх хугацааны дөрөвний гурав нь дуусаагүй болохыг нотлох баримт.		
	17.4.6.бүтээгдэхүүний нэр, хэлбэр, тун, тоо хэмжээ /баглаа боодол/, үйлдвэрлэгчийн нэр, хилээр нэвтрүүлэх хугацаа, нэвтрүүлэх хилийн боомтын талаарх мэдээлэл;		
	17.4.7.ачаа, тээврийн баримтын гаальд бүртгэгдсэн эх хувь, баглаа, боодлын дэлгэрэнгүй бүртгэл, нэхэмжлэлийн хуулбар, үйлдвэрлэгчээс олгосон сертификат.		
10	17.6.Мал, амьтны эмийн сангйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт хүсэлтийн хамт хүргүүлнэ:	Мал, амьтны эмийн сан	Үүрэгтэй танилцах, судлах;
	17.6.1.эрх бүхий боловсон хүчний чадавхтай болохыг нотолсон баримт бичиг;		Мэдээлэл цуглуулах;

17.6.2.мал, амьтны эмийн сангийн байранд тавих шаардлагыг хангасан болохыг нотолсон баримт бичиг, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;	Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх;
17.6.3.багаж, тоног төхөөрөмжийн стандартын шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;	Тоо баримтыг боловсруулах;
17.6.4.мал, амьтны эм барих итгэмжлэл, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг.	Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;

2.2. Холбогдох зардлуудыг тооцох;

№	Үүрэг	Гүйцэтгэх үүрэг	Хугацаа (мин)
1	10.5.Хангамжийн байгууллага нь үйлдвэрлэсэн, импортолсон эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн холбогдох баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд зах зээлд нэвтрүүлэхээс нэг сарын өмнө мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэн, бүртгэлийг шинэчлүүлсэн байна.	Үүрэгтэй танилцах, судлах;	15
		Мэдээлэл цуглуулах;	15
		Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх;	7
		Тооцоо хийх;	20
		Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах;	5
		Алдааг засах;	10
		Тоо баримтыг боловсруулах;	15
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;	2
2	10.6.Хангамжийн байгууллагын байршил, барилга байгууламж, мэргэжлийн удирдлага, чанарын менежер өөрчлөгдсөн талаарх мэдээллийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр мэдэгдэнэ.	Үүрэгтэй танилцах, судлах;	15
		Мэдээлэл цуглуулах;	15
		Тоо баримтыг боловсруулах;	15
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;	2
3	10.7.Хангамжийн байгууллага нь үйлдвэрлэсэн, импортолсон, нийлүүлсэн мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн бэлдмэлийн жилийн тайланг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн оны 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ.	Үүрэгтэй танилцах, судлах;	15
		Мэдээлэл цуглуулах;	15
		Тоо баримтыг боловсруулах;	7
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;	20
4	13.6.Мал эмнэлгийн байгууллага, эмийн сан нь энэ хуулийн 13.5-д заасан жагсаалтад орсон эм, эмнэлгийн хэрэгслийг тусгай зөвшөөрөл бүхий хүн эмнэлгийн эм хангамжийн байгууллагаас гэрээний үндсэн дээр худалдан авна.	Үүрэгтэй танилцах, судлах;	5
		Мэдээлэл цуглуулах;	10
		Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх;	15
		Тооцоо хийх;	2
		Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах;	15
		Алдааг засах;	15
		Тоо баримтыг боловсруулах;	15
		Бусадтай хамтран хийх хуралдаан ;	2
5	15.2.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийг импортлох, экспортлоход мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас энгийн зөвшөөрөл авна.	Үүрэгтэй танилцах, судлах;	15
		Мэдээлэл цуглуулах;	15
		Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх;	7
		Тооцоо хийх;	20
		Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах;	5
		Алдааг засах;	10
		Тоо баримтыг боловсруулах;	15
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;	480
6	18.5.Мал эмнэлгийн эм, биобэлдмэл, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, эмжүүлсэн тэжээлийг импортлогч нь	Үүрэгтэй танилцах, судлах;	15
		Мэдээлэл цуглуулах;	15

	гадаад улсын эмийн үйлдвэр, эсхүл түүний албан ёсны гэрээт борлуулагчтай, экспортлогч нь худалдан авагч байгууллагатай худалдааны гэрээ байгуулсан байна.	Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх;	7
		Тооцоо хийх;	20
		Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах;	5
		Алдааг засах;	10
		Тоо баримтыг боловсруулах;	15
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;	2
7	16.2.Мал эмнэлгийн байгууллага нь мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт, хэрэглээний тайланг хуульд заасан хугацаанд гарган мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бичгээр, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.	Үүрэгтэй танилцах, судлах;	15
		Мэдээлэл цуглуулах;	15
		Тоо баримтыг боловсруулах;	7
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;	20
	17.3.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийг импортлох тусгай зөвшөөрөл олгохдоо Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлтийн хамт хүргүүлнэ:	Үүрэгтэй танилцах, судлах;	5
	17.3.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;		10
8	17.3.2.гадаад улсын ханган нийлүүлэгч байгууллагатай байгуулсан худалдааны гэрээ, итгэмжлэл, эсхүл албан ёсны төлөөлөл болохыг нотлох баримт;	Мэдээлэл цуглуулах;	15
	17.3.3.мал, амьтны эм, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эмийн улсын бүртгэлийн гэрчилгээ;		2
	17.3.4.бүтээгдэхүүний гарал үүсэл, сорилтын дүн, тохирлын гэрчилгээ;	Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх;	15
	17.3.5.экспортлогч орны эмийн цувралын чанарын баталгаажилт;		
	17.3.6.эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, багаж, тоног төхөөрөмжийн олон улсын болон тухайн орны чанар баталгаажилтын болон гарал үүслийн гэрчилгээ, хэрэглэх заавар үйлдвэрлэгч, эсхүл нийлүүлэгчийн олон улсын чанар, стандартын шаардлага хангасан гэрчилгээ.	Тоо баримтыг боловсруулах;	15
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;	7
	17.4.Мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, мал, амьтныг мэдээ алдуулах, өвдөлт намдаах, тайвшруулах эм, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлт импортлох, экспортлох энгийн зөвшөөрөл олгохдоо Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлтийн хамт хүргүүлнэ:	Үүрэгтэй танилцах, судлах;	5
	17.4.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;		10
9	17.4.2.үйлдвэрлэгч болон албан ёсны гэрээт борлуулагчтай байгуулсан худалдааны гэрээ;	Мэдээлэл цуглуулах;	15
	17.4.3.бүтээгдэхүүн нь олон улсын чанарын стандартын шаардлага хангасныг нотлох гэрчилгээ;		2
	17.4.4.импортлох энгийн зөвшөөрлийн хувьд бүтээгдэхүүний хэрэглэх заавар монгол хэл дээрх орчуулгын хамт;	Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх;	15
	17.4.5.тухайн бүтээгдэхүүний хүчинтэй байх хугацааны дөрөвний гурав нь дуусаагүй болохыг нотлох баримт.		
	17.4.6.бүтээгдэхүүний нэр, хэлбэр, тун, тоо хэмжээ /баглаа боодол/, үйлдвэрлэгчийн нэр, хилээр нэвтрүүлэх хугацаа, нэвтрүүлэх хилийн боомтын талаарх мэдээлэл;	Тоо баримтыг боловсруулах;	15
	17.4.7.ачаа, тээврийн баримтын гаальд бүртгэгдсэн эх хувь, баглаа, боодлын дэлгэрэнгүй бүртгэл, нэхэмжлэлийн хуулбар, үйлдвэрлэгчээс олгосон сертификат.	Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;	7
10	17.6.Мал, амьтны эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохдоо Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна	Үүрэгтэй танилцах, судлах;	15

дараах баримт бичгийг аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт хүсэлтийн хамт хүргүүлнэ:		
17.6.1.эрх бүхий боловсон хүчний чадавхтай болохыг нотолсон баримт бичиг;	Мэдээлэл цуглуулах;	2
17.6.2.мал, амьтны эмийн сангийн байранд тавих шаардлагыг хангасан болохыг нотолсон баримт бичиг, мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;	Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх;	15
17.6.3.багаж, тоног төхөөрөмжийн стандартын шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;	Тоо баримтыг боловсруулах;	15
17.6.4.мал, амьтны эм барих итгэмжлэл, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг.	Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;	7
		1177

Хуулиар хуулийн этгээдэд оногдуулсан дээрх үүрэг бүрийн зардлыг тооцож гаргалаа. Хөдөө аж ахуйн салбарын сарын дундаж цалин 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 1000,000<sup>1</sup> төгрөг гэж тооцоод нэг минутын цалин 96.69 төгрөгөөр тооцлоо.

№	Үүрэг	Гүйцэтгэх үүрэг	Хугацаа (мин)	Зардал (төгрөг)
1	10.5.Хангамжийн байгууллага нь үйлдвэрлэсэн, импортлолсон эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн холбогдох баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд зах зээлд нэвтрүүлэхээс нэг сарын өмнө мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэн, бүртгэлийг шинэчлүүлсэн байна.	Үүрэгтэй танилцах, судлах;	15	1450.35
		Мэдээлэл цуглуулах;	15	1450.35
		Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх;	7	676.83
		Тооцоо хийх;	20	1933.8
		Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах;	5	483.45
		Алдааг засах;	10	966.9
		Тоо баримтыг боловсруулах;	15	1450.35
2	10.6.Хангамжийн байгууллагын байршил, барилга байгууламж, мэргэжлийн удирдлага, чанарын менежер өөрчлөгдсөн талаарх мэдээллийг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухай бүр мэдэгдэнэ.	Үүрэгтэй танилцах, судлах;	15	1450.35
		Мэдээлэл цуглуулах;	15	1450.35
		Тоо баримтыг боловсруулах;	15	1450.35
		Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх;	2	193.38
3	10.7.Хангамжийн байгууллага нь үйлдвэрлэсэн, импортлолсон, нийлүүлсэн мал, амьтны эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн түүхий эд, ариутгал, халдваргүйтгэлийн бэлдмэл, тэжээлийн нэмэлтийн бэлдмэлийн жилийн тайланг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн оны 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ.	Үүрэгтэй танилцах, судлах;	15	1450.35
